

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ШИНЭЖИНСТ СУМЫН НУТАГТ  
БАЙРЛАХ “ЭРДЭНЭ МОНГОЛ” ХХК-ИЙН “БАЯНХӨНДИЙ  
АЛТНЫ ҮНДСЭН ОРДЫГ АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2022 ОНД  
ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-021444/  
/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2718243/

Хянасан:

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны  
ХБОБНУГ-ын мэргэжилтэн:..... /Ч.Жаргалнэмэх/

Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал  
жуулчлалын газрын ахлах мэргэжилтэн:...../Б.Наранбаатар/

Биелэлтийг тайлагнасан:

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн Захиргааны  
ерөнхий захирал:...../Б.Баярмаа/

Байгаль орчны мэргэжилтэн:...../Э.Өнөрзаяа/

2022 он





## АГУУЛГА

<b>ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ</b> .....	<b>4</b>
<b>ЗУРГИЙН ЖАГСААЛТ</b> .....	<b>4</b>
<b>ОРШИЛ</b> .....	<b>6</b>
<b>БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b> .....	<b>8</b>
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл.....	8
1.1.1 Төслийн нэр .....	8
1.1.2 Төсөл хэрэгжүүлэгч .....	8
1.1.3 Төслийн талбайн байршил, хэрэгжих орчны тойм зураг .....	8
1.2 Төслийн зорилго .....	9
1.3 Хүчин чадал, хэрэгжих хугацаа .....	9
1.4 Төслийн талбайн ерөнхий төлөвлөлт .....	9
1.5 Уурхайн ажлын горим .....	10
1.6 Уурхайн ажилчдын хотхон .....	10
1.7 Цахилгаан хангамж .....	11
1.8 Усан хангамж.....	12
1.8.1 Ажилчдын хотхоны усны хэрэгцээ (унд, ахуй) .....	14
1.8.2 Замын тоос дарах усалгаа.....	14
1.8.3 Хайгуулын өрөмдлөгийн усны хэрэглээ.....	14
1.8.4 Байгалийн ургамал үржүүлгийн газар .....	14
1.9 Тээвэрлэлт.....	15
1.9.1 Хүн тээвэр:.....	15
1.9.2 Хүнс тээвэр:.....	16
1.9.3 Дотоод тээвэрлэлт:.....	16
1.10 Уурхайн дулаан хангамж.....	17
<b>БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ</b> .....	<b>18</b>
2.1 Физик газарзүй .....	18
2.2 Уур амьсгал.....	18
2.3 Гадаргын ус.....	18
2.4 Газрын доорх ус.....	18
2.5 Хөрсөн бүрхэвч .....	19
2.6 Ургамлан нөмрөг .....	19
2.7 Амьтны аймаг .....	20
2.8 Нийгэм - Эдийн засаг .....	20
<b>БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ</b> .....	<b>21</b>
<b>БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ</b> .....	<b>24</b>
4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөНИЙ БИЕЛЭЛТ.....	27
4.1.1 Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан .....	41
4.1.2 Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан .....	44
4.1.3 Уур амьсгалд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан .....	45



4.1.4	Агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан .....	46
4.1.5	Гадаргын усанд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан .....	47
4.1.6	Газрын доорх усанд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан .....	47
4.1.7	Ургамлан нөмрөгт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан .....	48
4.1.8	Амьтны аймагт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан .....	49
4.1.9	Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан .....	50
4.1.10	Дуу шуугианд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан .....	51
4.1.11	Нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан .....	51
4.2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт .....	54
4.3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....	59
4.3.1	Биологийн олон янз байдал талаар баримтлах бодлого .....	59
4.3.2	Нөлөөлөлд өртөх болон дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээ .....	65
4.3.3	Дүйцүүлэн хамгаалах газрын санал болгож буй байршлууд .....	66
4.4	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт .....	66
4.5	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....	67
4.6	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....	68
4.7	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт .....	70
4.8	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт .....	75
4.9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт .....	83
4.10	аймаг, нийслэлийн засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ .....	91
4.11	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт .....	93
4.12	2022 оны БОМТ, түүний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт .....	94
<b>БҮЛЭГ 5. ДҮГНЭЛТ .....</b>		<b>96</b>
<b>АШИГЛАСАН МАТЕРИАЛ .....</b>		<b>98</b>
<b>ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ .....</b>		<b>98</b>



## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Хөндий (MV-021444) тусгай зөвшөөрөлтэй талбайн байр зүйн солбицол..9
Хүснэгт 2.	Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн үндсэн барилга байгууламжууд ..... 10
Хүснэгт 3.	Хүрэнцав, Босгын сайр орчмын талбайн газрын доорх усны ордуудын ашиглалтын нөөцийн үйлдвэрлэлийн зэргийн ангилал..... 12
Хүснэгт 4.	Баянхөндий төслийн байгаль орчинд үзүүлж болзошгүй гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл ..... 21
Хүснэгт 5.	Барилгын ажлын төлөвлөлт ..... 24
Хүснэгт 6.	Ус ашиглах зөвшөөрөл ..... 25
Хүснэгт 7.	Байгаль орчны үнэлгээ ..... 25
Хүснэгт 8.	БОМТ-ний хэрэгжилтэд зарцуулсан зардал, 2022 он..... 26
Хүснэгт 9.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .... 27
Хүснэгт 10.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт ..... 55
Хүснэгт 11.	2022 оны тариалалтын мэдээ..... 57
Хүснэгт 12.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ..... 60
Хүснэгт 13.	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт ..... 67
Хүснэгт 14.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт..... 68
Хүснэгт 15.	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ... 69
Хүснэгт 16.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт ..... 70
Хүснэгт 17.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт..... 79
Хүснэгт 18.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт ..... 84
Хүснэгт 19.	Хяналт шалгалтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт... 91
Хүснэгт 20.	Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт..... 93
Хүснэгт 21.	БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь ..... 94
Хүснэгт 22.	БОМТ-ний хэрэгжилтэд зарцуулсан зардал, 2022 он ..... 97

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Баянхөндийн алтны үндсэн ордын талбайн байршлын зураг ..... 8
Зураг 2.	Баянхөндийн хээрийн анги ..... 11
Зураг 3.	Ус хангамжийн худгуудын байршил ..... 13
Зураг 4.	Майхан хүрэн худгийн усны тоолуур ..... 14
Зураг 5.	Байгалийн ургамал үржүүлгийн газар ..... 15
Зураг 6.	Баянхөндий төслийн тээврийн маршрут ..... 16
Зураг 7.	Баянхөндий төслийн дотоод зам ..... 17
Зураг 8.	Шатахуун хадгалах цэг..... 41
Зураг 9.	Хайгуулын цооног өрөмдөх үеийн байдал..... 41
Зураг 10.	Газар хөндөх журам..... 42
Зураг 11.	Аюулгүй ажиллагааны хурал..... 42
Зураг 12.	Хаасан зам..... 43
Зураг 13.	Замын тэмдэг ..... 43
Зураг 14.	Асгаралтад авах хариу арга хэжээний танилцуулга, мэдээллэх хуудас ..... 44
Зураг 15.	Саармагжуулах талбай ..... 44



Зураг 16.	Төслийн замын хөдөлгөөний дүрэм, тээврийн хэрэгслийн үзлэгийн хуудас	45
Зураг 17.	Замын усалгаа	46
Зураг 18.	Dust track TSU	46
Зураг 19.	Ус хэмнэх зөвлөмж	47
Зураг 20.	Шилжүүлэн тариалалтын талбай	48
Зураг 21.	Сайтад ирсэн, явсан бүртгэл	48
Зураг 22.	Амьтны бүртгэл	49
Зураг 23.	Тандан судалгааны хээрийн ажил	49
Зураг 24.	Хулгайн ан хийхгүй байх санамж	50
Зураг 25.	ГИДЦГ-ын “А” хэсгийн мэдээлэл	50
Зураг 26.	Дуу шуугианы нөлөөллийг бууруулахаар засан залруулсан арга хэмжээ	51
Зураг 27.	Ямаа самнахад туслав	51
Зураг 28.	Нутгийн иргэдэд төслийн танилцуулга хийж буй нь	52
Зураг 29.	Амьсгал дахь согтууруулах ундааны илэрц шалгасан хуудас	53
Зураг 30.	Байгалийн ургамал үржүүлгийн газар	57
Зураг 31.	Түүсэн үрийг хадгалсан байдал	58
Зураг 32.	Намрын тариалалт	58
Зураг 33.	Цооног өрөмдөхийн өмнө болон дараа	59
Зураг 34.	Техникийн семинар	64
Зураг 35.	Тэрбум мод хөтөлбөрийн хэрэгжилт	64
Зураг 36.	Тарвага нутагшуулж буй нь	65
Зураг 37.	Кэмийн тохижилт, цэцэрлэгжүүлэлт	67
Зураг 38.	Гал унтраах сургалт, дадлага	74
Зураг 39.	Гал унтраах багаж, хэрэгсэл	74
Зураг 40.	Анхны тусламж үзүүлэх сургалт	75
Зураг 41.	Хог хаягдлыг түр хадгалах цэг	76
Зураг 42.	Хог хаягдлыг түр хадгалах цэг	76
Зураг 43.	Хог хаягдлыг хэрхэн ангилан хаях талаарх сургалт	77
Зураг 44.	Хог хаягдлын нийлүүлэлт	77
Зураг 45.	Нүхэн жорлонгийн шинэчлэл	77
Зураг 46.	Ариутгал халдваргүйжүүлэлт	78
Зураг 47.	Эмнэлгийн хог хаягдал	78



## ОРШИЛ

“Эрдэнэ Монгол” ХХК нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Уртын гол 2-р багийн нутагт “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийг хөгжүүлэх ажлыг хэрэгжүүлж эхлээд байна. Тус компани нь байгаль орчин, нийгмийн хариуцлагын хүрээнд сайн туршлага, менежментийг нэвтрүүлж олон нийтэд нээлттэй, хариуцлагатай уул уурхайн жишиг төсөл болох зорилго тавин ажиллаж байна.

“Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-117 дугаар тушаалын 2-р хавсралтаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ын 4-р хэсэг болох “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”, 2019 оны А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулж, журамд заасан хугацаанд буюу 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр БОАЖЯ-нд хүргүүлсэн. БОАЖЯ-аас Баянхонгор аймгийн орон нутгийн иргэдийн хүсэлтийн дагуу БОАЖЯ, УУХУЯ, АМГТГ, Усны газар, Баянхонгор аймгийн МХГ болон иргэдийн төлөөлөл бүхий ажлын хэсэг 2022 оны 04 дүгээр сарын 07-13-ны өдрүүдэд, Усны газрын шинжээчдийн баг 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр Баянхөндий төслийн талбайд ажиллаж, холбогдох дүгнэлт гарсаны дараагаар төслийн БОМТ-г 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр батласан.

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1 дэх хэсэгт заасны дагуу Усны газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 01/532 дугаартай ус ашиглуулах дүгнэлтийн дагуу 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Алтайн Өвөр Говийн сав газрын захиргаатай Баянхөндий төслийн Ус ашиглах гэрээг байгуулсан.

Баянхөндий төслийн үйл ажиллагаанд коронавирусний цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, хил гаалийн хүндрэл бэрхшээл, нөгөө талаас зарим төрийн бус байгууллага, иргэдийн эсэргүүцэлтэй тулгарч, тэдгээрийг мэдээллээр хангах зэрэг олон хүчин зүйлүүд ихээхэн нөлөөлж, 2022 онд төлөвлөсөн туслах барилгын ажлууд хойшлогдсон бөгөөд БОМТ-г 08 дугаар сараас хойш хэрэгжилтийг эрчимжүүлж ажилласан. Зарим төрийн бус байгууллага, иргэдийн эсэргүүцэл нь 2022 оны 04 дүгээр сарын 09 болон 22, 05 дугаар сарын 7-10, 05 дугаар сарын 26-30, 06 дугаар сарын 10-аас 07 дугаар сарын 07-ны өдөр, 07 дугаар сарын 20-оос 08 дугаар сарын 15-ны өдрүүдэд болсон. Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 29-аас үзнэ үү. Баянхөндий төслийн 2022 онд төлөвлөсөн туслах барилгын ажил дээрх шалтгаануудын улмаас хойшлогдсон тул байгалийн ургамал үржүүлгийн газар байгуулах, кемпийн өргөтгөлийн бэлтгэл, нэмэлт хайгуулын өрөмдлөг, газрын доорх усны ордын гидрогеологийн нэмэлт судалгааны ажил явагдаж байна.

Баянхөндий төслийн хүрээнд 2022 онд барилгын ажил хойшлогдож газар хөндөөгүй боловч БОМТ-ний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дээрх Түймэртийн 1.6 га болон Их Богдын Байгалийн цогцолборт газрын 14 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийж БОМТ-нд тусгасан 6.3 га талбайн хэмжээнээс 2.5 дахин их талбайд нөхөн сэргээлтийн ажлыг хэрэгжүүлсэн.

Энэхүү “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан”-д байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээнд төслийн үйл ажиллагаанаас үүсэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоож, тэдгээр сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ,



болзошгүй эрсдэлээс сэргийлэх арга хэмжээний зэргийг тогтоосны дагуу “Эрдэнэ Монгол” ХХК-ийн “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар 2022 онд авч хэрэгжүүлсэн ажил, зарцуулсан хөрөнгийн хэмжээг тусгав. Төслийн 2022 оны БОМТ-ний хэрэгжилтэд 160 сая төгрөг, Тэрбум мод хөтөлбөрт 40 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд БОМТ-ний хэрэгжилтэд 174 сая төгрөг, Тэрбум мод хөтөлбөрийн хэрэгжилтэд 42.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

## БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1 ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

“Эрдэнэ Монгол” ХХК нь 100% Канад Улсын хөрөнгө оруулалттай компани юм. Канад улсын Торонтогийн Хөрөнгийн Бирж (тэмдэг: ERD), Монгол улсын хөрөнгийн биржид давхар бүртгэлтэй (тэмдэг: ERDN), Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн компани тусгай зөвшөөрлийг эзэмшдэг.

#### 1.1.1 Төслийн нэр

“Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төсөл

#### 1.1.2 Төсөл хэрэгжүүлэгч

Байгууллагын нэр: Гадаадын хөрөнгө оруулалттай “Эрдэнэ Монгол” ХХК

Улсын бүртгэлийн дугар: 9019005124

Регистрийн дугаар: 2718243


Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, ЧД 4-р хороо, Нэгдсэн Үндэстний гудамж 6/6, Монруд ХХК-ийн байр 2 давхар

Утас: +976 11 318532,

Факс: +976 11 315988

#### 1.1.3 Төслийн талбайн байршил, хэрэгжих орчны тойм зураг

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн эзэмшдэг MV-021444 дугаартай “Хөндий” тусгай зөвшөөрлийн талбай нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Уртын гол 2 дугаар багийн нутагт байрладаг. “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн талбай нь Улаанбаатар хотоос 1000 км, Баянхонгор аймгийн төв Баянхонгор хотоос баруун урагш 350 км, Шинэжинст сумын төвөөс баруун урагш 85 км зайтай.



Зураг 1. Баянхөндийн алтны үндсэн ордын талбайн байршлын зураг





Ашигт малтмалын газрын ГУУКХ-ийн даргын шийдвэрээр “Эрдэнэ Монгол” ХХК-д Хөндий нэртэй газар хайгуулын XV-015569 тусгай зөвшөөрөлтэй 19936.34 га талбайг 2010 онд олгож, хайгуулын ажлын явцад “Эрдэнэ Монгол” ХХК-ийн хүсэлтээр 2014 онд 15422.01 га талбайг буцаан, 4514.33 га талбайд хайгуулын ажлыг үргэлжлүүлэн хийж, 2308.62га талбайд ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгосон ба үлдсэн 2205.71га талбайг буцаан өгсөн.

Хөндий талбайд гүйцэтгэсэн нарийвчилсан хайгуулын ажлын үр дүнг 2019 онд ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж нөөцийг батлуулсан бөгөөд “Эрдэнэ Монгол” ХХК-д АМГТГ-ын кадастрын хэлтсийн даргын шийдвэрээр 2019 оны 08 дугаар сарын 05-нд ашигт малтмал ашиглах MV-021444 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий 2308.62 га талбайг 30 жилийн хугацаатай олгосон.

Хүснэгт 1. Хөндий (MV-021444) тусгай зөвшөөрөлтэй талбайн байр зүйн солбицол

Эргэлтийн цэг	Уртраг	Өргөрөг
1	98° 48' 40.00"	43° 53' 50.00"
2	98° 47' 18.81"	43° 53' 50.00"
3	98° 46' 33.93"	43° 57' 36.11"
4	98° 50' 00.34"	43° 57' 36.11"
5	98° 50' 00.34"	43° 55' 30.00"
6	98° 48' 40.00"	43° 55' 30.00"

## 1.2 ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших "Баянхөндий" алтны үндсэн ордыг орчин үеийн шинэ техник, технологид суурилан Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм журам, стандартын дагуу эдийн засгийн өндөр үр ашигтайгаар ашиглах, улс орон нутагт татвар төлбөрүүдийг төлөх, ордын хүрээлэн буй талбайн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх, шинээр ажлын байр бий болгох, ордын үр ашгийг улс, орон нутаг болон төсөл хэрэгжүүлэгч компанид хүртээхэд уг төслийн зорилго оршино.

## 1.3 ХҮЧИН ЧАДАЛ, ХЭРЭГЖИХ ХУГАЦАА

“Эрдэнэ Монгол” ХХК нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт Хөндий нэртэй газар орших Баянхөндийн алтны үндсэн ордоос 5 жилийн хугацаанд гадаад овоолготой, ил аргаар алт олборлоно. Ашиглалтын хугацаанд 40.05 сая тонн хөрс хуулалтын ажил хийж, хаягдал бохирдол тооцоогүй дүнгээр нийт 2.26 сая тонн исэлдсэн хүдэр, 0.51 сая тонн анхдагч хүдэр, 5.32 сая тонн ядуу хүдэр (ядуу хүдэр гэж өнөөгийн эдийн засгийн нөхцөлд үр ашиггүй нөөцийг нэрлэсэн) олборлоно. Баяжуулах үйлдвэр нь жилд 600 мян.тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай бөгөөд нийт 10.3 тн алт ялган авахаар төлөвлөсөн.

## 1.4 ТӨСЛИЙН ТАЛБАЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨЛТ

Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах хугацаанд ил уурхай, гадаад овоолгууд, баяжуулах үйлдвэр, уурхайн ажилчдын хотхон болон засвар, үйлчилгээний барилга



байгууламжууд баригдна. Эдгээр барилга байгууламжуудыг 117.44 га талбайд барихаар зураг төслийг боловсруулсан.

Хүснэгт 2. Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн үндсэн барилга байгууламжууд

#	Барилга байгууламж	Талбай, га	Эзлэхүүн, мян.м <sup>3</sup>
1	Авто зам	20.48	-
2	Авто машины зогсоол	2.52	-
3	Баяжуулах үйлдвэр	2.94	-
4	Дулаан хангамжийн байгууламж	0.50	-
5	Засварын газар	0.22	-
6	Ил уурхай	30.16	-
7	Тэсрэх бодисын агуулах	0.13	-
8	Уурхайн ажилчдын хотхон	1.40	-
9	Уурхайн оффис	0.19	-
10	Халаалтын зуух	0.50	-
11	Хаягдлын нэгдсэн байгууламж	48.02	19,500.0
12	Хаягдлын талбай	5.04	-
13	Хүдрийн овоолгын талбай	2.03	-
14	Шатахуун түгээх станц	0.39	-
15	Шимт хөрсний овоолго	2.92	-
	Нийт	117.44	19,500.0


## 1.5 УУРХАЙН АЖЛЫН ГОРИМ

Уурхайн үйл ажиллагаа нь жилд 350 хоног ажиллаж, 15 хоног нь төлөвлөгөөт бус сул зогсолт байхаар ТЭЗҮ-д тусгагдсан. Уурхай нь хоногт 2 ээлжээр ажиллах ба ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна.

Төслийн барилга, олборлолтын үйл ажиллагаа эхлээгүй байгаа тул ажилчид Хөдөлмөрийн хуулийн дагуу ростероор өдрийн нэг ээлжээр ажиллаж байна.

## 1.6 УУРХАЙН АЖИЛЧДЫН ХОТХОН

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн Баянхөндий хээрийн анги нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Уртын гол 2 дугаар багийн нутаг дэвсгэрт хоногт дунджаар 50 хүнтэй хайгуулын үйл ажиллагаа явуулж байна. Хээрийн ангийн катеринг үйлчилгээг Монруд ХХК, өрөмдлөгийн ажлыг Фалкон дриллинг Монголиа ХХК, харуул хамгаалалтын үйлчилгээг Геомандал секьюрити ХХК, гидрогеологийн судалгааны ажлыг Охь ус ХХК гэрээгээр гүйцэтгэж байна.



Зураг 2. Баянхөндийн хээрийн анги

## 1.7 ЦАХИЛГААН ХАНГАМЖ

Баянхөндий төслийн талбай орчмын нутагт дэд бүтэц сулавтар хөгжсөн. Хамгийн ойрын суурин газар болох Шинэжинст сумын төв нь төвийн эрчим хүчний нэгдсэн системтэй холбогдсонхэдий ч эрчим хүчний хүрэлцээ байдаг тул Баянхөндий хээрийн ангийн цахилгааны эх үүсвэрийг Caterpillar үйлдвэрийн DE450E0 загварын ISO8528 стандартын шаардлага хангасан дизель генератороор хангадаг.



## 1.8 УСАН ХАНГАМЖ


Уурхайн усны хэрэглээг хангах зорилгоор 2019 онд гүйцэтгэсэн газрын доорх усны эрэл-хайгуулын гидрогеологийн судалгааны үр дүнд Хүрэнцавын талбай, Хүрэнцавын зүүн талбай, Шинэ кемпийн талбай гэсэн усжилт өндөртэй 3 талбайг ялгаж газрын доорх усны ашиглалтын нөөцийг үйлдвэрлэлийн С зэргээр 10 л/с хэмжээгээр тогтоосон. Усны газрын 2021 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 158 тоот дүгнэлтэд төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах  $861.58\text{м}^3/\text{хон}$  усыг нийт 10 л/сек буюу  $950.4\text{м}^3/\text{хон}$  газрын доорх усны орд болон шүүрлийн усыг хуримтлуулан хангахад усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй гэж дүгнэсэн.

Газрын доорх усны эрэл-хайгуулын гидрогеологийн судалгааны ажлаар 6 цооног өрөмдөж сорилын шавхалт явуулж, уст үеийн параметруудийг тодорхойлон тухайн цооногт урт хугацааны ашиглалтын үеийн ундаргын нөөцийн тооцоог хийж, усны нөөцийг батлуулсан.

Хүснэгт 3. Хүрэнцав, Босгын сайр орчмын талбайн газрын доорх усны ордуудын ашиглалтын нөөцийн үйлдвэрлэлийн зэргийн ангилал

д/д	Хайгуул-ашиглалтын цооногийн дугаар, худгийн нэр	Газрын доорх усны ашиглалтын боломжит нөөцийн үйлдвэрлэлийн зэрэг	
		С зэрэг	
		л/с	$\text{м}^3/\text{хоног}$
<b>Хүрэнцавын талбай</b>			
1	W-1	3.5	302.4
2	W-2	1.7	146.88
3	W-3	3.9	336.96
	Дүн	9.1	786.24
<b>Хүрэнцавын зүүн талбай</b>			
4	W-4	0.9	77.76
	Дүн	0.9	77.76
	Үйлдвэрийн хэрэгцээнд	10.0	864.0
<b>Шинэ кемпийн талбай</b>			
5	W-5	0.75	64.8
6	W-6	0.25	21.6
	Дүн	1.0	86.4
	Ахуйн хэрэгцээнд	1.0	86.4
	<b>БҮГД ДҮН</b>	11.0	

Компани нь дээрх нөөцийг тогтоох судалгааны үед хийгдсэн шавхалт туршилтын хугацаа бага байсан тул дахин урт хугацаагаар шавхалт туршилтын ажлыг явуулсан. Үүний дагуу ВКW30, ВКW44, ВКW16 цооногуудад урт хугацааны туршилтын шавхалт явуулах ажлын даалгаварыг Усны газраар баталуулан ажиллаж байна. Энэхүү судалгааны ажлын тайланг гүйцэтгэгч компани 2022 оны 12 дугаар сард танилцуулна.



Зураг 3. Ус хангамжийн худгуудын байршил

Усны нэмэлт эрэл хайгуулын ажил 2022 оны 04 дүгээр сараас эхлэн явагдаж байгаа бөгөөд ВКW-46 - ВКW-51 дугаартай 5 цооног өрөмдөж, цооногуудад 5 хоногийн шавхалт туршилтын ажил хийсэн. Усны хайгуулын ажлын үед Усны газар, Алтайн Өвөр говийн сав газрын захиргаанаас хяналтыг тавьсан ба шавхалтын усыг замын усалгаа, хайгуулын өрөмдлөгт эргүүлэн ашигласан. Аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/561 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт ажилласан нутгийн иргэдийн хүсэлт, шаардлагын дагуу шавхалтын ажлын явцад усыг цооногоос



500м зайтай хөрсөнд нэвчүүлсэн ба зэрлэг амьтдын усан хангамжийг нэмэгдүүлэх түр хөв байгуулсан.

Төслийн ахуйн хэрэглээний ус авч ашигладаг Майхан хүрэнгийн урд худагт 2022 онд усны тоолуурыг суурилуулж, Баянхонгор аймгийн Шинэжинст сумын байгаль орчны хяналтын улсын байцаагчаар лац ломбо тавиулж хэрэглэж байна.



Зураг 4. Майхан хүрэн худгийн усны тоолуур

### 1.8.1 Ажилчдын хотхоны усны хэрэгцээ (унд, ахуй)

Баянхөндий хээрийн ангид төсөл хөгжүүлэлтийн үйл явцтай холбоотойгоор хоногт дунджаар 50 ажилтантай ажиллаж байна. Ажилчдын хотхоны ахуйн усны хэрэгцээнд хоногт дунджаар 4 м<sup>3</sup>, ажиллах хугацаанд 1640.9 м<sup>3</sup> ус хэрэглэсэн.

### 1.8.2 Замын тоос дарах усалгаа

Зам, талбайн тоос дарахад шавхалтын ажил хийгдаж байх үед шавхалтаас гарч байгаа ус, шавхалт зогссон үед Уртын гол худгаас, өрөмдлөгт хэрэглэсэн усыг эргүүлэн ашигласан. Усалгааг 6 тн багтаамжтай камаз маркын автомашинаар өдрийн цагаар хийж, хоногт дунджаар 1.5 км зам, талбай усалж, 2946 м<sup>3</sup> усыг нөхөн сэлбэлтээр авч, 1777.4 м<sup>3</sup> усыг эргүүлэн ашигласан. Зам талбайн усалгаанд зарцуулсан ус нь БОНХАЖ-ын Сайдын А/301 дугаар тушаалын “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-оос 1.1 дахин бага байна.

### 1.8.3 Хайгуулын өрөмдлөгийн усны хэрэглээ

Хөндий талбайд хайгуулын өрөмдлөгийн ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж энэ онд 3029 т.м өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэж, өрөмдлөгт хэрэглэж байгаа усыг хэмнэлттэй хэрэглэх зорилгоор эргүүлэн ашигласан ба 230.2 м<sup>3</sup> усыг нөхөн сэлбэлтээр авч, 115.1 м<sup>3</sup> усыг эргүүлэн ашиглаж нийт 345.3 м<sup>3</sup> ус хэрэглэсэн.

### 1.8.4 Байгалийн ургамал үржүүлгийн газар

Байгалийн ургамал үржүүлгийн газрыг 2 га талбайд байгуулан 6 хүлэмж барьж, ургамал шилжүүлэн тарих, бойжуулалтын 9 талбайг бэлтгэсэн ба 20 тн багтаамжтай 2 контайнер, оффисын зорилгоор 1 гэр, ажилчдын амрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор 2 сүүдрэвч

хийсэн ба 5 тн багтаамжтай нөөцийн сав 5 ш байршуулж, хоёрдугаар хүлэмжинд дуслын усалгааны систем суурьлуулсан.

Хаврын тариалалтаар үрээр заг, хайлаас, шар хотир, лидэр, тоорой, жигд мөчрөөр сухай, суулгацаар улиас, бургас нийт 18810 ш тарьц суулгацыг 90% амьдралттай, намрын тариалтаар Говийн их ДЦГ-ын “А” хэсгийн хамгаалалтын захиргаатай байгуулсан санамж бичигт заасны дагуу тус захиргааны мод үржүүлгийн газрын үйл ажиллагааг дэмжих заалтын дагуу жигд 100 ш, тоорой 100 ш, саваа улиас 150 ш, бургас 50 ш, сухай 2300 ш суулгац худалдан авч, тариалсан ба усалгаанд 3255.8 м<sup>3</sup> ус хэрэглэсэн.



Зураг 5. Байгалийн ургамал үржүүлгийн газар

## 1.9 ТЭЭВЭРЛЭЛТ

Улаанбаатар хотоос төслийн талбай хооронд төслийн тээвэрлэлтийн үйл ажиллагаа хүн тээвэр (977 км), хүнс тээвэр (947 км), ачаа тээвэр (975 км) гэсэн 3 маршрутаар хийгдэнэ. Орон нутаг (сум)-тай зөвшилцөж тээврийн замын маршрутыг сонгосон.

Төслийн талбай хүртэл хүн тээврийг суудлын автомашинаар 1-2 машин долоо хоногт 1 удаа, хүнс тээврийг 10тн хүртэлх багтаамжтай ачааны автомашинаар 14 хоногт 1 удаа зорчиж байна.

### 1.9.1 Хүн тээвэр


Баян Хөндийн алтны үндсэн ордыг ашиглах төсөл хэрэгжсэнээр нийт 359 ажлын байр бий болно. Үүнээс 70-80 хувийг орон нутгийн иргэдээс ажиллуулна. Үүнтэй холбоотой хүн тээврийн хэрэгслүүд Улаанбаатараас Баянхонгор хотын төв хүртэл хатуу хучилттай замаар (640 км), Баянхонгороос Шинэжинст сумын төв хүртэл хатуу хучилттай замаар



(38 км), сайжруулсан шороон замаар (217 км), Шинэжинст сумаас төслийн талбай хүртэл 85 км шороон зам ашиглана.

### 1.9.2 Хүнс тээвэр

Хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэлтийн үед түргэн муудах эрсдэлтэй тул хүнс тээврийн тээврийн хэрэгслүүд хамгийн дөт замаар буюу Улаанбаатараас Арвайхаар хотын төв хүртэл хатуу хучилттай замаар (435 км), Арвайхээрээс Нарийнтээл хүртэл хатуу хучилттай замаар (160 км), Нарийнтээлээс Шинэжинст сумын төв хүртэл сайжруулсан шороон замаар 267 км, Шинэжинст сумаас төслийн талбай хүртэл 85 км шороон зам ашиглан тээвэрлэнэ.




Зураг 6. Баянхөндий төслийн тээврийн маршрут

### 1.9.3 Дотоод тээвэрлэлт

Олон салаа зам гаргах, замыг өргөсгөхөөс сэргийлэн төслийн талбай дотор зорчих дотоод замын маршрутыг 2022 онд батлуулан, мөрдөж байна. Мөн Шинэжинст сумаас төслийн талбай хүртэлх нийтийн зам дагуу аюулгүй нөхцлийг сайжруулахад 1200 ширхэг гэрэл ойлгогч бүхий замын шонг байршуулсан.





Зураг 7. Баянхөндий төслийн дотоод зам

## 1.10 УУРХАЙН ДУЛААН ХАНГАМЖ

Хээрийн ангийн гэрүүдийг нүүрсэн галлагаатай зуухаар, оффис, амралтын танхим, гал тогоо, ангор, бие засах газар, анхны тусламжийн төвийг тениэр халаадаг. Нүүрсийг орон нутгийн худалдан авалтыг дэмжих зорилгоор Шинэжинст сумын Хотгор дэрсний нүүрсний уурхайгаас авч байна, тайлант онд 2748 кг нүүрс хэрэглэсэн.



## **БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

### **2.1 ФИЗИК ГАЗАРЗҮЙ**

Физик газарзүйн мужлалын хувьд Монгол Алтайн их мужид, газарзүйн хэлбэр гадаргуугийн хэв шинжээр уулс хоорондын хөндийн хэв шинжид багтаан үздэг. Газрын гадаргын хувьд 1850-2010 м өргөгдсөн мөлгөрдүү оройтой намхан толгодтой, эдгээр нь өөр хоорондоо 25-40 метрийн өргөн хуурай сайраар тусгаарлагдсан, элэгдэл хуримтлалын рельеф зонхилно (Ш.Цэгмид 1967 он). Ашиглалтын талбай нь Эдрэнгийн нурууны зүүн төгсгөлд оршино.

### **2.2 УУР АМЬСГАЛ**

Ашиглалтын талбайн нутаг дэвсгэр нь эх газрын говь цөлийн эрс тэс, хахир ширүүн уур амьсгалтай. Агаарын урсгал үүсэхэд уул зүйн нөхцөл болон орон нутгийн бичил салхи нөлөөлж, хур тунадас, чийгшил харьцангуй бага хуурай, хуурайвтар, зундаа халуун дулаан, өвөлдөө хахир хүйтэн нөхцөлтэй бичил бүс нутгийг бүрдүүлдэг. Өвлийн улиралд цас бага ордог бөгөөд агаар нь хуурайвтар, чийг багатай, харин хавар салхи шуурга ихтэй, зарим үед 40 м/сек-ээс их хурдтайгаар шуурдаг. Үнэмлэхүй бага температур нь  $-37.4^{\circ}\text{C}$ , үнэмлэхүй их температур нь  $44.9^{\circ}\text{C}$  хүрдэг бөгөөд үнэмлэхүй их, бага температурын агууриг нь ( $82.3^{\circ}\text{C}$ ) эрс ялгаатай байдаг. Жилийн дундаж температур нь  $0.7^{\circ}\text{C}$ , хамгийн хүйтэн 01 сарын дундаж температур  $-15.5^{\circ}\text{C}$  байхад хамгийн дулаан буюу 07 сарын дундаж температур  $16.8^{\circ}\text{C}$  байдаг.

### **2.3 ГАДАРГЫН УС**

Баянхөндийн тусгай зөвшөөрөлтэй талбай нь Алтайн өвөр говийн сав газарт багтах бөгөөд энэ сав газар дахь ихэнх голдрил нь түр урсацтай, жилийн ихэнх хугацаанд хуурай байдаг. Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн талбайг түр урсацтай, хуурай сайрууд дайран өнгөрөх бөгөөд эдгээр сайрууд зун, намрын эрчимшил ихтэй хур борооны үед түр урсацтай болдог.

### **2.4 ГАЗРЫН ДООРХ УС**

Баянхөндийн талбай нь гидрогеологийн дүүрэгчлэлээр улирлын хомс тэжээлтэй Монголын Өмнөдговийн хэсгийн дэд мужид багтана. Харин төслийн ойр орчмын дэвсгэр талбай нь Монгол орны гидрогеологийн мужлалаар (Н.Жадамбаа ба болон бусад, УБ 1988) хувирмал, терриген, вулканоген чулуулгаас бүрдсэн антиклиналь атираажилтай гидрогеологийн массивт хамаарна. 2016 оны хээрийн судалгаанд 10 худаг тэмдэглэгдэж, 4 худгаас дээжлэлт хийсэн бол 2017 оны судалгаагаар 7 худгаас дээжлэлт, 2019 оны судалгаагаар 7 худгаас дээжлэлт хийсэн. Уг 7 худаг нь тусгай зөвшөөрлийн талбайд болон талбайн хүрэнээс 2-11.6 км зайд оршиж байна.

Усны чанарын 2019, 2022 оны мэдээллээс үзэхэд Майхан хүрэн (хойд, урд), Хүрэн цав, Өргөө, Босго худгуудын усанд кальци, хлор, сульфат, ерөнхий хатуулаг, стронци, Хүрэнцав, Өргөө, Босго, Майхан хүрэнгийн хойд худгуудад магни, Гүн заг худгийн усанд хөнгөн цагаан, Өргөө, Босго худгуудын усанд манган, Хүрэнцав, Майхан



хүрэнгийн хойд, Босго худгуудын усанд никель, Майхан хүрэнгийн хойд худгийн усанд молибден, Хүрэнцав, Гүн заг, Майхан хүрэн хойд, Босго худгуудын усанд хүнцэл, Хүрэнцав, Гүн заг, Майхан хүрэн хойд худгуудын усанд уран, Өргөө худгуудын усанд төмрийн агууламж тус тус Ундны усны стандарт (MNS 0900:2018)-ын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан байна.

Майхан хүрэн (хойд, урд), Хүрэн цав, Өргөө, Босго худгуудын усанд хлор, сульфат, Гүн заг худгийн усанд хөнгөн цагаан, Өргөө, Босго худгуудын усанд манган, Гүн заг, Майхан хүрэн урд, хойд худгуудын усанд молибден, Хүрэнцав, Гүн заг, Майхан хүрэн хойд, Босго худгуудын усанд хүнцэл, Гүн заг, Майхан хүрэн хойд худгуудын усанд уран, Өргөө худгийн усанд төмөр гэсэн элементүүд тус тус Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ (MNS 6148:2010) стандартаас тус тус давсан үзүүлэлттэй байна.

## **2.5 ХӨРСӨН БҮРХЭВЧ**

Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн талбай орчмын бүс нутагт цөлийн бор саарал хөрс зонхилон тархсан. Төслийн талбай орчимд тархсан бор саарал хөрс нь элсэнцэр, хэврэг бүтэцтэй, үржил шим багатай, эмзэг хөрс тархсан.

Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн талбайд ил уурхай, гадаад овоолгууд, баяжуулах үйлдвэр, уурхайн үйлчилгээ, хангамжийн барилга байгууламжуудыг 117.44 га талбайд байгуулахаар төлөвлөсөн. Барилга байгууламжуудыг барихаас өмнө хөндөгдөх талбайн өнгөн хөрсийг хуулж шимт хөрс хадгалах талбайд байршуулна. Нийт хөндөгдөх талбайгаас 0.8 тн ялзмагийн агууламжтай 320.4 мян.м<sup>3</sup> шимт хөрс хуулагдна. Шимт хөрсний овоолгын үржил шимийг тогтвортой байлгах зорилгоор орой болон хажууг ургамжлуулна. Энэхүү шимт хөрсийг уурхайн ашиглалтын хугацаанд болон хаалтын үе шатанд эвдэрсэн газрыг нөхөн сэргээхэд ашиглахаар төлөвлөсөн.

## **2.6 УРГАМЛАН НӨМРӨГ**

Баянхөндий ордын байрлаж буй бүс нутаг нь Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Алтайн өвөр говийн цөлийн тойрог, цөлийн хээрийн бүсэд хамаарагддаг. Ургамалжилтын хувьд сийрэг, чулуут цөлийн хэвшинжид хамаарна. Энэ тойргийг ургамлын зүйлийн бүрдлийн хувьд их ядраг боловч Алашаа говиос арай илүү гэж үздэг. Тус ордын талбайд гүйцэтгэсэн 3 удаагийн хээрийн судалгаагаар 57 зүйл ургамал тэмдэглэгдсэн бөгөөд ургамлын зүйлийн бүрдэлд сөөг, сөөгөнцөр (бүйлс, зээргэнэ, хармаг, хотир, бударгана, ортууз гэх мэт) зонхилсон. Мөн 2 зүйлийн мод (сухай, заг), 1 зүйлийн хагас шимэгч (Цөлийн аргамжин цэцэг буюу цагаан гоёо) болон олон наст өвслөг ургамлууд ургадаг. Үүнээс гадна тухайн жилийн хур тундасны хэмжээнээс хамааран ургадаг эсвэл өнждөг нэг наст ургамлууд тохиолдоно.

Тусгай зөвшөөрлийн талбайд хийгдсэн байгаль орчны судалгаануудаар 57 зүйл ургамлаас нэн ховор 3 зүйл (Регелийн будраа, Толбот бэрээмэг, Потанины Хотир), ховор 2 зүйл (Монгол бүйлс, Өргөст ортууз) бүртгэгдсэн. Харин цөлийн аргамжин цэцэг буюу цагаан гоёо Майхан хүрэнгийн худгаас Цэнхэр Номин орох зам дагуу загийн ёроолоор шимэгчлэн ургадаг.



## **2.7 АМЬТНЫ АЙМАГ**

Баянхөндий төслийн талбай нь бүхэлдээ ГИДЦГ-ын А хэсгийн Орчны бүсэд хамаарагдах тул нэн ховор, ховор зэрлэг амьтад, шувуудын байршил нутагтай давхцахаас гадна 10-20 км-ийн ойр байрладаг. Тусгай зөвшөөрлийн талбайн ойр орчимд хөхтөн амьтдаас хар сүүлт, махчдаас чоно, үнэг шавж идэштнээс зараа, мэрэгчдээс алаг даага, шар чичүүл, бор шигшүүхэй жигүүртнээс цэгцгий, сар, хэрээ, хулан жороо, тас, цөлийн чогчиго мөлхөгчдөөс хонин ба нохой гүрвэл, сум могой тархсан.

## **2.8 НИЙГЭМ - ЭДИЙН ЗАСАГ**

Төслийн талбай нь манай орны дэд бүтэц сул хөгжсөн бүс нутагт байрлана. Хүн амын суурьшил маш багатай. Гол төлөв Халх ястан амьдардаг бөгөөд сумын хүн амын 90 орчим хувь нь мал аж ахуй эрхэлдэг. Хөндий талбай нь Шинэжинст, Баян-Өндөр сумдаас 130 орчим км зайтай оршино. Хамгийн ойр орших Шинэжинст сум нь талбайгаас 85 км-т байдаг бөгөөд энэ сум нь 2015 онд төвийн нэгдсэн цахилгаан сүлжээнд холбогдсон. Хүн эмнэлэг, холбооны салбартай, 9 жилийн дунд сургууль, ШТС-тай. Тээврийн үндсэн төрөл нь автомашин бөгөөд харилцдаг бүх газруудтайгаа шороон замаар холбогдоно.



### БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн MV-02144 тусгай зөвшөөрөлтэй Хөндий талбайн “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн барилгын үе шатны үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчин, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй сөрөг нөлөөллийн хураангуйг доорх хүснэгтэд тоймлон үзүүлэв.

Хүснэгт 4. Баянхөндий төслийн байгаль орчинд үзүүлж болзошгүй гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Сөрөг нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр				
	Барилгажилтын үе шат				
	Барилга байгууламж барих талбайн хөрс хуулагт	Зам ашиглалт/Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн	Барилгын материал тээвэрлэх, хадгалах, ашиглах	Барилга байгууламж, гур суурин барих	Хог хаягдал цуглуулах, устгах талбай байгуулах
<b>Газрын гадарга, хэвлий</b>					
<b>Гол сөрөг нөлөөлөл</b>					
Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд 117.44 га газрын гадарга эвдрэлд орж, гадаргын хэлбэр дүрс өөрчлөгдөх, байгалийн үзэмжийг доройтуулах	Т	Т	Т	Т	У
<b>Болзошгүй сөрөг нөлөөлөл</b>					
Уурхайн ажилчдын хотхоноос гарсан хог хаягдал, уурхайн бусад барилга байгууламжуудын хатуу хог хаягдлын менежментийг хангалтгүй хийснээр тухайн орчны газрын гадаргыг бохирдуулах					У
<b>Уур амьсгал</b>					
<b>Гол сөрөг нөлөөлөл</b>					
Энэ төслийн үйл ажиллагаанд ашиглах хөдөлгөөнт, суурин техник хэрэгслүүдээс жилд хамгийн ихдээ 61,599 тн нүүрсхүчлийн хий ялгарч агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг дээр дурдсан хэмжээгээр нэмэгдүүлнэ.		Д			
<b>Агаарын чанар</b>					
<b>Гол сөрөг нөлөөлөл</b>					
108.83 га эвдэгдсэн талбайгаас цагт 39.24 кг тоос дэгдэн агаарын чанарт нөлөөлнө. Ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө.		Б			
Тээврийн хэрэгслүүд болон дизель цахилгаан генераторуудаас жилд 61599 тн нүүрстөрөгчийн хий ялгарна.		Б			
<b>Гадаргын ус</b>					
<b>Гол сөрөг нөлөөлөл</b>					



Ил уурхай, хүдрийн овоолго, авто зам байгуулснаар Хүрэн цавын сайрын голдирол өөрчлөгдөх				Б	
Шимт хөрсний овоолго, авто зам, автомашины зогсоол, ШТС, дулаан хангамжийн байгууламж, хаягдлын нэгдсэн байгууламж, хаягдлын талбайг байгуулснаар сайрын голдирол өөрчлөгдөх				Б	
<b>Газрын доорх ус</b>					
<b>Гол сөрөг нөлөөлөл</b>					
Газрын доорх усны тэжээмжийн талбай багасах				Б	
<b>Болзошгүй сөрөг нөлөөлөл</b>					
Химийн бодисоор бохирдсон ус асгарч алдагдаж болзошгүй;			б		
ШТМ асгаралт бий болж болзошгүй.		б			
<b>Хөрсөн бүрхэвч</b>					
<b>Гол сөрөг нөлөөлөл</b>					
Ил уурхайг ашиглах, барилга байгууламжуудыг барих явцад хөндөгдөх 117.44 га талбайгаас 0.8 тн ялзмагийн нөөц бүхий 320.4 мян.м3 шимт хөрс хуулагдана.	У			Д	
<b>Болзошгүй сөрөг нөлөөлөл</b>					
ШТМ алдагдсан тохиолдолд хөрсөн бүрхэвч бохирдох		Д			
Ашиглалт дууссан аккумуляторын шингэн, баяжуулах үйлдвэрт ашиглаж буй химийн бодис гоожиж, асгарсан тохиолдолд хөрсөн бүрхэвч бохирдож болзошгүй.					Б
<b>Ургамлан нөмрөг</b>					
<b>Гол сөрөг нөлөөлөл</b>					
Барилгажилтын үе шатанд уурхайн овоолго, зам бусад дэд бүтцийн барилга байгууламжийг байгуулах 39.26 га талбайгаас 4 хэвшинжийн ургамлан нөмрөг өнгөн хөрстэй хамт хуулагдана	б	б	б	б	
<b>Болзошгүй сөрөг нөлөөлөл</b>					
Барилгажилтын үеийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, газар хөндөх үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтын улмаас ургамлын фотосинтезийн эрчим ургалтын хугацаанд буурч, ургамлан нөмрөг доройтох	б	б	б	б	
Ашиглалтын үед ил уурхай, хөрсний овоолгуудаас салхиар, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр замаас үүсэх тоосжилтын улмаас ургамлан нөмрөгийн фотосинтезийн эрчим ургалтын хугацаанд буурснаар, ургамлын биомасс багасах					У
<b>Амьтны аймаг</b>					
<b>Болзошгүй сөрөг нөлөөлөл</b>					
Барилгын газар шорооны ажлын үед шувуудын үүр устах, тэр дундаа Жороо тоодог ( <i>Chlamydotis undulata</i> ), Хулан жороо ( <i>Podoces hendersoni</i> )	б	б	б	б	
Барилгын ажилтнууд хууль бус ан хийх		б	б	б	
Уурхайн бүхий л үйл ажиллагаанаас зэрлэг амьтад тэр дундаа нүүдлийн том туруутан амьтад (хар сүүлт зээр) дайжсанаар амьдрах орчноо шууд бусаар алдах		б	б	б	
<b>Тусгай хамгаалалттай газар нутаг</b>					
<b>Болзошгүй сөрөг нөлөөлөл</b>					



Хүн амын суурьшил нэмэгдэх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, тэсэлгээ хийх зэргээс тухайн орчны дуу шуугиан нэмэгдэн улмаар Говийн их ДЦГ-ын А хэсгийн орчны бүсэд тархан амьдрах амьтад үргэж дайжих		б			
<b>Дуу шуугиан, доргион чичиргээ</b>					
<b>Гол сөрөг нөлөөлөл</b>					
Төслийн талбайд ажиллах техник хэрэгслүүдээс дуу шуугиан үүсэж, уурхайн 359 ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө.		б			
<b>Нийгэм эдийн засаг</b>					
<b>Болзошгүй сөрөг нөлөөлөл</b>					
Баянхөндийн алтны үндсэн ордын ашиглах бүх үе шатанд барилгын материал, хүнс, хүн тээвэрлэх маршрутаар тээврийн хэрэгслүүд зорчих явцад үүссэн тоосжилт, дуу шуугианаас ойролцоо нутаглаж буй малчдад тавгүй байдал үүсэх, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй.		Т			

**Нөлөөллийн эрчим**

	Их
	Дунд
	Бага

**Нөлөөллийн үргэлжлэх хугацаа**

Т	Түр зуурын	1 сар хүртэл
б	Богино	сар хүртэл
Д	Дунд	1-3 жил хүртэл
У	Урт	Төслийн үйл ажиллагаа дуусах хүртэл
Б	Байнгын	Хаалтын дараа ч үргэлжлэх



## БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

**Зорилго, зорилт:** “Эрдэнэ Монгол” ХХК-ийн “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа 2021 онд “Эко трейд” ХХК-ний боловсруулсан “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх үүрэг, амлалтаас гадна Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29–ний өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” зэргийг мөрдлөг болгон боловсруулсан бөгөөд энэ төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэхийг гол зорилго болгосон.

**Баримтлах зарчим:** Төсөл хэрэгжүүлэгч “Эрдэнэ Монгол” ХХК нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, БОАЖЯ-ны тусгай дансанд төслийн үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ. Хэрвээ “Эрдэнэ Монгол” ХХК байгаль хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ хангалттай биелүүлж, жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг биелүүлсэн бол Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3-т заасан хаалтын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн явцыг үндэслэн мөн хуулийн 9.10-т зааснаар хуримтлагдсан хөрөнгийг тодорхой хуваарийн дагуу буцаан олгохоор зохицуулагдсан.

**Хамрах хүрээ:** “Эрдэнэ Монгол” ХХК-ийн MV-02144 “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн талбайд 2022 онд дараах барилгуудыг барьж, 268,178 м<sup>3</sup> хөрс хуулалтын ажил, 25000 т.м өрөмдлөг, 2000 м суваг нэвтрэлт, 7900 ш геохимийн дээж авахаар төлөвлөсөн. Үүнд:

Хүснэгт 5. Барилгын ажлын төлөвлөлт

#	Барилга байгууламж	Талбай, га	Эзлэхүүн, мян.м <sup>3</sup>	Улсын бүртгэлийн дугаар	Талбайн хэмжээ, м.кв
1	Авто зам	20.48			
2	Цэвэр ус дамжуулах хоолой			А-031900024	46247
3	Авто машины зогсоол				
4	Машин механизмын засварын талбай	2.74		А-031900003	4184
5	Баяжуулах үйлдвэр	2.94		А-031900011	12530
6	Дулаан хангамж	0.50		А-031900008	5169
7	Тэсрэх бодисын агуулах	0.13		А-031900022	6539
8	Химийн бодисын агуулах	0,16		А-031900004	1638
9	Агуулах	588		А-031900016	1012





10	Уурхайн ажилчдын хотхон	1.40		A-031900012	22341
11	Цэвэрлэх байгууламж			A-031900010	3500
12	Худаг			A-031900007	154
13	Хогийн цэг			A-031900019	7200
14	Уурхайн оффис	0.19		A-031900014	1134
15	Уурхайн байгууламж			A-031900018	1776
16	Лаборатори			A-031900017	2978
17	Харуулын байр			A-031900005	458
18	Хаягдлын нэгдсэн байгууламж	48.02	19,500.0	A-031900021	570471
19	Хаягдлын талбай	5.04		A-031900014	7200
20	Цахилгаан станц			A-031900015	6264
21	Шатахуун түгээх станц	0.39		A-031900009	3233
22	Хөрсний овоолго	3.48	268,178	A-031900020	22041
23	Мод үржүүлгийн газар	2		A-031900013	20000
Нийт		<b>87.31</b>			<b>746069</b>

Төслийн 2022 онд төлөвлөсөн туслах барилгын ажлууд хойшилж, харин төлөвлөгөөнд тусгагдсан 3029 т.м өрөмдлөг, 457 ш геохимийн дээж авсан ба 2 га талбайд байгалийн ургамал үржүүлгийн газар байгуулах ажил хийгдсэн.

**Холбогдох зөвшөөрлүүд:**

Хүснэгт 6. Ус ашиглах зөвшөөрөл

Д/д	Зөвшөөрөл	Огноо, дугаар	Хүчинтэй хугацаа
1	Ашиглах боломжит нөөцийн дүгнэлт	Усны газар 2020.09.23 №158	-
2	Ус ашиглуулах дүгнэлт	Усны газар 2022.05.11 №85	2022.12.30
3	Ус ашиглуулах зөвшөөрөл	АӨГСГЗахиргааны даргын тушаал 2022.05.20 А/17	2022.12.30
4	Ус ашиглах гэрээ	АӨГСГЗахиргаа 2022.05.24 №22/03	2022.12.31
5	Шинэжинст сумын Засаг даргын захирамж “Эрдэнэ Монгол ХХК-д газар ашиглуулах” тухай	2022.02.08 А/17	5 жил

**Байгаль орчны үнэлгээ:**

Хүснэгт 7. Байгаль орчны үнэлгээ

Д/д	Үнэлгээний нэр	Батлагдсан он
1	Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ – Эко трейд ХХК	2017
2	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ – Састэйнабилити Ийст Эйжия ХХК	2020
3	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ - “Эко трейд” ХХК	2021

Бид хайгуулын үе шатнаас эхлэн байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсны дагуу хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн холбогдох дүрэм, журмуудыг баримтлан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллийг



бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилгоо биелүүлж, менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн орон нутгийн хамтын ажиллагааг хангаж ажилласаар ирсэн.

### **Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хураангуй**

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөлөл, түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ, сөрөг нөлөөллийн хамрах хүрээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт болон шаардагдах хөрөнгө зардлыг, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, хяналт шинжилгээ хийх цэгийн байршил, хугацаа ба давтамж, баримтлах стандарт, арга аргачлал болон шаардагдах зардал зэргийг тодорхойлон тусгасан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 160.8 сая төгрөг төлөвлөж 174.2 сая төгрөг, Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөнд 40 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, 42.2 сая төгрөгийг зарцуулсан. Төслийн БОМТ хэрэгжүүлэхэд зарцуулсан зардлуудын хураангуйг доор харуулав.

#### Хүснэгт 8. БОМТ-ний хэрэгжилтэд зарцуулсан зардал, 2022 он

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зардал, төг.	
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөө	15 сая	
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	13.5 сая	
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт	58 сая
		Тандан судалгаа	9 сая
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-	
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-	
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	Үйл ажиллагааны зардал	
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	17 сая	
8	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	59.7 сая	
9	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах	2 сая	
Нийт дүн		174.2 сая	
“Тэрбум мод тарих” үндэсний хөдөлгөөн		42.2 сая	



#### 4.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчноор буюу агаарын чанар, хөрсөнд, усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, амьтан, ургамлын аймагт үзүүлж болзошгүй нөлөөллийг бууруулах, арилгах зэрэг чиглэлүүдээр хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Баримтласан эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (сая төгрөг)
<b>НЭГ. ГАЗРЫН ГАДАРГА, ХЭВЛИЙД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР</b>				
Барилга байгууламжууд барих, хөрс хуулалт хийх, уурхайн доторх зам 85.81га талбайн газрын гадарга, хэвлий эвдэгдэх, доройтох, нөлөөлөлд өртөх	Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө Газар хөндөх зөвшөөрөл (ГХЗ) Газарзүйн мэдээллийн систем (ГМС)-д бүртгэл хөтлөх	MNS 5917:2008 "Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, MNS 5916:2008 "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт, “Эрдэнэ” - ийн бодлого журмын гарын авлага	Төслийн талбайд 2022 онд 23 туслах барилгын 85.8 га талбайд газар хөндөх ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч орон нутгийн иргэдийн удаа дараагийн хууль бус эсэргүүцэлийн улмаас барилгын ажлууд хойшлогдсон. 2022 онд кэмгийн өргөтгөлтэй холбоотойгоор шатахуун хадгалах цэг байгуулах ажил хийгдсэн. Энэ шатахуун хадгалах цэг байгуулахаас өмнө газар хөндөх зөвшөөрлийг журмын дагуу олгож, явцын хяналтыг тогтмол тавьж ажилласан ба газар хөндөлт дуусахад олгосон зөвшөөрлийг хаасан. Газар хөндөх зөвшөөрлийн бичгийг 2022 оноос батлан мөрдүүлж, тухай бүрд бүртгэн ГМС-д бүртгэл хөтлөн ажиллаж байна. Хавсралт 6. Газар хөндөх зөвшөөрөл авсан ГМС-ийн бүртгэл Хайгуулын цооног хэдэн цооног өрөмдсөн тухай бүрт техникийн нөхөн сэргээлтийг Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS 5917:2008 стандартын дагуу гүйцэтгэсэн. Сумын газрын даамалтай нийт 36 газар ашиглах гэрээ байгуулж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж аилласан. Газрын төлбөрийг бүрэн төлж, гэрээнүүдийг 09 дүгээр сарын 20-нд дүгнүүлсэн.	-
	Үйл ажиллагааны багуудад газар хөндөх зөвшөөрөл, ховор ургамал хамгаалал,		Газар хөндөх журам болон Ховор ургамал хамгаалал, нөхөн сэргээлттэй холбоотой мэдээллийн Биологийн төрөл зүйлийн сургалтын материалд тусган боловсруулж, туслан гүйцэтгэгч 3 аж	-



нөхөн сэргээлттэй холбоотой сургалт орох		ахуйн нэгжүүдийн ахлах ажилтан болон гардан гүйцэтгэгч нарт 2 удаа танилцуулсан. Төслийн талбайн “Ерөнхий зааварчилаа болон Аюулгүй ажиллагааны хурлын үеэр дээр байгаль орчныг хамгаалах,, ховор ургамалын хамгаалал, нөхөн сэргээлттэй холбоотой мэдээллийг тогтмол өгч ажилладаг. Хавсралт 7. Газар хөндөх журам. Хавсралт 8. Биологийн төрөл зүйлийн сургалтын материал.	
Говийн Их ДЦГазрын “А” хэсгийн хамгаалалтын захиргаанаас “Тусгай хамгаалалттай газар нутаг, хамгаалалтын захиргаанаас хэрэгжүүлж байгаа ажлын тухай” мэдээллийг 2022 оны 04 дүгээр сарын 13-ний өдөр болон 10 сарын 09-ний өдөр өгсөн.




Зураг 25. ГИДЦГ-ын “А” хэсгийн мэдээлэл



#### 4.1.10 Дуу шуугианд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан

Төслийн талбайд хамгийн их дуу чимээ гаргаж байгаа генераторын болон хөрөөний өрөөнд дуу чимээний хэмжилтийг 2022 оны 06 сард хийхэд генераторын өрөөнд 93.1 dBA байсан тул генераторын өрөөнд зөвхөн зөвшөөрөгдсөн хүн нэвтрэх, ажилтан чихний бөлгөөг тогтмол хэрэглэх санамжийг байршуулсан.

DATE RAISED	LOCATION	PHOTO	ISSUE DESCRIPTION	CORRECTIVE ACTION	STATUS	PRIORITY	RESPONSIBLE	EXPECTED DATE	COMPLETION DATE / PHOTO
2022.06.20	Camp Generator room		Генераторын өрөөнд гэрээ их өндөр давтамжийн чимээтэй 93.1дБ байна. High decibels of sound at the generator room over 93.1dB.	Генераторын өрөөнд нэвтрэх ажиллах ажилтан чихний бөлгөөг тогтмол хэрэглэх байх. Зөвхөн зөвшөөрөгдсөн хүн нэвтрэх. Ear plugs must be worn before accessing to the generator room. Only authorized person can enter.	CLOSED	High	Safety officer /Tuvshimbaya / Camp manager /Khairat/	20 JUNE 2022	 21 JUNE 2022

Зураг 26. Дуу шуугианы нөлөөллийг бууруулахаар засан залруулсан арга хэмжээ

#### 4.1.11 Нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан

Төслийн хүчин чадалд үндэслэн Шинэжинст, Баян-Өндөр сумдын иргэдийн хамгийн түрүүнд ажилд оруулах компанийн бодлогын дагуу Эрдэнэ Монгол ХХК болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд 75 иргэнийг ажиллуулж байна.

Энэ онд иргэдээс 110 санал, гомдол ирснээс 75 нь ажилд орохыг хүссэн үлдсэн нь төслийн үйл ажиллагаатай холбоотой байгаагаас 25-ыг шийдвэрлэсэн, 10 нь шийдвэрлэх шатанд явж байна.

Тусгай зөвшөөрлийн талбайн ойр орчмын хүн хүч дутмаг малчин айл өрхүүдэд туслах зорилгоор 05 сард Уртын гол 2-р багийн засаг дарга М.Болдцэрэнгийн гаргаж ирүүлсэн 11 өрхөөс С.Батаа, Т.Алтангэрэл нар бидний саналаас татгалзаж, С.Бямбасүрэн, Ц.Мөнхдалай нар ямаагаа самнаж дууссан. Батхуягийнх хүсэлт гарган, нэмэгдэж нийт 8 өрхөд 602 ямаа самнаж тусалсан. Орон нутгийн багийн энэ ажил нь малчидтай харилцах харилцаанд ахиц, үр дүн гаргасан, тэдэнд эерэг сэтгэгдэл үлдээсэн маш чухал ажил болсон гэж дүгнэн, жил бүр хүн хүч нэмэгдүүлж илүү олон айлд туслахаар хүртээмжтэй байдлаар уламжлал болгон зохион байгуулах шаардлагатай гэж үзсэн.



Зураг 27. Ямаа самнахад туслав

Компанийн төлөөлөгчид давхардсан тоогоор Шинэжинст сумын 60 өрхөөр зочилж, төслийн талаарх мэдээллийг өгч, иргэдийн санал гомдол, хүсэлтийг хүлээн авч ажилласны 55 өрх нь Уртын гол багийн өрх байсан.



Зураг 28. Нутгийн иргэдэд төслийн танилцуулга хийж буй нь

Баянхөндий алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах төсөлд ажилд орохоор Шинэжинст сумаас ажилд орохоор 321, Баянхонгор аймгаас 85 нийт 406 иргэн бүртгүүлсэн. Энэ онд Эрдэнэ Монгол ХХК-д 32, Эрдэнэ Монгол ХХК-ийн туслан гүйцэтгэгч Фалкон дриллинг Монголиа ХХК-д 11, Геомандал секьюрити ХХК-д 17, Монруд ХХК-д 15 иргэн ажиллаж байна.

Шинэжинст сумын 4 иргэнийг эксватор оператор бэлтгэх сургалтанд компанийн зардлаар хамруулсан ба эдгээр 4 иргэн нь одоо төслийн барилгын багт туслах ажилтнаар ажиллаж байна.

“Согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хэрэглээнд тавих хяналтын бодлого”-ын дагуу болзошгүй хэрэглээ дээр хатуу хяналт тавьж ажилладаг. Мөн байгууллагын мөрдөх 10 “Алтан дүрэм” -д “Төслийн талбайд согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хэрэглэх, хэрэглэсэн үедээ ирэх болон ажиллахыг хориглоно.” гэж заасан байдаг.

Өдөр бүр төслийн талбайд ажиллаж байгаа бүх ажилчдыг өглөө, орой, төслийн талбай руу орж, гарах бүрт амьсгал дахь согтууруулах ундааны илэрцийг шалгадаг.



**ДРАГЕР ШАЛГАСАН ӨДӨР ТУТМЫН БҮРТГЭЛ**

2022 оны 08 дугаар сарын 08 Шинэжинст Баянхөндий

№	Нэрс	Байгууллага	Он сар өдөр	АДСХ %	АДСХ %	АДСХ %	№	Гарын үсэг
				Өглөө	Өдөр	Орой		
1	Давааниям	ЭРД	2022.08.08	00%	00%	00%	1	[Signature]
2	Бат-эрдэнэ	ЭРД	2022.08.08	00%	00%	00%	2	[Signature]
3	Өнөрзаяа	ЭРД	2022.08.08	00%	00%	00%	3	[Signature]
4	Чулуунбат	ЭРД	2022.08.08	00%	00%	00%	4	[Signature]
5	Итгэлт	ЭРД	2022.08.08	00%	00%	00%	5	[Signature]
6	Бумбаяр	ЭРД	2022.08.08	00%	00%	00%	6	[Signature]
7	Мягмарсүрэн	ЭРД	2022.08.08	00%	00%	00%	7	[Signature]
8	Баянжаргал	ЭРД	2022.08.08	00%	00%	00%	8	[Signature]
9	Долгорсүрэн	ЭРД	2022.08.08	00%	00%	00%	9	[Signature]
10	Цэвэлмаа	ЭРД	2022.08.08	00%	00%	00%	10	[Signature]
11	Алтанхуяг	ЭРД	2022.08.08	00%	00%	00%	11	[Signature]
12	Батбаяр	ЭРД	2022.08.08	00%	00%	00%	12	[Signature]
13	Батбаатар	ЭРД	2022.08.08	00%	00%	00%	13	[Signature]
14	Жаргалсайхан	МОНРУД	2022.08.08	00%			14	[Signature]
15	Энхсайхан	МОНРУД	2022.08.08	00%			15	[Signature]
16	Энхээ	МОНРУД	2022.08.08	00%	00%	00%	16	[Signature]
17	Баянбилэг	МОНРУД	2022.08.08	00%	00%	00%	17	[Signature]
18	Гантөмөр	МОНРУД	2022.08.08	00%	00%	00%	18	[Signature]
19	Ууганбаяр	МОНРУД	2022.08.08	00%	00%	00%	19	[Signature]
20	Одончимэг	МОНРУД	2022.08.08	00%	00%	00%	20	[Signature]
21	Сүрэнлхам	МОНРУД	2022.08.08	00%	00%	00%	21	[Signature]
22	Буянжаргал	МОНРУД	2022.08.08	00%	00%	00%	22	[Signature]
23	Сосорбурам	МОНРУД	2022.08.08	00%	00%	00%	23	[Signature]
24	Цогзолбоо	МОНРУД	2022.08.08	00%	00%	00%	24	[Signature]
25	Ариунжаргал	МОНРУД	2022.08.08	00%	00%	00%	25	[Signature]
26	Пүрэв-Очир	МОНРУД	2022.08.08	00%	00%	00%	26	[Signature]
27	Номундарь	МОНРУД	2022.08.08	00%	00%	00%	27	[Signature]
28	Отгонбаатар	ГМС	2022.08.08	00%	00%	00%	28	[Signature]
29	Цэрэндаваа	ГМС	2022.08.08	00%	00%	00%	29	[Signature]
30	Алтанхундага	ГМС	2022.08.08	00%	00%	00%	30	[Signature]
31	Соёмбо-Эрдэнэ	ГМС	2022.08.08	00%	00%	00%	31	[Signature]
32	Маралмаа	ГМС	2022.08.08	00%	00%	00%	32	[Signature]
33	Доржсамбуу	ГМС	2022.08.08	00%	00%	00%	33	[Signature]
34	Ендонсамбуу	ГМС	2022.08.08	00%	00%	00%	34	[Signature]
35	Ганбаатар	ГМС	2022.08.08	00%	00%	00%	35	[Signature]
36	Мэндбаяр	ГМС	2022.08.08	00%	00%	00%	36	[Signature]
37	Бүрэнзэвсэг	ГМС	2022.08.08	00%	00%	00%	37	[Signature]
38	Бямбарэнцэн	ГМС	2022.08.08	00%	00%	00%	38	[Signature]
39	Золзаяа	ГМС	2022.08.08	00%	00%	00%	39	[Signature]
40							40	
41							41	
42							42	
43							43	

Зураг 29. Амьсгал дахь согтууруулах ундааны илэрц шалгасан хуудас

Эрдэнэ Ресурс нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр мөрдөгдөж ОНХАГ-г шинэчилснийг танилцлахад таатай байна. ОНХАГ нь Ашигт



малтмалын тухай хуулийн хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын орон нутаг буюу аймаг сумдын захиргаатай зайлшгүй гүйцэтгэх гэрээ юм. ОНХАГ-г компаниас гадна дараах оролцогч талууд хамтран баталгаажуулсан:

- Баянхонгор аймаг: Засаг дарга Д.Мөнхсайхан
- Баян-Өндөр сум: Засаг дарга Б.Идэрмөнх
- Шинэжинст сум: Засаг дарга Б.Бат-Эрдэнэ

Манай үйл ажиллагаа эрхлэн явуулдаг орон нутгийн алслагдмал нөхцөл байдлын онцлогоос хамаарч бид эрүүл мэнд, дэд бүтцийн салбаруудыг онцлон авч үздэг ба ОНХАГ-ний хөрөнгө оруулалт дээрх салбаруудад төвлөрсөөр ирсэн. Шинэчилсэн ОНХАГ нь 2021 оны 07 дугаар сард байгуулсан гэрээнд үндэслэсэн бөгөөд Монгол Улсын баруун өмнөд бүс нутгийг хөгжүүлэхэд Компани болон орон нутгийн засаг захиргаа хамтран ажиллана. Эрдэнэ Ресурс өнөөг хүртэл төсөл хөтөлбөрүүдэд 3.4 тэрбум төгрөг хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд шинэчлэгдсэн ОНХАГ-ний хүрээнд үргэлжлүүлэн 4.1 тэрбум төгрөг хөрөнгө оруулалт хийнэ. ОНХАГ-ний санхүүжилтийн 60 орчим хувийг аймгийн төсөл хөтөлбөрүүд, үлдсэн 40 орчим хувийг хоёр сумдын хөтөлбөрүүдэд зарцуулна. ОНХАГ-г Эрдэнэ Ресурсийн төлөөлөгч болон орон нутгийн сонгогчдын төлөөллүүдээр ахлуулсан ашгийн бус байгууллага удирддаг. Ингэснээр ОНХАГ-ний хүрээнд санхүүжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн саналыг хүлээн авах, сонгон шалгаруулах, баталгаажуулах болон цаашдаа хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдийн гүйцэтгэлийг үнэлнэ.

Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд цар тахлын нөлөөллөөс үүдэн ОНХАГ-ний санхүүжилтийн 32% нь нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн хөрөнгө оруулалтууд байв. Эрдэнэ Ресурсийн дэмжлэгээр шинжилгээ, оношилгооны тоног төхөөрөмж, эмнэлгийн ажилтнууд, сайн дурын ажилтнуудад зориулсан хувийн хамгаалах хэрэгслүүдийг санхүүжүүлж, нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах эмчилгээ, эмний нийлүүлэлтийг хүртээмжтэй болгосон. Түүнээс гадна компани нь аймаг, сумдын сэтгэцийн эрүүл мэнд, бие бялдрын чийрэгжүүлэлтийн сургалтуудыг дэмжин ажилласан.

Компани нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд орон нутгийн дэд бүтэц, бүтээн байгуулалтын төслүүд, орон нутгийн амьжиргааг дээшлүүлэх хөтөлбөрүүдэд 450,000 ам.долларын санхүүжилт хийсэн. Аймгийн төвийн цэцэрлэгт хүрээлэнг нөхөн сэргээх, төвлөрсөн дулааны станцад агаарын чанарыг сайжруулах төхөөрөмж суурилуулах, цаг агаарын хүндрэлтэй нөхцөлд малын тэжээлээр хангах зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн.

Үлдсэн 20%-ийн санхүүжилт нь залуучуудын хөгжил, олон нийтийн боловсролд зориулагдсан. Төсөл хөтөлбөрүүдээс онцолбол: орон нутгийн сургуулиудыг цар тахлын үед зайнаас суралцах боломжтой болгон тоног төхөөрөмжөөр хангаж, сургалтуудыг хийсэн. Түүнээс гадна оролцогч талуудын соёл урлаг, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх ажлын хүрээнд тэмдэглэлт өдрүүд, спортын арга хэмжээнүүдийг дэмжин ажилласан.

## 4.2 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Эрдэнэ Монгол” ХХК нь төслийн талбайд нөхөн сэргээх арга хэмжээ авч, газрын эвдрэлийг хамгийн бага хэмжээнд байлгахыг эрмэлздэг. “Баянхөндий” төслийн барилгын ажил хойшлогдсон хэдий ч барилгажилтын явцад эвдрэх газрын хэмжээг



хамгийн бага байлгах үүднээс төслийн талбайд газар хөндөх зөвшөөрлийн журам хэрэгжүүлж эхээлсэн. Түүнчлэн, нөхөн сэргээлтийн ажилд бэлдэх үүднээс байгалийн ургамал үржүүлгийн газар байгуулж, тодохой хэмжээний ургамлын үр бэлдэж, үрээр үржүүлэх, тарьц суулгац бэлдэх ажлыг эхлүүлээ. Мөн геологийн хайгуулын цооног өрөмдсөн талбайд техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж, анхны төрхөнд ойртуулахыг зорьсон.

Хүснэгт 10. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Тоо хэмжээ	Баримтласан эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (сая төгрөг)
Шимт хөрсийг овоолгод тогтвортой байршуулж, нөхөн сэргээлтэд ашиглах	Төслийн барилгажилтын үед 85.81 га талбайгаас 0.3 м зузаантай хуулсан шимт болон шимэрхэг хөрсийг экскаватороор ачиж, овоолго байгуулах талбай руу автосамосвалаар тээвэрлэх	257,430.00	MNS 5916:2008 Байгаль орчин. Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт	Барилгажилт болон хөрс хуулалтын ажил хийгдээгүй.	Үйл ажиллагааны зардал
Байгалийн ургамал үржүүлгийн газар байгуулах	2 га талбайн хөрс бэлтгэх, хөрс бэлтгэх, хүлэмж, хашаа барих, агуулах, усны нөөцийн сав байршуулах	1 багц байгууламж	MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага	Байгалийн ургамал үржүүлгийн газрын 2 га талбайг байгуулан 6 хүлэмж барьж, ургамал шилжүүлэн тарих, бойжуулалтын 9 талбайг бэлтгэсэн ба 20тн багтаамжтай 2 контайнер, оффисын зорилгоор 1 гэр, ажилчдын амрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор 2 сүүдрэвч хийсэн ба 5тн багтаамжтай нөөцийн сав 5 ш байршуулсан.	Үйл ажиллагааны зардал



				Мөн хоёрдугаар хүлэмжинд дуслын усалгааны систем суурьлуулсан.	
	Зөвшөөрлийн дагуу талбайн ойр орчмоос загийн үртүүх	20.00	Байгалийн ургамлын тухай хууль 13.3	Дараа жилүүдийн тариалалтад хэрэглэх, нутгийн ургамлын үрийн сан бүрдүүлэх, нөхөн сэргээлтэд нутгийн ургамал хэрэглэх зорилгоор хайлаасны 15кг, шар хотирын 2кг, тооройн 3кг, бүйлсний 2.5кг, хармагны 3кг, жигдний 3кг үр түүсэн. Говийн их ДЦГ-ын “А” хэсгийн хамгаалалтын захиргаатай байгуулсан санамж бичигт заасны дагуу тус захиргааны мод үржүүлгийн газрын үйл ажиллагааг дэмжих заалтын дагуу жигд 100 ш, тоорой 100 ш, саваа улиас 150 ш, бургас 50 ш, сухай 2300 ш суулгац худалдан авч, намрын тариалалтаар тариалсан.	Үйл ажиллагааны зардал
Газрын гадарга, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах	Цооног өрөмдсөн талбайд техникийн нөхөн сэргээлтийн стандартыг баримтлан анхны төрхөд ойртуулах	Өрөмдсөн цооног, нэвтэрсэн сувгийн тоогоор	“Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008”	Хөндий талбайд 54 цооног 3029 т.м өрөмдлөгийн ажил хийсэн. Цооног өрөмдсөн тухай бүрт өрмийн талбайд техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийлгэхийг эрхэмлэн, анхны төрхөд ойртуулж, ойр орчмын хог хаягдлыг бүрэн	13,500.0





				цэвэрлэж дууссны дараа уг талбайг хүлээн авдаг. Салаа зам гаргасан болон эвдрэлд оруулсан, зорчих шаардлагагүй замыг тор татан хааж, дахин тээврийн хэрэгсэл зорчихгүй байх арга хэмжээг авдаг.	
--	--	--	--	---	--

Байгалийн ургамал үржүүлгийн газрыг 2 га талбайд байгуулан 6 хүлэмж барьж, ургамал шилжүүлэн тарих, бойжуулалтын 9 талбайг бэлтгэсэн ба 20 тн багтаамжтай 2 контайнер, оффисын зорилгоор 1 гэр, ажилчдын амрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор 2 сүүдрэвч хийсэн ба 5 тн багтаамжтай нөөцийн сав 5ш байршуулсан.



Зураг 30. Байгалийн ургамал үржүүлгийн газар

Хүснэгт 11. 2022 оны тариалалтын мэдээ

Д/д	Ургамлын нэр	Ургасан тоо	Тариалалт	Амьдралтын хувь	Өвөлжилтөд бэлтгэсэн
<b>Хаврын тариалалт</b>					
1	Заг	2500	Үрээр	100	Гадаа талбайд бортогонд
2	Заг	12000	Үрээр	100	Хүлэмжинд 18 м <sup>2</sup>
3	Хайлаас	2500	Үрээр	100	Хүлэмжинд бортогонд 1м х 5м
4	Хотир	952	Үрээр	100	Хүлэмжинд бортогонд
5	Лидэр	528	Үрээр	100	Хүлэмжинд бортогонд
6	Сухай	180	Мөчрөөр	100	Талбайд
7	Тоорой	50	Үрээр	20	Хүлэмжинд бортогонд
8	Хайлаас	100	Үрээр	100	Хээрийн ангид
<b>Нийт</b>				<b>18,810</b>	
<b>Намрын тариалалт</b>					
9	Жигд	100	Суулгац	Ирэх жил үнэлнэ.	Талбайд
10	Тоорой	80	Суулгац		Талбайд
11	Бургас	10	Суулгац		Талбайд
12	Улиас	150	Суулгац		Талбайд
13	Сухай	1700	Суулгац		Талбайд
<b>Нийт</b>				<b>2,040</b>	

Дүн	20,850
-----	--------

Дараа жилүүдийн тариалалтад хэрэглэх, нутгийн ургамлын үрийн сан бүрдүүлэх, нөхөн сэргээлтэд нутгийн ургамал хэрэглэх зорилгоор хайлаасны 15 кг, шар хотирын 2 кг, тооройн 3 кг, бүйлсний 2.5 кг, хармагны 3 кг, жигдний 3 кг үр түүсэн.



Зураг 31. Түүсэн үрийг хадгалсан байдал

Говийн их ДЦГ-ын “А” хэсгийн хамгаалалтын захиргаатай байгуулсан санамж бичигт заасны дагуу тус захиргааны мод үржүүлгийн газрын үйл ажиллагааг дэмжих заалтын дагуу Говийн их ДЦГ-ын “А” хэсгийн хамгаалалтын захиргаатай байгуулсан санамж бичигт заасны дагуу тус захиргааны мод үржүүлгийн газрын үйл ажиллагааг дэмжих заалтын дагуу жигд 100 ш, тоорой 100 ш, саваа улиас 150 ш, бургас 50 ш, сухай 2300 ш суулгац худалдан авч, намрын тариалалтаар тариалсан.



Зураг 32. Намрын тариалалт

Хөндий талбайд 54 цооног 3029 т.м өрөмдлөгийн ажил хийсэн. Цооног өрөмдсөн тухай бүрт өрмийн талбайд техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийлгэхийг



эрхэмлэн, анхны төрхөд ойртуулж, ойр орчмын хог хаягдлыг бүрэн цэвэрлэж дууссны дараа уг талбайг хүлээн авдаг. Салаа зам гаргасан болон эвдрэлд оруулсан, зорчих шаардлагагүй замыг тор татан хааж, дахин тээврийн хэрэгсэл зорчихгүй байх арга хэмжээг авдаг.



ФалконДриллинг Монголиа ХХК / Falcon Drilling Mongolia LLC

Кэмп болон өрмийн талбайг цэвэрлэж хүлээлцсэн протокол  
Camp & drill site area inspection sheet

Jobsite name & # / Ажлын хэсгийн нэр: Баян Хөндий 004

Jobsite Location / Ажлын хэсгийн байршил: Баян Хөндий Увс сум, Ховд сум, 44

Date / Огноо: 2022-09-09

No	Description / Тайлбар	Yes / Тийм	No / Үгүй
1	Өрмийн талбайг цэвэрлэсэн эсэх / Is drill site cleaned proper & completely	✓	
2	Кампын өрмийн тойргийг цэвэрлэсэн эсэх / Is the camp area cleaned proper & completely	✓	
3	Өрөмдлөгийн цооногийг бусан эсэх / Are all sumps back filled in the drill area	✓	
4	Кампын хог хаягдлын нүхийг бусан эсэх / Are garbage holes back filled in the camp area	✓	

Comments: AAD-204, AAD-205, AAD-206 цөөнгүүрэн талбайг цэвэрлэн талбайг цэвэрлэн хэргийг хэрэгсэл хэрэгсэл.

Signed by:

From the Company / Компаний талаас:

Position / Албан тушаал: Foreman

Name & Signature / Нэр, гарын үсэг: Воронцов А.И.

From the Client / Үйлдүүлэгч талаас:

Position / Албан тушаал: Г.Н.М.М.М.М.М.

Name & Signature / Нэр, гарын үсэг: Г.Н.М.М.М.М.М.

Зураг 33. Цооног өрөмдөхийн өмнө болон дараа

## 4.3 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### 4.3.1. Биологийн олон янз байдал талаар баримтлах бодлого

“Эрдэнэ Монгол” ХХК нь төслийн бүс нутгийн биологийн олон янз байдалд эерэг ахиу нөлөө үзүүлэхийг зорилготой ажиллаж байгаа билээ. Энэхүү зорилгодоо уурхайн хаалтын үед хүрсэн байхаар зорьж байгаа хэдий ч төсөл хэрэгжих хугацаанд аль болох эрт хүрэх боломжуудыг эрэлхийлэх болно.

Үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн биологийн олон янз байдалд учирч болох нөлөөллийг шатлалтайгаар багасгах зарчмыг баримталж байгаа ба энэ нь биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулахдаа юун түрүүнд тэрхүү нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, нөхөн сэргээх арга замаар хийгддэг.



Хүснэгт 12. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага	Тоо хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (сая төгрөг)
Байгалийн амьдрах орчныг нөхөн сэргээх	Нөхөн сэргээлт хийх Цагаан дэрс, Түймэрт газруудад эвдэрсэн газрын судалгаа хийлгэж, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг боловсруулах	Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр БОНХСайдын 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн А 117 дүгээр тушаалын 2 дүгээр хавсралт. 3-р хэсэг; Байгаль орчныг хамгаалах тухай хууль. 31 дүгээр зүйл.	1 төлөвлөгөө	Төслийн БОМТ-нд тусгагдсан Шинэжинст сумын Уртын гол 2 дугаар багийн нутагт орших Цагаан дэрс газар нь түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох Аурум металурус ХХК-ны лицензийн талбайд хамаарч байгаа тул нөхөн сэргээлтийн судалгаагТүймэрт, ИБЦГ-аас ирүүлсэн Баянлиг сумын Их халбагант 1-р багийн нутаг болон Шинэжинст сумын Засаг даргаас ирүүлсэн Давхар хар зэрэг газруудад судалгааны ажлыг 2022 оны 07-08 дугаар сард хийсэн. “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний хүрээнд эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлт хийх ажлын даалгаварыг боловсруулж Их Богдын Байгалийн цогцолборт газартай 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр гэрээ байгуулан ажиллаж байна. Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт байрлах Түймэрт газрын талбайг оролцуулан Их Богдын байгалийн цогцолбор газарт хууль бус ашигт малтмал олборлолтын улмаас эвдрэлд орж орхигдсон нийт 14 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 2022 оны 10 дугаар сард хэрэгжүүлсэн. Хавсралт 14. Техникийн нөхөн сэргээлтийг ажил гүйцэтгэх гэрээ.	58.0
	Эвдэрсэн газруудыг нөхөн сэргээх			6.3	БОНБҮ-ний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх хэсэгт “биологийн олон янзын байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн



				олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээ”-г хэлнэ гэж заасан байдаг. Баянхөндий төслийн хүрээнд 2022 онд барилгын ажил хойшлогдож газар хөндөөгүй боловч БОМТ-ний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Шинэжинст сумын Уртын гол багийн Түймэртийн 1.6 га талбай болон Их Богдын БЦГазрын хамгаалалтын захиргаанаас ирсэн хүсэлтийн дагуу Баянлиг суманд улсын тусгай хамгаалалттай газарт гар аргаар ашигт малтмал олборлолтын улмаас эвдрэлд орж, эзэнгүй орхигдсон 14 га, нийт 15.6 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийх ажилд 2022 оны 10 сард гэрээ байгуулан техникийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэсэн. Баянхөндий төслийн БОМТ-нд тусгасан 6.3 га талбайн хэмжээнээс 2.5 дахин их буюу 15.6 га талбайд нөхөн сэргээлтийн ажлыг хэрэгжүүлсэн.Түймэрт болон бусад талбайн нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэлийг 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хүлээж авахаар ажиллаж байна.	
	Тарьц, суулгац бэлдэх	МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод тарих” үндэсний хөдөлгөөн	10000	Байгалийн ургамал үржүүлгийн газар болон хээрийн ангид хаврын тариалалтаар 18810 болон намрын тариалалтаар 2040 мод нийт 20850 тарьц суулгацыг тарьж ургуулаад байна.	42,2
Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалал хэрэгжүүлэх газар нутгийг холбогдох төрийн захиргааны байгууллагуудтай хамтран сонгох	Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, 2021 он	5721	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр санал болгосон газруудад судлаач Н.Батсайхан, түүний багтай хамтран биологийн олон янз байдлын тандан судалгааг хийсэн. Энэхүү судалгааны үр дүнд үндэслэн биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын хүрээнд цаашид хэрэгжүүлэх ажлыг тодорхойлно.	-
	Дүйцүүлэн хамгаалал хэрэгжүүлэх газар нутгийн биологийн төрөл зүйлийн судалгаа	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний	1 гэрээ	Монгол Улсын Их Сургуулийн мэргэшсэн судлаачидтай хамтранбиологийн олон янз байдлындүйцүүлэн хамгааллыг хэрэгжүүлэх газар нутгийг сонгох, хамгааллын аргуудыг сонгох тандан судалгааны ажлын	9,0



<p>хийх мэргэжлийн байгууллагыг сонгох, гэрээ байгуулах</p>		<p>тухай хууль, 9.6 дугаар заалт</p>		<p>гэрээг 2022 онын 9 дүгээр сард байгуулж, хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэсэн. Судалгааны тайланг үндэслэн биологийн олон янз байдлыг дүйцүүлэх хамгаалах, амьдрах орчныг сайжруулах арга хэмжээг тодорхойлно.</p>	
	<p>Дүйцүүлэн хамгаалал хэрэгжүүлэх газар нутгийн биологийн төрөл зүйлийн судалгаа хийх</p>		<p>1 тайлан</p>	<p>Монгол Улсын Их Сургуулийн мэргэшсэн судлаачидтайхамтран биологийн төрөл зүйлийн дүйцүүлэн хамгаалалыг хэрэгжүүлэх байршил, амьдрах орчныг тэтгэх чиглэлээр цаашид хэрэгжүүлэх ажлуудыг тодорхойлох зорилгоор тандан судалгааг 2022 оны 09 дүгээр сард зохион байгуулсан.Судалгааны үр дүнд Судалгааны үр дүнд ОУСК-ын боловсруулсан гүйцэтгэлийн стандарт 6, ОУБХХ-ны боловсруулсан Улаан дансны шалгуураар бүс нутгийн болон олон улсын түвшинд ховордлын зэрэг өндөртэй амьтан, ургамлын зүйлийг нэн тэргүүнд санал болгож, ижил төстний экосистемийг нарийвчлан судалж дүйцүүлэн хамгаалалын байршлыг сонгож, хөтөлбөр төлөвлөгөөг гаргахыг зөвлөсөн. Иймд 2023 онд дүйцүүлэн хамгаалалын байршлыг нарийвчлан тогтоож, холбогдох арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Хавсралт 15. Биологийн төрөл зүйлийн тандан судалгааны тайлан.</p>	
	<p>Дүйцүүлэн хамгаалал хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, батлуулах</p>		<p>1 төлөвлөгөө</p>	<p>Дээр дурьдсан тандан судалгааны үр дүнд төслийн үйл ажиллагаанд хамаарах газар нутгийн цар хүрээнд биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах зорилгод нийцэх амьдрах орчин буюу экосистемийн хэв шинж нь өвөрмөц экосистем болох гүний уснаас хамааралтай сайр, садарга, хотгор газар илэрч байгаа тул энэ дурдсан оронзайд сонголт хийх шаардлагатай. Тухайлбал, олон улсын болон бүс нутгийн түвшинд ховордлын зэрэг өндөртэй зарим зүйл хөхтөн амьтан, шувуу (хар сүүлт зээр хулан жороо), түүнчлэн монгол</p>	



				<p>буйлс, алтан харгана, Төв Азийн лавай, Монгол азар зэрэг олон эндемик зүйл сөөг өвөрмөц экосистемд тохиолдож буй нь энэ экосистемийн ач холбогдлыг илэрхийлж байна. ОУСК-ын боловсруулсан гүйцэтгэлийн стандарт 6-д, ОУБХХ-ны боловсруулсан Улаан дансны шалгуураар бүс нутгийн болон олон улсын түвшинд ховордлын зэрэг өндөртэй амьтан, ургамлын зүйлийг нэн тэргүүнд санал болгосон байдаг. Тиймээс Жинст уулын бэлд орших Баянбулгийн тал, Идрэнгийн нурууны дорнод хая уулсын бэлд орших загт бүлгэмдэлтэй талархаг газар, Долооны хоолой нь биологийн олон янз байдлын хувь ядмаг түгээмэл экосистем болох хээржүү цөл, жинхэнэ цөл, алаг цоог цөлжүү хээр илэрч байгааг тодорхойлсон.</p> <p>Иймд 2023 онд дүйцүүлэн хамгаалалын байршлыг нарийвчлан тогтоож, холбогдох төрийн захиргааны байгууллагуудтай хамтран сонгож, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Энэ ажлыг барилгын ажлын үе шаттай уялдуулан хэрэгжүүлнэ.</p>	
--	--	--	--	--	--

Компанийн үйл ажиллагаанд Монгол Улсад 2013 оноос хэрэгжиж байгаа Үйл ажиллагааны сайн дурын Кодекс (ҮАСДК)-т 2016 оноос орж ажиллаж байна. Энэхүү кодекст нэгдсэнээрээ усны нөөцийг зохистой ашиглах, усыг хэмнэлттэй, үр ашигтай ашиглах, тогтвортой менежементийг нэвтрүүлэх чиглэлд анхаарч ажиллах үүргийг сайн дураараа хүлээж байгаа хэрэг юм. Энэ хүрээнд Ус, биологийн олон янз байдлын тогтвортой менежмент цаашид авах арга хэмжээ техникийн семинарыг 2022 оны 03 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд хамтран зохион байгуулж Баянхөндий төсөл хөгжүүлэлтийн мэдээллийг танилцуулсан.



Зураг 34. Техникийн семинар

МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод тарих” үндэсний хөдөлгөөнийг дэмжин 2030 он гэхэд 2 сая мод тарих ажлыг төлөвлөсөн. 2022 оны хаврын тариалалтаар байгалийн ургамал үржүүлгийн газарт үрээр заг, хайлаас, тоорой, хотир, лидэр мөчрөөр сухай хүлэмжинд тарьсан ба намрын тариалалтаар 3-5 настай суулгацаар жигд, тоорой, саваа улиас, бургас, сухай 2040 ш нийт 20850 ш тарьц суулгацыг тарьж ургуулсан. Хаврын тариалалтын модны суулгацын амьдралтын хувь 90%, намрын тариалалтын амьдралтын хувийг 2023 онд үнэлэхээр төлөвлөж байна.



Зураг 35. Тэрбум мод хөтөлбөрийн хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8000га талбайг нөхөн сэргээх төлөвлөгөөний дагуу Баянхонгор аймгийн Шинэжинст суманд гар аргаар алт олборлох үйл ажиллагааны улмаас эвдэрч, орхигдсон Цагаан дэрс, Түймэрт газруудын 6.3 га талбайг нөхөн сэргээхээр төлөвлөсөн хэдий ч Цагаан дэрс талбай нь Аурум



металурус ХХК-ны тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай байсан. Иймд эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг Шинэжигст сумын Уртын гол багийн Түймэрт талбайн 1.6 га болон Их Богдын БЦГазрын хамгаалалтын захиргаанаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Шинэжинст, Баянлиг суманд улсын тусгай хамгаалалттай газарт гар аргаар ашигт малтмал олборлолтын улмаас эвдрэлд орж, эзэнгүй орхигдсон 14га газарт техникийн нөхөн сэргээлтийг хамтран гэрээ байгуулан 2022 оны 10 дугаар сард хэрэгжүүлсэн. БОНБУ-ний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх хэсэгт “биологийн олон янзын байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээ”-г хэлнэ гэж заасан байдаг. Баянхөндий төслийн хүрээнд 2022 онд барилгын ажил хойшлогдож газар хөндөөгүй боловч БОМТ-ний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дээрх Түймэртийн 1.6 га болон Их Богдын Байгалийн цогцолборт газрын 14 га, нийт 15.6 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийж БОМТ-нд тусгасан 6.3 га талбайн хэмжээнээс 2.5 дахин их талбайд нөхөн сэргээлтийн ажлыг хэрэгжүүлсэн (Хавсралт 14). Нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэлийг 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хүлээн авах комисс ажлуулахаар төлөвлөж байна.

Баянхонгор аймгийн БОАЖГазар, Шинэжинст сумын ЗДТГазар, Отгон-Бор Хавцал ТББ-ын хамтарсан гэрээний дагуу “Хонгор Тогтвортой Хөгжил” ТББ-ын 8.3 сая төгрөгийн санхүүжилтээр Баян-Өндөр сумын нутгаас 20 толгой тарвага мэргэжлийн байгууллага барьж 2022 оны 05 сарын 28-нд Шинэжинст сумын Уртын гол 2-р багийн Хатан хайрхан гэдэг газар нутагшууллаа. Тарвага нутагшуулсан ажлын тайланг Хавсралт 16-д хавсаргав.



Зураг 36. Тарвага нутагшуулж буй нь

Шинэжинст сумын Уртын гол багт мод тарих хүсэлтийн дагуу намрын тариалалтад зориулж сухай - 540ш, тоорой - 35, бургас -37ш нийт суулгацыг сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагчид хүлээлгэн өгсөн.

#### **4.3.2. Нөлөөлөлд өртөх болон дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээ**

“Баянхөндий төслийн ил уурхайн олборлолт, баяжуулах үйлдвэр, дэд бүтцийн бүтцийн байгууламжууд нь талбай болон зурвас хэлбэрийн нөлөөлөл үзүүлэх ба нөлөөлөлд өртөх талбайн хэмжээ “Нөлөөлөл бууруулах программ” (Mongolian Mitigation Design Tool)-д тооцсоноор 1,041 га (337.5 га их, 107.5 га дунд, 595.9 га бага эрчимтэй), дүйцүүлэн хамгаалах шаардлагатай талбайн хэмжээг мөн “Нөлөөлөл буурах программ”-д тооцсон



ба 5721 га буюу нөлөөлөлд өртөх талбайгаас 5 дахин их байна.” гэж БОННУ-д тусгагдсан.

#### **4.3.3. Дүйцүүлэн хамгаалах газрын санал болгож буй байршлууд**

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх боломжит газрын байршлаар ГИДЦГ-ын А хэсгийн орчны бүсэд орших Эдрэнгийн нуруу, Номингийн говь болон Баянбулагийн тал гэсэн 3 байршил сонгогдсон. Өмнийн говийн Экологийн бүс нутгийн үнэлгээгээр Эдрэнгийн нуруу, Номингийн говь, хамгаалах шаардлагатай газруудад Баянбулагийн тал Шинээр хамгаалах шаардлагатай газрын ангилалд хамаарагдана. 2022 онд төслийн талбай болон дээрх БОННУ-ний тайланд санал болгосон байршлуудад Монгол Улсын Их Сургуулийн мэргэшсэн судлаачидтай хамтран биологийн төрөл зүйлийн дүйцүүлэн хамгаалалыг хэрэгжүүлэх байршил, амьдрах орчныг тэтгэх чиглэлээр цаашид хэрэгжүүлэх ажлуудыг тодорхойлох зорилгоор тандан судалгааг 2022 оны 09 дүгээр сард зохион байгуулсан. Судалгааны үр дүнд төслийн үйл ажилгаанд хамаарах газар нутгийн цар хүрээнд биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах зорилгод нийцэх амьдрах орчин буюу экосистемийн хэв шинж нь өвөрмөц экосистем болох гүний уснаас хамааралтай сайр, садарга, хотгор газар илэрч байгаа тул энэ дурдсан оронзайд сонголт хийх шаардлагатай. Тухайлбал, олон улсын болон бүс нутгийн түвшинд ховордлын зэрэг өндөртэй зарим зүйл хөхтөн амьтан, шувуу (хар сүүлт зээр хулан жороо), түүнчлэн монгол буйлс, алтан харгана, Төв Азийн лавай, Монгол азар зэрэг олон эндемик зүйл сөөг өвөрмөц экосистемд тохиолдож буй нь энэ экосистемийн ач холбогдлыг илэрхийлж байна. ОУСК-ын боловсруулсан гүйцэтгэлийн стандарт 6-д, ОУБХХ-ны боловсруулсан Улаан дансны шалгуураар бүс нутгийн болон олон улсын түвшинд ховордлын зэрэг өндөртэй амьтан, ургамлын зүйлийг нэн тэргүүнд санал болгосон байдаг. Тиймээс Жинст уулын бэлд орших Баянбулгийн тал, Идрэнгийн нурууны дорнод хая уулсын бэлд орших загт бүлгэмдэлтэй талархаг газар, Долооны хоолой нь биологийн олон янз байдлын хувь ядмаг түгээмэл экосистем болох хээржүү цөл, жинхэнэ цөл, алаг цоог цөлжүү хээр илэрч байгааг тодорхойлсон. Иймд 2023 онд дүйцүүлэн хамгаалалын байршлыг нарийвчлан тогтоож, холбогдох төрийн захиргааны байгууллагуудтай хамтран сонгож, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Энэ ажлыг барилгажилтын үе шаттай холбогдуулан хэрэгжүүлнэ.

#### **4.4 ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Баянхөндий хээрийн ангийг тохижуулах, цэцэрлэгжүүлэх ажлын хүрээнд гэрүүд, оффис, гал тогоо, ариун цэврийн өрөө хооронд хайрган замыг гаргасан ба оффис, амралтын өрөө, ариун цэврийн өрөө, амралтын өрөөний урд талд өмнөх жилүүдэд үрээр тарьсан заг, мөчрөөр тарьсан сухай ургаж байна. Тайлант онд оффисын хойд тал, амралтын өрөөний зүүн талд хайлаас үрээр тарьсан хэдий ч туулай идсэн тул дахин сухай мөчрөөр тарьсан. Мөн хамгаалалтын байр руу орох замын 2 талаар, хээрийн ангийн хашааны гадна талаар эхний ээлжинд нөмөртэй газарт шуудуу татан сухай, саваа улиас, тоорой суулгацаар тарьсан. Анхны тусламж үзүүлэх байрны урд талд 7 ш мандалд энхэлгэнэ цэцэг тарьсан.



Зураг 37. Кэмпийн тохижилт, цэцэрлэгжүүлэлт

Хүснэгт 13. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Тоо хэмжээ	Баримтгласан эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (сая төгрөг)
Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана	Кэмп, оффисын гаднах талбайд ногоон байгууламж бий болгох	5000м <sup>2</sup>	Газрын тухай хууль 56.6	Баянхөндий хээрийн анги нь 2 га талбайтай өмнөх тариалалт хийсэн талбай 40 м, энэ онд үүнээс 127 м зурвас талбайд ургамал тариалах ажлыг хэрэгжүүлж байна.	-

#### 4.5 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Баянхөндий төслийн ил уурхай, барилга байгууламжууд барих талбайгаас баруун урагш 1.9-3.2 км зайд 3 өрх малчин өрхийн өвөлжөө зориулалттай эзэмшил газар байдаг. Д.Баасандаш (1.9 км), Б.Ганбат (2.8 км), П.Нямсүрэн (3.2 км) нарын өвөлжөөний газар хамгийн ойр байршдаг ба тухайн бууцыг улирлын чанартайгаар ашигладаг бөгөөд жил бүр ирж нутагладаггүй.

Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас үзүүлж буй нөлөөлөл тус өрхийн гишүүдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учруулах, малын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй нь хяналт шинжилгээний хөтөлбөр болон



бусад холбогдох баримтуудаар тогтоогдвол нүүлгэн шилжүүлэх ажлыг нөлөөлөлд өртөх эрсдэлтэй малчин өрх, Шинэжист сумын удирдлагатай хамтран зохион байгуулахаар төлөвлөсөн. Дээрх малчин өрхүүд нь тухайн бууцыг улирлын чанартайгаар ашигладаг бөгөөд энэ жил ирж нутаглаагүй.

Хүснэгт 14. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Баримтласан стандарт, аргачлал	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (сая төгрөг)
Барилга барих үйл ажиллагаанаас үүсэх дуу чимээ, тоосжилтоос ойролцоо нутаглаж буй малчин өрхийн гишүүдэд тавгүй байдал үүсгэж болзошгүй	Уурхайн үйл ажиллагаанаас үүсч буй дуу чимээ, тоосжилт нь ойролцоо өвөлжөөнүүдийн орчимд агаарын чанарын стандарт хэмжээнд байгаа эсэхийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн үр дүнгүүдэд үндэслэн тодорхойлсноор цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.	Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, 2021 он	Баянхөндий төслийн ил уурхай, барилга байгууламжууд барих талбайгаас баруун урагш 1.9-3.2 км зайд 3 өрх малчин өрхийн өвөлжөө зориулалттай эзэмшил газар байдаг. Малчин өрхүүд нь тухайн бууцыг улирлын чанартайгаар ашигладаг бөгөөд энэ онд ган, зудтай байсантай холбоотойгоор эзэмшлийн газартаа болон төслийн талбайн ойролцоо айлууд нутаглаагүй.	-

#### 4.6 ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Баянхөндий төслийн талбайд ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор судалгаагаар илрээгүй. Гэвч төслийн газар шорооны ажлын явцад соёл өв олдхо магадлалтай. Хэрэв барилгын болон үйл ажиллагааны явцад соёлын өв илэрсэн олдсон тохиолдолд газар шорооны ажлын үйл ажиллагааг түр зогсоож дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

- Барилгын ажлын явцад өмнө нь судалж тогтоож чадаагүй палеонтологи болон археологийн үнэт олдвор илэрвэл илэрсэн даруйд ажлаа зогсоож, олдворын талаар сум/аймгийн Засаг даргад мэдэгдэнэ.
- Бүртгэсэн соёлын өв, түүхийн үнэт олдворын эргэн тойронд эрх бүхий байгууллагын зөвлөмжийн дагуу хамгаалалтын бүс байгуулах ба хөнөөл учруулж болзошгүй үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- Дурсгалт газар, үнэт зүйлс нь эрсдэлд орохоор байвал эрх бүхий байгууллага бүртгэгдсэн тэдгээр зүйлсийг нүүлгэн шилжүүлнэ.
- Чухал ач холбогдол бүхий түүх соёлын олдвор, үнэт зүйлс олдсон тохиолдолд зөөвөрлөнө. Ингэхдээ Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Засгийн газрын 2016



оны 52 дугаар тогтоолын хавсралт “Соёлын биет өвийг зөөж тээвэрлэх журам”-ыг баримтална.

- Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд заавал бүртгүүлнэ.

Хүснэгт 15. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Нөлөөлөлд өртөх түүх соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Баримтласан стандарт, аргачлал	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (сая төгрөг)
Газар шорооны ажлын үед том оврын техник хэрэгслээр хөрс хуулах, суваг шуудуу ухах зэрэг ажил хийгдэх явцад өмнөх судалгааны явцад илрээгүй, хөрсөнд хадгалагдан үлдсэн байж болзошгүй археологи, палеонтологийн олдвор санамсаргүй байдлаар тохиолдож, нөлөөлөлд өртөх	Археологи, палентлогийн олдвор олдсон үед хэрэгжүүлэх зааварчилгааг туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд өгөх	"Эрдэнэ"-ийн бодлого журмын гарын авлага	Баянхөндий төслийн талбайд ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор судалгаагаар илрээгүй. Гэвч төслийн газар шорооны ажлын явцад соёл өв олох магадлалтай учраас үйл ажиллагааны явцад соёлын өв илэрсэн олдсон тохиолдолд авах зааварчилгааг боловсруулж, туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийн ахлах ажилтнуудад танилцуулсан. Хавсралт 17. Археологи, палентлогийн олдвор олдсон үед хэрэгжүүлэх журам	-
	Олдвор илэрсэн тохиолдолд орон нутгийн захиргаа, мэргэжлийн байгууллагад мэдэгдэж, туслалцаа үзүүлэн хамтарч ажиллах	Соёлын өвийг хамгаалах тухай хууль /шинэчилсэн найруулга/, 27.8	Хайгуулын өрөмдлөг, кэмпийн өргөтгөл, ургамал үржүүлгийн талбайд ямар нэг археологи палентлогийн олдвор олноогүй.	-



#### 4.7 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Компанийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа, харуул хамгаалалтын бодлого нь эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа, хамгаалалтын асуудалтай холбоотой эрсдлүүдийг үнэлж, бууруулах журам, зааварчилгаанд дэлгэрэнгүй заасан байдаг ба түүнтэй холбоотой хариуцлага, мониторинг, үнэлгээний зохицуулалтыг тодорхойлсон байдаг.

Төслийн талбай, оффисийн байр бүрд ажлын байран дахь эрүүл мэнд, эрүүл ахуйн арга хандлагыг хэвшүүлэн сахиулдаг. Мөн ажлын байр, талбай нь компанийн бодлого, эрх зүйн шаардлагыг хангаж буй эсэхийг тогтмол хянан шалгадаг. Осол эрсдэлийн үнэлгээ болон тэдгээрээс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг доорх хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 16. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Тоо хэмжээ	Баримтласан стандарт, аргачлал	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (төгрөг)
Гал түймэр гарах	Гал унтраах дасгал сургууль тогтмол зохион байгуулах	4.00	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.4.	Галын аюулгүй байдлын хамгаалалт, галын төрлүүд, галын бүрэлдэхүүн, галын хөнжил, хучилт, түүнийг хэрхэн зөв арга техникээр ашиглах талаар сургалтыг явуулж, сургалтад нийт давхардсан тоогоор 105 хүн хамрагдсан ба гал унтраах дадлага сургуулилалтыг 03 сарын 15, 05-р сарын 15, 08 сарын 15, 10 сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулсан.	Үйл ажиллагааны зардал
	Бүх ажлын талбайд галын дохиолол, аюулын гарцын байрлалыг заасан самбар байрлуулах; галын дохиолол, гал унтраагуур, гал унтраах хоолойд зөвшөөрөгдсөн тэмдэг тавих	Бүх ажлын байранд	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.3	Барих, бүтэц, өөрчлөх, түймрээс хамгаалах тоног төхөөрөмж суурилуулах,	Багор дэгээ 1ш Троссон гөвүүр 1ш Хүрз хумбан 2ш Жоотуу 1ш Шулуун лоом 1ш Конус хувин 8л 2ш Цүдгэр хөрөө 1ш Хадаасны лоом 1ш Жоотуутай сүх 1ш Элсний хайрцаг 1ш Галын хор 4кг 2ш Галын бүтээлэг 1.2x1.2м



			цахилгааны эх үүсвэрийн шугам сүлжээг шинэчлэхдээ эрх бүхий хуулийн этгээдээр галын аюулгүй байдлын магадлал хийлгэсэн зураг төслийг баримтлах	Гал унтраагуур шалгах хуудас Орос шланг Ф50/20 Орос муфьт Ф50/20 Гуулин хаалт /Ф51/мм Резбатай муфьт орос /Ф51/мм Энгийн хошуу /Ф51/ Хомут /Ф51/ Галын гидрантын хайрцаг 60x50x20 Галын хайрцаг 3 төрөл байршуулсан.	
	Галын дохиолол, гал унтраах хоолойг зохих газруудад байрлуулах	Бүх гэр, ажлын байранд		Төслийн талбай дахь бүх байгууламж, гэрүүдэд утаа мэдрэгч дохиолуудыг байрлуулсан. Дохиоллын ажиллагаа хэвийн эсэхийг сар бүр шалгаж, бүртгэл хөтөлдөг.	Үйл ажиллагааны зардал
	Гал унтраагуурыг зохих газруудад байрлуулах,	Бүх гэр, ажлын байранд		Хээрийн анги дахь бүх гэрүүд, байгууламжууд, ажлын талбар бүрт нийт 150 ширхэг галын хор байрлуулсан. Галын хорны үзлэг шалгалтыг сар бүр хийж, даралт унасан тохиолдолд дахин цэнэглүүлдэг.	Үйл ажиллагааны зардал
Хүний эрүүл мэнд муудах	Үндсэн болон гэрээт гүйцэтгэгчдийн ажилтнуудыг “Анхан шатны тусламж үзүүлэх сургалт”-нд хамруулах	Сургалт авсан ажилчдын тоо		Анхан шатны тусламж үзүүлэх сургалтын багц материалыг боловсруулж, 2022 оны туршид 33 сургалт зохион байгуулах төлөвлөгөө гарган, сургалтыг зохион байгуулсан. Төлөвлөгөөний дагуу долоо хоногийн бямба гараг бүрт сургалтыг зохион байгуулдаг. . Хавсралт 18. Анхны тусламж үзүүлэх сургалтын хуваарь	Үйл ажиллагааны зардал
	Үндсэн болон гэрээт гүйцэтгэгчдийн ажилтнуудыг урьдчилан сэргийлэх	Үзлэгт хамрагдсан ажилчдын тоо	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 3, 4 дүгээр бүлэг	Төсөлд шинээр орсон орон нутгийн ажилтнуудыг Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлэгт, Улаанбаатар хот болон бусад газраас орсон ажилтнуудыг Мэргэжлийн өвчин судлалын эмнэлэгт эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулсан. 2022 онд нийт 44 хүн шинээр ажилд орсон байна. Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардал



	эмнэлгийн үзлэгт хамруулах			аюулгүй ажиллагааг хангахын тулд Ковид 19-ээс урьдчилан сэргийлэх зорилгоор ПГУ болон түргэвчилсэн шинжилгээний ажлыг тогтмол зохион байгуулж ажиллаж байна. Гэрээт байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах журмаар шинээр элсэн орох гэж буй гэрээт байгууллагуудад уг шаардлагыг тавин ажиллах ХАБЭА-н хариуцлагын гэрээнд уг заалтыг онцгойлон тусгах арга хэмжээг хэрэгжүүлдэг. Ажилд орохын өмнөх эрүүл мэндийн үзлэгүүдийг үндсэн болон гэрээт байгууллагын ажилчдаас авдаг бөгөөд уг үзлэгийн бүртгэл болон хуудсуудыг мэдээллийн дотоод санд байршуулж тодотголуудыг хийсээр байна.	
	Хүний эрүүл мэнд муудахад анхан шатны тусламж үзүүлэх, шаардлагатай бол тухайн нөхцөлд хамгийн тохиромжтой ойр газар руу нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах эсвэл SOS-ийн тусламж дуудах	Шаардлагатай тохиолдолд	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 3, 4 дүгээр бүлэг	Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлэгтэй байгуулсан гэрээний дагуу төслийн талбайд яаралтай тусламжийн эмч, эсвэл сувилагчыг байнгын байршуулан ажиллуулдаг бөгөөд эрүүл мэндийн яаралтай тусламж үзүүлэх цэг буюу өрөө тасалгаа бүхий байгууламжийг ашиглаж байгаа. Цаашлаад гэмтэж бэртсэн ажилтныг эрүүл мэндийн онцгой яаралтай тусламж авах зохицуулалтыг агаарын тээврийн үйлчилгээний Гео Сан ХХК-нтай хамтран ажиллах гэрээ байгуулах ажлыг зохион байгууллахаар ажиллаж байгаа. Энэ нь гэнэтийн осол тохиолдход яаралтай тусламжийг цаг алдалгүй авах зорилгын хүрээнд төлөвлөгдөж буй ажил билээ.	Үйл ажиллагааны зардал
Автомашинны осол гарах	Талбай дахь замын хөдөлгөөний дүрмийг мөрдөж ажиллах	-	"Эрдэнэ"-ийн бодлого журмын гарын авлага	Төслийн талбай дахь Замын хөдөлгөөний журмыг боловсруулан, журмыг мөрдлөг болгон замын хөдөлгөөнд оролцож байна.	-





	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрмийг мөрдөөгүй тохиолдолд авах арга хэмжээ, шийтгэлийг мөрдөж ажиллах	-	Замын хөдөлгөөний дүрэм Замын аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/, 3 дугаар бүлэг	Төслийн талбай замын хөдөлгөөний аюулгүй ажиллагааны журамд хариуцлага тооцох механизмыг тусгасан.	-
	Тээврийн хэрэгсэл болон жолоочийн хариуцлагын даатгалд бүрэн хамрагдах	-	Замын аюулгүй байдлын тухай хууль	Байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдийн даатгал тэдгээрийн жолооч нарын хариуцлагын болон албан журмын даатгалд хамрагдаж үйл ажиллагаагаа явуулж байгаа.	Үйл ажиллагааны зардал
КОВИД-19 цар тахлын эрсдэл үүсэх	Ажлын бүх талбар, ажилчдын гүйцэтгэх үүрэг даалгавар, өртөж болзошгүй эрсдэлийн эх үүсвэрүүдийг харгалзан ажлын байранд КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах	1.00	Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль	Байгууллагын төслийн үйл ажиллагааны хүрээнд КОВИД халдварт өвчний эсрэг үйл ажиллагааг зохион байгуулах түүний эсрэг арга хэмжээний журам боловсруулан мөрдлөгө болгон үйл ажиллагаагаа явуулсаар ирсэн ба засгийн газрын шийдвэр, эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийг даган биелүүлж ажилласаар байгаа билээ. Байгууллага төслийн талбайд ирж ажиллах үндсэн болон гэрээт бүхий л ажилтан албан хаагчдыг түргэвчилсэн шинэжилгээнд хамруулж байгаа ба энэхүү процесс одоог хүртэл хэрэгжсээр байна.	Үйл ажиллагааны зардал



Галын аюулгүй байдлын хамгаалалт, галын төрлүүд, галын бүрэлдэхүүн, галын хөнжил, хучилт, түүнийг хэрхэн зөв арга техникээр ашиглах талаар сургалтыг явуулж, сургалтад нийт давхардсан тоогоор 105 хүн хамрагдсан ба гал унтраах дадлага сургуулилалтыг 03 сарын 15, 05-р сарын 15, 08 сарын 15, 10 сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулсан.



Зураг 38. Гал унтраах сургалт, дадлага

Бүх ажлын талбай, гэрүүдэд галын дохиолол, гал унтраагуур, аюулын гарцын байрлалыг заасан самбар байрлуулсан.



Зураг 39. Гал унтраах багаж, хэрэгсэл

Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлэгтэй байгуулсан гэрээний дагуу төслийн талбайд яаралтай тусламжийн эмч, эсвэл сувилагчийг байнгын байршуулан ажиллуулдаг бөгөөд эрүүл мэндийн яаралтай тусламж үзүүлэх цэг буюу өрөө тасалгаа бүхий байгууламжийг ашиглаж байгаа. Төслийн талбайд ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтан нь Бямба



Хог хаягдлын сөрөг нөлөөлөл болон түүний хэмжээг бууруулахад 17 сая төгрөг зарцуулсан ба дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Эдгээрт:

- Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, хуулийн шаардлагад нийцсэн хогийн цэгийг зонхилох салхины чиглэлийн доор байрлуулж, хог хаягдлыг түр хадгалдаг.



Зураг 41. Хог хаягдлыг түр хадгалах цэг

- Оффис, гэр, контейнер сууцуудад, гадна талбайн шаардлагатай байршлуудад хог ангилан хаях зориулалттай ногоон болон хар өнгийн хогийн савнууд, гал тогоонд хоолны үлдэгдэл, өндөгний хальс, хуванцар хаягдал хаях савнуудыг хангалттай хэмжээгээр байрлуулсан.



Зураг 42. Хог хаягдлыг түр хадгалах цэг

- Хог хаягдлыг зохистойгоор хаяж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажлын байрны шалгалт тогтмол явуулж, ажилчдад заавар зөвлөмжийг тогтмол өгсөн. Мөн хээрийн ангийн ойр орчим, ажлын талбай бүрт хог хаягдлыг Ням гараг бүрт тогтмол цэвэрлэдэг.



Зураг 43. Хог хаягдлыг хэрхэн ангилан хаях талаарх сургалт

- Цугларсан хогийг сумын нэгдсэн хогийн цэгт тээвэрлэн нийлүүлсэн. Тайлант онд нийт 6 удаагийн тээвэрлэлтээр 5 тн хог хаягдлыг шилжүүлсэн.

**ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛСЭН БАРИМТ**

Огноо: *2022.09.07*

Хүлээн авагч байгууллагын нэр, хаяг:  
Шинэжинст сумын тохижилт үйлчилгээний алба

Хог хаягдал тушаасан байгууллагын нэр, хаяг:  
“Эрдэнэ Монгол” ХХК 89984224

№	Хог хаягдлын нэр	Тоо хэмжээ /кг/
1	Үнс	
2	Ахуйн хаягдал	<i>2тн</i>
3	Хоолны үлдэгдэл	<i>1тн</i>
	Бусад	

ТУШААСАН:  
“ЭРДЭНЭ МОНГОЛ” ХХК-НИЙ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН *Н.О.Г.* П.ӨЛЗИЙ-УНДРАХ  
ХҮЛЭЭН АВСАН:  
ШИНЭЖИНСТ СУМЫН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ  
ДАРГА *О.ЧОЙЖИЛСҮРЭН*



Зураг 44. Хог хаягдлын нийлүүлэлт

- Кемпийн гадна талын нүхэн жорлонг буулгаж, хаягдлыг хөрсөнд шингэхээс сэргийлэх зорилгоор танк суурьлуулж, эко жорлон байгуулсан.



Зураг 45. Нүхэн жорлонгийн шинэчлэл

- Хээрийн ангийн ариутгал, халдваргүйтлийг 14 хоног тутам хийдэг ба хог хаягдлын цэгийг хог ачсны дараа тухай бүрт ариутгаж байна. Урьдчилан сэргийлэлт, шавжгүйтэл, мэрэгчгүйтэйл ариутгал халдваргүйжүүлэлтийг Баянхонгор аймгийн Бурхант эх ХХК-аар 05 сарын 29-30-ны өдрүүдэд хийлгэсэн.

**14 хоног тутмын ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн тайлан**  
**Weekly Disinfection Report**

Халдваргүйжүүлэлт хийсэн өдөр (Date of Disinfection)	Халдваргүйжүүлэлт ашигласан бодис (Type of chemicals)	Халдваргүйжүүлэлт хийсэн байршил (Location)	Халдваргүйжүүлэлт хийсэн ажилтны нэр (Person responsible)	Хянасан нөмрөл менежер (Manager who checked)	Хавсралт
2022.09.26	Ариун, Жавелин (Alpin, Sanitizer Javein)	Нийтийн ариун цэврийн өрөө	Б.Сугар-Эрдэнэ	Б.Болдбат	Зураг хавсаргав

Компаний нийтийн зориулалтын бусад 14 хоног тутам ариутгал хийгдэж байна. Мөн хаалганы барилд, нийтийн ариун цэврийн өрөөний барилд, угсаатнуурын холигч, бохионы даралт гэмт хүний гар байнга хурч байдаг хэсгүүдэд өдөрт 2-3 удаа ариутгалын бодисоор ариутгаж байна.

Зураг 46. Ариутгал халдваргүйжүүлэлт

- Эмнэлгийн хог хаягдлыг зориулалтын битүүмжлэлтэй саванд нарны тусгалаас сэргийлэн, битүүмжлэн хадгалж, Шинэжинст сумын хүн эмнэлэгт 19.7кг халдвартай, 3.1кг хурц үзүүртэй, иртэй хог хаягдлыг хүлээлгэн өгсөн.



Хог ачинг тээвэрлэсэн Он сар өдөр	Халдвартай хог хаягдал /кг-аар/	Хурц үзүүртэй иртэй хог хаягдал /кг-аар/	Эмтэг хог хаягдал /кг-аар/	Эмийн болон эсэд хортой хог хаягдал /кг-аар/	Химийн хог хаягдал /кг-аар/	Цацраг идэвхит хог хаягдал	Хүлээлгэн өгсөн хүний гарын үсэг	Хүлээн авсан хүний гарын үсэг
2022.02.02	14.9kg	18kg-100%	-	-	-	-	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
2022.4.22	7kg	-	-	-	-	-	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
2022.8.22	3.8kg	8kg	-	-	-	-	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
2022.9.20	7kg	-	-	-	-	-	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
2022.10.20	-	-	-	-	-	-	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>

Зураг 47. Эмнэлгийн хог хаягдал

- Орон нутагт жижиг, дунд бизнесийг дэмжих зорилгоор хог хаягдлыг тээвэрлэх, устгах аж ахуйн нэгжийг байгуулах, сумын хог хаягдлын менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлэн хамтран ажиллахаар төлөвлөж, аж ахуйн нэгжүүдтэй холбогдох, төсөл боловсруулах ажлуудыг эхлүүлээд байна.



Хүснэгт 17. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хаягдлын эх үүсвэр	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Баримтлах стандарт, аргачлал	Тоо хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (сая төгрөг)
Уурхайн тосгон, оффис, аж ахуйн барилга	Ахуйн гаралтай хатуу хог хаягдал	Ахуйн болон барилгын хаягдал түр хадгалах цэгийг бэлдэх	Хог хаягдлын тухай хууль 2017 он; МУЗГ-ын 2018 оны 116 дугаар тогтоол, БОАЖС-ын 2018 оны "Аргачилсан заавар батлах тухай" А/445 тушаал	1	Хээрийн ангийн үйл ажиллагаанаас гарч байгаа хогийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны “Тавигдах шаардлага батлах тухай” А/443, “Аргачилсан заавар батлах тухай” А/445 тушаалуудын дагуу байгуулж, журмын шаардлагыг хангасан түр хадгалах цэгт хуримтлуулж байна. Энэхүү түр хуримтлуулах цэг кэмпээс зүүн урд зүгт буюу салхины зонхилох чиглэлийн доор 300м зайтай ба хог хаягдлыг хийсгэхгүй байхаар битүү тагтай ба хог ачих тээврийн хэрэгсэл ухран орж хогийг авдаг. Хогийн цэг нь гадуураа хашаатай ба хаягжуулсан, үерийн хамгаалалтын далантай.	Үйл ажиллагааны зардал
		Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан хаях сургалтыг зохион байгуулах	Хог хаягдлын тухай хууль 2017. “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт”	Уурхайн талбайд ажиллахаар анх удаа ирж буй ажиллагсад болон зочдод ажил эхлүүлэхээс өмнө сургалтыг тогтмол хийх	Даваа гараг бүрийн өглөөний уулзалт дээр хог хаягдлыг зориулалтын саванд ангилан, эзэлхүүнийг багасган хаяхыг сануулдаг ба хээрийн ангийн ерөнхий зааварчилгаанд эх үүсвэр дээр нь ангилах хаяхыг тусгасан байдаг. Мөн ээлж солилцох бүрт ахлах ажилтанд хог хаягдлыг ангилан хаях талаар зааварчилгааг өгдөг. Хээрийн анги дотор хуванцар болон пластик хог хаягдлыг хаях ногоон өнгийн 7ш, бусад хог хаягдлыг хаях саарал өнгийн 9, гэрүүдэд 20л багтаамжтай сав 2ш, байгууламжуудад 50л багтаамжтай 2ш хогийн савыг байршуулсан. Мөн нөөцөд хогийн савыг хангалттай хэмжээгээр худалдан авсан.	6,640.0
		Ялгаруулж буй хог хаягдлыг	Хог хаягдлын тухай хууль 2017.	Гаргасан хог хаягдлын хэмжээгээр	Хог хаягдлыг органик, органик биш, дахин ашиглагдах гэж ангилан өдөр бүр бүртгэдэг. Хээрийн ангийн оршин суугчдын тооноос хамааран хоногт дунджаар 2 кг	-



Ахуйн гаралтай шингэн хаягдал	өдөр бүр ангилан бүртгэх			органик, 6.5 кг органик биш, 4.5 кг дахин ашиглагдах хог хаягдал гардаг. Энэ онд нийт 549.8 кг органик, 1713.8 кг органик биш, 957.3 кг дахин ашиглагдах, 1187.3 кг үнсний хаягдал гарсан.	
	Хог хаягдлыг ангилан зөвшөөрөгдсөн цэгт түр хадгалах	Шинэжинст сумын Тохижилт үйлчилгээний албатай байгуулсан гэрээ	Гаргасан хог хаягдлын хэмжээгээр	Шинэжинст сумын Тохижилт үйлчилгээний албатай “Хог хаягдлын талаар хамтран ажиллах гэрээ”-г 2021.11.16-нд байгуулсан. Хог хаягдлыг энгийн, хуванцар, аюултай хог хаягдал гэж ангилан түр хуримтлуулах цэгт хадгалж байна. Хог хаягдлыг 10-14 хоногт 1 удаа сумын төвийн нэгдсэн хогийн цэгт нийлүүлэхээр тээвэрлүүлдэг.	6,250.0
	Бохирын септик систем суурьлуулах	Усны тухай хууль, MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин, усны чанар, хаягдал ус. Техникийн ерөнхий шаардлага	1	Баянхөндий кемпийн бохирын схемийг боловсруулсан, 2023 онд барилгын ажил эхлэхээс өмнө кемпийн хүчин чадалд тохируулан септик танк суурьлуулах ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Кемпийн гадна орон нутгийн иргэд болон харуул хамгаалалтын ажилтнуудад зориулсан нүхэн жорлонг буулгаж эко жорлон байгуулсан.	4.050.0
Бохир ус цэвэршүүлэх байгууламж барьж, ашиглалтад оруулах	Усны тухай хууль, MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин, усны чанар, хаягдал ус. Техникийн ерөнхий шаардлага	1	Бохир ус цэвэрлэх байгууламжийн зураг, төсөл батлагдсан, барилгын ажил эхлэхээр хамгийн түрүүнд цэвэршүүлэх байгууламжийг барихаар төлөвлөж байна. Хавсралт 19. Баянхөндий төслийн бохирын ерөнхий схем	-	





		Усыг хэмнэлттэй хэрэглэх талаар сургалт зохион байгуулах	-	Уурхайн талбайд ажиллахаар анх удаа ирж буй ажиллагсад болон зочдод ажил эхлүүлэхээс өмнө сургалтыг тогтмол хийх	Усны нөөцийг хэмнэлттэй ашиглах талаар хээрийн ангийн ерөнхий зааварчилгаанд тусгасан ба ариун цэврийн өрөөнүүдэд 3 төрлийн бш зөвлөмжүүдийг байршуулсан.	-
Барилгууд, уурхайн агуулах	Барилгын хог хаягдал	Хог хаягдлыг түр хадгалах цэгт нийлүүлэх	Хог хаягдлын тухай хууль, Шинэжинст сумын Тохижилт үйлчилгээний албатай байгуулсан гэрээ	-	Барилгын ажил хойшлогдсон тул 2022 онд барилгын хог хаягдал гараагүй. Барилгын хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй орон нутгийн ААН-ийг чадавхижуулж, хамтран ажиллах бэлтгэл хийгдэж байна.	Үйл ажиллагааны зардал
Эмнэлэг	Аюултай хог хаягдал	Хог хаягдлыг бүртгэх	Хог хаягдлын тухай хууль, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/505 тушаал, Шинэжинст сумын Хүн эмнэлэгтэй байгуулсан хог хаягдал	Гаргасан хог хаягдлын хэмжээгээр	Төслийн анхны тусламжийн цэгээс гарсан эмнэлэгийн хог хаягдлыг Эрүүл мэндийн сайдын 2011 оны 158 тоот “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, халдваргүйтгэх, устгах заавар батлах тухай” тушаалын дагуу хог хаягдал үүсэх бүрт бүртгэдэг.	-



			нийлүүлэх гэрээ 2021			
		Эмнэлгийн аюултай хог хаягдлыг зааврын дагуу хадгалан, Шинэжинст сумын эмнэлэгт нийлүүлэх	-	Сумын эмнэлэгт нийлүүлсэн хог хаягдлын хэмжээгээр	Эмнэлгийн хог хаягдлыг зориулалтын битүүмжлэлтэй саванд нарны тусгалаас сэргийлэн, битүүмжлэн хадгалж, Шинэжинст сумын хүн эмнэлэгт 19.7 кг, халдвартай, 3.1 кг хурц үзүүртэй, иртэй хог хаягдлыг хог хаягдлыг хүлээлгэн өгсөн.	Үйл ажиллагааны зардал
Засварын цэг	Аюултай хог хаягдал	Хог хаягдлыг бүртгэх	Хог хаягдлын тухай хуулийн 5-р бүлэг 23-р зүйл	Гаргасан хог хаягдлын хэмжээгээр	Барилгын ажил хойшлогдсонтой холбоотойгоор засварын цэг байгуулах ажил хийгдээгүй. хог хаягдал ангилах, цуглуулах, шилжүүлэх журмын хавсралтаар Аюултай хог хаягдлыг бүртгэх маягтыг боловсруулсан.	-
		Шингэн тосны хаягдлыг зориулалтын саванд хадгалан, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх		Нийлүүлсэн хог хаягдлын хэмжээгээр	Хээрийн ангид техникийн засвар үйлчилгээ хийгддэггүй, хээрийн ангид очихоос өмнө шаардлагатай засвар үйлчилгээг хийсэн байхыг туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдээс шаарддаг. Тиймээс шингэн тосны хаягдал гараагүй.  Хавсралт 20. Аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, шилжүүлэх, тээвэрлэх журам	-
		Ашиглалт дууссан эд ангийг зориулалтын цэгт хадгалан хаягдал төмрийг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Хог хаягдлын тухай хууль 2017.	Нийлүүлсэн хог хаягдлын хэмжээгээр	Засварын цэгийн барилгын ажил хойшлогдсон тул хаягдал төмөр гараагүй.	-



		Тосоор бохирдсон арчих материал зэрэг аюултай хог хаягдлыг зориулалтын цэгт хадгалах	Хог хаягдлын тухай хууль 2017.	Нийлүүлсэн хог хаягдлын хэмжээгээр	Хээрийн ангид техникийн засвар үйлчилгээ хийгдэггүй, хээрийн ангид очихоос өмнө шаардлагатай засвар үйлчилгээг хийсэн байхыг туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдээс шаарддаг. Тиймээс тосоор бохирдсон арчих материалын хаягдал гараагүй.	-
		Аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр тээвэрлүүлэн, нийлүүлэх	Хог хаягдлын тухай хууль 2017.	Нийлүүлсэн хог хаягдлын хэмжээгээр	Аюултай хог хаягдлыг тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй Хай би ойл ХХК-тай “Аюултай хог хаягдал нийлүүлэх гэрээ”-г 2022 оны 07 сарын 01-нд байгуулсан. Хээрийн ангийн, хайгуулын үйл ажиллагаанаас аюултай хог хаягдал ялгараагүй.  Хавсралт 21. Аюултай хог хаягдал нийлүүлэх гэрээ	-
Хаягдлын мэдээллийн сан хөтлөх, ажиллагсад хаягдлын менежментийн сургалт зохион байгуулах				2 удаа	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны “”Маягт батлах тухай” А/444 тушаалын дагуу энгийн болон аюултай хог хаягдал үүсгэгчээр бүртгүүлсэн. Хаягдлын мэдээллийн санг үүсгэн хөтөлж байгаа ба хаягдлын менежментийн талаарх сургалтыг хээрийн ангийн бүх оршин суугчдад 06 сарын 22 болон 08 сарын 07-ны өдрүүдэд зохион байгуулсан. Хавсралт 22. Хог хаягдлын журмын сургалтын материалыг хавсаргав.	Үйл ажиллагааны зардал

#### 4.9 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийг хэрэгжүүлэхдээ тухайн дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, дүйцүүлэн хамгаалах, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг төсөл хэрэгжүүлэгч “Эрдэнэ Монгол” ХХК хүлээсэн. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд орчны



хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсан байдаг.

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмын 5.4, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.7 заалтыг удирдлага болгон төслийг хэрэгжүүлэх явцад “Эрдэнэ Монгол” ХХК-аас байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон байгалийн бүрдэл тус бүрээр орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)-т тусгагдсан. Баянхөндий төслийн 2022 онд хэрэгжүүлэх ОХШХ-ийг хэрэгжүүлэхэд 59.7 сая төгрөг зарцуулсан.

Хүснэгт 18. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Давтамжийн тоо	Баримтласан стандарт, аргачлал	Хэрэгжилт	Зарцуулсан хөрөнгө (сая төгрөг)
<b>ГАЗРЫН ГАДАРГА, ХЭВЛИЙ</b>					
Байгаль орчны аудит хийлгэх	Уурхайн талбай	1	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 10 <sup>1</sup> заалт. 1995 он	Байгаль орчны хууль тогтоомжийн нийцлийн аудитыг Энвайроментал комплайнц ХХК-аар 04 дүгээр сард гүйцэтгүүлсэн. Энэхүү аудитын дүгнэлтээр кемпийн гадна байгаа нүхэн жорлонг солих, экологийн паспортыг хөтлөх арга хэмжээг зөвлөмж болгосны дагуу эдгээр ажлуудыг хэрэгжүүлж ажилласан.	49,962.0
Хөрсний чанар - Хими, физикийн ерөнхий үзүүлэлтүүд	Уурхайн барилга байгууламжуудын талбайн орчимд	6 цэг	MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсны дагуу хөрсний өнгөн хэсэг дэх хүнд металлын агууламжийг тодорхойлох дээжийг 6 цэгээс шинжилгээг авч Ханлаб лабораторид төлөвлөгөөний дагуу 3 удаа хийлгэсэн, Хөрсний дээжинд хийлгэсэн шинжилгээний дүнгээр зарим хүнцлийн агууламж стандартаас давсан үзүүлэлттэй байна. Хавсралт 23. Хөрсний шинжилгээний хариу	0,600.0
Ялзмагийн агууламж (%), урвалын орчин (рН), карбонат (CaCo3), шингээгдсэн	Уурхайн барилга байгууламжуудын талбайн орчимд	4 цэг	Хөрс. Дээж авах, савлах, тэвэрлэх, хадгалах журам MNS 2305:1994	Одоогийн байдлаар хөрсөн дэх ялзмагийн агууламжийг тодорхойлох шинжилгээг Инженер геодези ХХК-ийн лаборатори хийж байгаа ба тус лабораторитой холбогдоход ялзмагийг тодорхойлох	Үйл ажиллагааны зардал



сууриуд (Ca <sup>2+</sup> , Mg <sup>2+</sup> ), хөрсний шим тэжээлийн элементүүд болох азот (N), фосфор (P), кали (K), давсжилт буюу цахилгаан дамжуулах чадвар (EC2.5 dS/m)				шинжилгээ хийхгүй байгаа гэсэн хариу өгсөн. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсны дагуу хөрсний өнгөн хэсэг дэх хүнд металлын агууламжийг тодорхойлох дээжийг 6 цэгээс шинжилгээг авч Ханлаб лабораторид төлөвлөгөөний дагуу 3 удаа хийлгэсэн, Хөрсний дээжинд хийлгэсэн шинжилгээний дүнгээр зарим хүнцлийн агууламж стандартаас давсан үзүүлэлттэй байна.	
<b>УУР АМЬСГАЛ</b>					
Цаг уур (агаарын хэм, салхины хурд, чиглэл, харьцангуй чийгшил, даралт, бороо цас, ууршилт, нарны цацрагжилт)	Төслийн талбай	Тогтмол	Цаг уур, орчны хяналт шинжилгээний заавар ШЗ.П.01.03.2014 (Цаг уурын ажиглалт, хэмжлийн технологийн заавар XIV дэвтэр. Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур орчны шинжилгээний газар)	Төслийн талбайд суурьлуулсан агаар дахь тоосонцорыг хэмжих 2 багажаар PM 2.5 болон PM 10 тоосонцорыг 24 цагийн турш тасралтгүй хэмжиж байна. Цаг уур, орчны шинжилгээний газраас 1980.01.01-ээс 2022.04.30-ыг дуусталх агаарын температур, хур тунадасны мэдээг Эхийн гол, Жинст станцын мэдээг авсан.	Үйл ажиллагааны зардал
Шатахууны хэрэглээг бүртгэх	Тээрийн хэрэгслүүд	Сард 1 удаа	MNS ISO 14064-1-2015. Хүлэмжийн хий – Нэгдүгээр хэсэг - Байгууллагын түвшинд хүлэмжийн хийн ялгарал ба шингээлтийг тооцоолох, тайлагнах тухай зааварчилсан удирдамж	Төслийн үйл ажиллагаанд тайлант онд нийт 11.6тн шатахуун, 72.3тн дизель түлш хэрэглэсэн	-
Нүүрсний хэрэглээг бүртгэх	Түр кэмп	Сард 1 удаа		Хээрийн ангийн гэрүүдийг нүүрсээр галлан халаадаг, 2748 кг нүүрс ашигласан.	Үйл ажиллагааны зардал



АГААРЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ					
Суурин станцаар: Орчны агаар дахь зарим хийнүүд /SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> /	Тусгай зөвшөөрлийн талбайн зүүн урд, хойд зах	Тогтмол	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага	Pro Rae II багажийг завсар хийх, дахин тохируулахаар Канад улс руу явуулсан. Хэвийн ажилладаг блосны дараа хэмжилтийг хийх болно.	Үйл ажиллагааны зардал
Суурин станцаар: Агаар дахь том болон жижиг ширхэглэгт тоосонцор		Тогтмол			Dust track TSU багажаар PM 2.5 болон PM 10 тоосонцорыг 24 цагийн турш тасралтгүй хэмжиж байна.
Нөлөөллийн бүсэд айл өвөлжих тохиолдолд айлын ойр орчимд дуу шуугиан, агаар дахь тоосонцорыг хэмжих	Айлын өвөлжөөний орчим	Сард 1 удаа	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага	Төслийн талбайн ойр орчимд 2022 онд нутгийн айл өрх нутаглаагүй.	-
ГАЗРЫН ДООРХ УС					
Нутгийн иргэдийн хамтын оролцоотой мониторингийн хөтөлбөр хэрэгжүүлж эхлэх	Гүн заг, Майхан хүрэн, Хүрэн цав, Өргөө, Босго, Хоолой худаг	Улиралд 1 удаа	Санал, гомдол шийдвэрлэх механизм	Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон Шинэжинст сумын Т.Алтангэрэл, Баян-Өндөр сумын Ш.Цогбадрах нартай ярилцан хэмжилт хийх худгийн тоог нэмэгдүүлж, оролцох иргэдийн хуваарийг гаргасан. Бямба гараг бүрт Шинэжинст сумын Майхан хүрэн урд, хойд, Гүн заг, Сухайн худаг, Гашуун худаг, Хөвт хүрэн, Хүрэн цавын худгуудад, Ням гараг бүрт Баян-Өндөр сумын Өргөө, Босго, Таван худгийн дээд, доод, Холбоо хүрэн, Их, жижиг арын ус, Захын хөх, Үзүүр хар, Гүндалай, Гурван худгийн дээд, доод худгуудад усны түвшний хэмжилт хийж байхаар тохиролцсон. Шинэжинст сумын иргэн Т.Алтангэрэлтэй 09 сарын 24, Баян-Өндөр сумын иргэн Ш.Цогбадрахтай 10 сарын 12-ны өдрүүдэд худгийн усны түвшний хэмжилтийг хийсэн ба бусад товлосон хугацаанд малчид хувийн ажилтай байсан тул хэмжилтэд оролцож чадаагүй.	1,056.0



Усны чанарын шинжилгээ	Гүн заг, Майхан хүрэн, Хүрэн цав худгууд	2022 оны II, IV улиралд	MNS 0900:2018 Хүрээлэн байгаа орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ	Тусгай зөвшөөрлийн талбайн ойролцоох худгуудын усны чанарын шинжилгээг улирал бүрийн сүүлийн саруудад Ханлаб лабораторид хийлгэж байна. Шинжилгээний хариугаар Гүн заг худаг ундны усны стандартын шаардлага хангаж байгаа бол бусад худгууд усны хатуулаг стандартаас 2-3 дахин өндөр ундны усанд хэрэглэхэд тохиромжгүй гэсэн дүгнэлт гарсан. Хавсралт 24. Гүн загийн худгийн усны шинжилгээний хариу	1,056.0
	Кэмпийн болон үйлдвэрийн ус хангамжийн худгууд	Улиралд 1 удаа	MNS 0900:2018 Хүрээлэн байгаа орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ	Хээрийн ангийн ахуйн хэрэглээний усанд усны чанарын шинжилгээг улирал бүрийн сүүлийн саруудад Ханлаб лабораторид шинжилгээ хийлгэж байна. Шинжилгээний дүнгээр натри, кальци, хлор, сульфат, хатуулаг, усанд ууссан бодис, стронци зэрэг элементүүд зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан. Хавсралт 25. Майхан хүрэнгийн худгийн усны шинжилгээний хариу	-
Усны түвшний хэмжилт	Тусгай зөвшөөрлийн талбайн ойролцоох худгууд	14 хоногт 1 удаа	"Эрдэнэ"-ийн бодлого журмын гарын авлага	Тусгай зөвшөөрлийн талбайн ойролцоох 7 худгийн усны түвшний хэмжилтийг Бямба гараг бүрт хийдэг. Хавсралт 26. Малчдын худгийн усны түвшний хэмжилт	1,499.0
<b>УРГАМЛАН НӨМРӨГ</b>					
10x10 м талбай дахь ургамлын зүйлийн бүрдэл, ургамлын тусгаг бүрхэц, арви, 1x1 м талбайгаас газрын дээрх биомасс авах	Шар хотир-Пржевалскийн зээргэнэ – Регелийн шар модот, Жижиг сийрэг заг – Шар хотир – Пржевалскийн зээргэнэт болон Шар хотир – Пржевалскийн	1 удаа	Тухайн бүлгэмдэлд ургаж буй ургамлын зүйлийн баялагийг тодорхойлох; Ургамлын зүйлүүдийн (элбэгшил-abundace) арвийг Drude’s scale-ээр үнэлэх; 10x10 м талбайн ургамал, хагд,	БОМТ-д заасны дагуу нийт 9 цэгт ургамлын хээрийн судалгаа хийсэн. Ил уурхайн ус шавхалтаас түвшин буурах 850 м-ийн радиуст 1 цэгт радиусаас гадна 1 цэгт энэ хоёр цэгт чийг дутсан маш хуурай, ургамлан бүрхэц 10x10м талбай дахь ургамлын зүйл багатай бүрхэц 30% шар хотир зүүн гарын бударгана сор2. Био масс авсан худгуудын ойролцоох 2 цэгт чийг муу биш, 10x10м талбай дахь ургамлын бүрхэц 30% 1x1м талбайд 40% сухай зүүн гарын бударгана /бутаргана/ сийрэг загтай сор2.	1,000.0



	зээргэнэт бүлгэмдлүүд, Сийрэг заг-Пржевальскийн зээргэнэ-Сухайт болон Сийрэг заг-Шар хотир-Пржевальскийн зээргэнэт бүлгэмдэлд		халцгай газар гэх мэт газрын бүрхцийг Браун-Бланке-ийн аргаар нүдэн баримжаагаар үнэлэх; 1x1 м талбай байгуулан ургамлын газрын дээрх биомассын дээж авч, ургамлын бүрхцийг (Раменский, 1938) үнэлэх; 2019 оны ургамлан нөмрөгийн хээрийн судалгааны үр дүн	Кемпээс 7км зам дагуу 2 цэгт доройтоогүй чийг дутсан хуурай 10x10м-д ургамлан бүрхэц 10% 1x1м-д 10% шар хотир, зүүн гарын бударгана байсан, кемпээс Шинэжинст сумын төв орох зам дагуу 3 цэгт 10x10м ургамлан бүрхэц 40%, 1x1м ургамлан бүрхэц 40% заг, зүүн гарын бударгана сор1-байна.	
Ургамалд тоосжилтоос үзүүлж буй нөлөөг биомасс, навчны талбайн индексээр (leaf area index) эсвэл ургамлын физиологийн аргаар тодорхойлох	Уурхайн дотоод, гадаад тээврийн зам дагуу, салхины дээд болон доод талд	1.00	Баянхөндий төслийн БОННУ, БОМТ 2021-2025	Хур тунадас бараг ороогүй, гантай байсан учраас ургамал тоосжилттой харагдна.	Үйл ажиллагааны зардал
Талбай дахь ургамлуудыг бүртгэх	Газар хөндөх зөвшөөрөл олгох бүрт	Зөвшөөрөл хүсэх бүрт	Ургамалын бичиглэл хийх аргачлал	Төслийн БОННУ-д заасны дагуу төслийн талбайд ургамалын бичиглэлийн хээрийн судалгааг 2022 оны 08 сард хийсэн. Хавсралт 27. Ургамалын хээрийн бичиглэлийн судалгааны дүн	Үйл ажиллагааны зардал
Нутгийн иргэд, байгаль хамгаалагчтай хамтран ургамлын бичиглэл хийх	Сонгогдсон талбайд	2.00	Санал, гомдол шийдвэрлэх механизм	Төслийн БОННУ-д заасны дагуу төслийн талбайд ургамалын бичиглэлийн хээрийн судалгааг 2022 оны 08 сард хийсэн. Судалгааны хүрээнд Хүрэн цавын худгийн орчимд 2 цэг дээр Уртын гол багийн 2 иргэн оролцсон.	Үйл ажиллагааны зардал





				Хавсралт 27. Ургамалын хээрийн бичглэлийн судалгааны дүн	
<b>АМЬТНЫ АЙМАГ</b>					
Төслийн талбайд тохиолдох мөлхөгч, шувуу, хөхтний зүйлийн бүрдэл, тохиолдсон бодгалийн тоо, байршил	Уурхайн талбайд	2.00	Баянхөндий төслийн БОННУ, БОМТ 2021-2025	Төслийн талбай дотор болон ойр орчимд, худгуудын усны түвшний хэмжилт хийх замд амьтан харагдах бүрт бүртгэдэг, 2022 онд мөлхөгч 2 зүйл, шувуу 24 зүйл, хөхтөн 3 зүйл ажиглагдсан. Хавсралт 13. Амьтны бүртгэлийг хавсаргав.	-
Жороо тоодог (Chlamydotis undulata)-ийн тоо толгой, нягшилыг үнэлэх. голлох амьдрах орчныг тодорхойлох. Энэ зүйл шувууг гөрөөлөгч амьтан болох үнэг, хярсны нягтшил, харьцангуй элбэгшлийг үнэлэх, мөн цаашид явуулах хяналт шинжилгээний талбай, замналыг тодорхойлох.	Төслийн талбайгаас 20 км радиус дотор хатуу хайрган хөрс бүхий Заг, зээргэнэ, хармаг, хотир, бүйлс, орог тэсэг, бударганат бүлгэмдэлд	2.00	Монгол орны шувууны Улаанданс, 2011 болон шувуу судлаачдын судалгааны бүтээл	Улаан хайгуулын талбайд үнэг 1 бодгаль бүртгэсэн. Жороо тоодог бүртгэгдсэн газарт ажиглалтыг 06, 10 саруудад хийсэн, бүртгэгдээгүй. Жороо тоодог тэмдэглэгдсэн газрын эргэн тойронд 100 гаран км ажиглалт хийсэн. Энэ онд бүртгэгдээгүй ч гэсэн дараагийн жилүүдэд үргэлжлүүлэн ажиглалт хийнэ.	-
Хар сүүлтийн тоо толгой, нягтшлыг үнэлж, нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг хөдөлгөөнийг сансрын дамжуулагчтай хүзүүвч ашиглан судлах	Төслийн талбай, түүний орчмын тохиолдож болох амьдрах орчин	Жилийн турш	Баянхөндий төслийн БОННУ, БОМТ 2021-2025	Хар сүүлтийг бүртгэж байгаа, хүзүүвч зүүх ажлыг төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор хойшлуулсан. Мэргэжлийн байгууллагаар хийлгэх, тандан судалгааны үр дүнд үндэслэн хийнэ.	-



“Эрдэнэ Монгол” ХХК-ийн MV-021444 дугаартай “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Тусгай зөвшөөрлийн талбайн ойр орчмын амьтныг бүртгэх	Амьтан таарах бүрд	Амьтан таарах бүрд	Ажиглалтын арга	Төслийн талбай дотор болон ойр орчимд, худгуудын усны түвшний хэмжилт хийх замд амьтан харагдах бүрт бүртгэдэг, 2022 онд 30 зүйлийн амьтан 103 удаа ажиглагдсан.	Үйл ажиллагааны зардал
Нутгийн иргэд, байгаль хамгаалагчтай хамтран амьтан бүртгэх	Сонгогдсон цэгт	2.00	Санал, гомдол шийдвэрлэх механизм	Хар сүүлтийн тархац, байршлын талаар нутгийнхантай мэдээлэл солилцдог. Хамтын оролцоотой мониторинг хөтөлбөрийг худгийн усны төвшин хэмжих ажилд хэрэгжүүлж эхэлсэн ба цаашид амьтны ажиглалтаар өргөжүүлэхээр хэлэлцэж байна.	1,000.0



#### 4.10 АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

“Эрдэнэ Монгол” ХХК нь 2022 оны 10 дугаар сарын 15-ны байдлаар төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны байгууллагуудын нийт 5 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтад хамрагдсан. Шалгалтуудын үр дүнгээр торгууль, шийтгэвэр, албан шаардлага аваагүй.

Хүснэгт 19. Хяналт шалгалтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт

Д/д	Шалгагч	Шалгагдсан огноо	Шалгалтын дүгнэлт, зөвлөмж, зөрчил	Зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ
1	БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын БОУАХ, УУХҮЯ-ны Уул уурхайн бодлогын газар, АМГТГ, Усны газар, Баянхонгор аймгийн МХГ, иргэн Э.Дагвасамбуу, н.Чогсом	2022.04.07-04.13	Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна гэж үзсэн бөгөөд ажлын хэсгээс гаргасан санал дүгнэлт болон орон нутгийн иргэдээс тавьж буй шаардлагыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах нь зүйтэй. Усны чиглэлээр дүгнэлт гаргах, зөвлөгөө, мэдээлэл өгөх үүрэг бүхий шинжээчийн баг томилон ажиллуулах шаардлагатай. Заган ойн давхцалтай байгааг аймгийн ой зохион байгуулалт хийгдсний дараа хуульд нийцүүлэх. БОННУ-г шүүхийн шийдвэр гарсны дараа холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Хуулийн дагуу тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийг хариуцлагагүй уул уурхай эрхлэгчтэй ижил байдлаар хандаж эсэргүүцэж байгаад иргэдэд чиглэсэн тодорхой ажлуудыг зохион байгуулах.	Усны газрын даргын 2022.04.22-ны “Шинжээч томилох тухай” тушаалын дагуу Усны нөөцийн хэлтсийн дарга Я.Болдбаатараар ахлуулсан ажлын хэсэг газар дээр нь шалгалт хийсэн. Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/561 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн Ус, Ойн шалгалтын хэсэг 09 сарын 14,15-ны өдрүүдэд талбай дээр шалгалт хийж, заган ойн байгаа талбайд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах нь зүйтэй гэж үзсэн.
2	Усны газар	2022.04.22	Ажлын даалгаврын дагуу хээрийн судалгааны ажлыг чанартай сайн гүйцэтгэж байна. Судалгааны ажлын явцад судалгааны талбайн орчмын нутгийн иргэдийн худгуудад усны түвшин буурах нөхцөл үүсээгүй, 2021 онд өрөмдсөн	Орон нутгийн иргэдийн эсэргүүцлийн улмаас газрын доорх усны эх үүсвэрийн хайгуул судалгааны ажлын гүйцэтгэл хойшлогдсон. Хайгуул судалгааны ажил



			цооногуудын байршлын сонголтыг оновчтой байрлуулаагүй, бүрэн автомат багаж суурилуулан ГДУ-ны хяналт шинжилгээний сүлжээнд холбох. ГДУ-ны судалгааны ажлыг үргэлжлүүлэн усны ордыг нарийвчлан судлах, үр дүнг сумын БОХУБ, СГЗ-нд гаргаж өгч, нутгийн иргэдэд мэдээлэх шаардлагатай.	үргэлжлэн явагдаж байна.
3	Шинэжинст сумын БОХУБ	2022.04.27	Хог хаягдлын тал дээр сумын менежмент дээр суурилж тусгай зөвшөөрөл эзэмшигч ААНБ-ын хог хаягдлыг зайлуулах, булшлах, хог хаягдлын цэгийн асуудлыг шийдэж хариу өгье.	Одоогоор хариу ирүүлээгүй байгаа тул хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй орон нутгийн аж ахуйн нэгжийг чадавхижуулж, хамтран ажиллах төлөвлөгөөтэй байна.
4	Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/561 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг	2022.09.14-15	Усны шавхалт туршилтын ажлын усыг 500м-ээс илүү зайнд хийх. Гарч байгаа усыг жижиг хөв цөөрөм байгуулж замын усалгаа, мал, амьтны усалгаа зэрэг аль болох эргүүлэн ашиглах арга хэмжээ авах 21 дүгээр худаг дээр тоолуур тавих, тоолуурыг аймгийн байгаль орчны байцаагч байлгаж суурилуулах. Мөн насосыг сольж усны ундарга хэвийн байгааг батлах. Дараа хавар хүртэл малчдын бүсэд байгаа 7-н худгаар орон нутгийн иргэдтэй худгуудын усны хэмжилтийг цуг хийх. Усны хяналтын цооногуудыг мэргэжлийн байгууллагатай хамтран тогтоож, байгуулах, нутгийн иргэдтэй хамтран хяналт шинжилгээ мониторингийн ажлыг тогтмол хийх. Заган ой байгаа талбайд мэргэжлийн байгууллагыг орон нутгаас томилж мэргэжлийн дүгнэлт	Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон Шинэжинст сумын Т.Алтангэрэл, Баян-Өндөр сумын Ш.Цогбадрах нартай ярилцан хэмжилт хийх худгийн тоог нэмэгдүүлж, оролцох иргэдийн хуваарийг гаргасан. Бямба гараг бүрт Шинэжинст сумын Майхан хүрэн урд, хойд, Гүн заг, Сухайн худаг, Гашуун худаг, Хөвт хүрэн, Хүрэн цавын худгуудад, Ням гараг бүрт Баян-Өндөр сумын Өргөө, Босго, Таван худгийн дээд, доод, Холбоо хүрэн, Их, жижиг арын ус, Захын хөв, Үзүүр хар, Гүндалай, Гурван худгийн дээд, доод худгуудад усны түвшний хэмжилт хийж байхаар тохиролцсон. Шинэжинст сумын иргэн Т.Алтангэрэлтэй



			гаргуулах нь зүйтэй гэж үзсэн. Ажлын хэсэгт ажилласан орон нутгийн иргэд бусад иргэдэд үнэн зөв бодит үзсэн мэдээллээсээ цаашид хуваалцаж байхыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга сануулсан.	09 сарын 24, Баян-Өндөр сумын иргэн Ш.Цогбадрахтай 10 сарын 12-ны өдрүүдэд худгийн усны түвшний хэмжилтийг хийсэн ба бусад товлосон хугацаанд малчид хувийн ажилтай байсан тул хэмжилтэд оролцож чадаагүй.
5	Шинэжинст сумын БОХУБ	2022.09.14-15	Бичиг баримтын бүрдэл хангасан, зөрчилгүй.	Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйл заасны дагуу бусгай зөвшөөрлийн талбайд байх шаардлагатай баримт бичгүүдийн хуулбарыг байршуулж байсан боловч, эх хуваарь нь эсвэл наториатаар батлуулсан хувийг байлгах зөвлөмжийн дагуу наториатаар батлуулсан хувийг бэлтгэж бүрдүүлсэн.

#### 4.11 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж хайгуулын үйл ажиллагаанаас байгаль орчны бүхий л бүрэлдэхүүн хэсгүүдэд нөлөөлж буй болзошгүй сөрөг нөлөөллүүдийг үе шаттайгаар хянах, гол нөлөөллүүдийг бууруулах, үйл ажиллагаагаа тогтмол сайжруулах, хууль эрх зүйн шаардлагуудыг бүрэн биелүүлэхийг зорин ажиллаж байна.

Хүснэгт 20. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт

Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилт
Төслийн барилгын ажил эхлэхтэй холбоотойгоор Байгаль орчин, аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд, орон нутгийн хэлтсийг байгуулна	Эрүүл мэнд хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчин, орон нутгийн харилцааны хэлтсийг байгуулсан. Эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлын баг 3, байгаль орчны баг 4, орон нутгийн харилцааны баг 5 мэргэжилтний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.
Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	“Байгаль орчны чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам”-ыг боловсруулж, 07 сарын 01-ээс мөрдөж эхэлсэн.



	Хавсралт 28. Байгаль орчны чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам
Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Төслийн бүх ажилчдыг өвлийн, 2 ээлжийн зуны хувцасаар бүрэн хангасан.
Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт жил бүр тогтмол хамруулах. Ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах, хордлого тайлах хүнс, бэлдмэлээр хангаж байх	Орон нутгаас шинээр ажилд орж байгаа иргэдийг Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтран урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Ажилтнуудыг нэг бүрийн хамгаалах хэрэгслээр бүрэн хангасан ба тусгайлсан хэрэгсэл шаардлагдах ажлуудыг гүйцэтгэх үед шаардлагатай хамгаалах хэрэгслээр хангах ажиллаж байна.
Галын аюулаас хамгаалах хэрэгсэл, эрүүл ахуйн хэрэгслээр хангах	Шаардлагатай байгаа багаж хэрэгсэл тоног төхөөрөмжийг худалдан авч, төлөвлөсөн хэсгүүдэд суурьлуулсан. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний хэсэгт дэлгэрэнгүй тусгасан.
Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ -нд хүргэн өгч байх	Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг журмын дагуу боловсруулан, журамд заасан хугацаанд хүргүүлж байна.

#### 4.12 2022 ОНЫ БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төсөл хэрэгжүүлэгч “Эрдэнэ Монгол” ХХК жил бүр БОМТ-ний хэрэгжилт, үйл ажиллагааны талаарх мэдээллийг сонирхсон хүн бүхэнд нээлттэйгээр танилцуулдаг ба төслийн менежер орон нутгийн харилцааны багийнхны хамтаар давхардсан тоогоор төслийн нөлөөллийн бүсийн болон Шинэжинст сумын 55 өрхөөр зочилж төслийн талаарх мэдээлэл өгч иргэдийн саналыг сонсон ажиллаж байна. Орон нутгийн 60 иргэнийг ажлын байраар хангасан. Мөн 9 өрхөд ямаа самнах ажилд дэмжлэг үзүүлсэн. БОМТ-ний хэрэгжилтийг дүгнүүлсний дараа сумын ИТХурал, багийн ИНХуралд танилцуулна.

Хүснэгт 21. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Мэдээллийн агуулга	Хугацаа	Зохион байгуулах газар	Хэрэгжилт	Зарцуулсан хөрөнгө (сая төгрөг)
БОМТөлөвлөгөө олон нийтэд нээлттэй байлгах	БОМТөлөвлөгөө	Төлөвлөгөө батлагдмагц	www.erdene.com вэбсайт	<a href="https://erdene.com/mn/sustainability/environmental-management/">https://erdene.com/mn/sustainability/environmental-management/</a>	-
БОАЖЯамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн	БОМТөлөвлөгөөний биелэлт	11 сарын 30-ны дотор	БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн	Менежментийн төлөвлөгөөний биелэлтийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны “Журам батлах тухай” А/618	-



“Эрдэнэ Монгол” ХХК-ийн MV-021444 дугаартай “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

удирдлагын газарт			удирдлагын газар	тушаалын дагуу гарган хүргүүлж байна.	
Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар	БОМТөлөвлөгөөний биелэлт	11 сарын 01-ны дотор	Баянхонгор аймгийн БОАЖГазар	Менежментийн төлөвлөгөөний биелэлтийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны “Журам батлах тухай” А/618 тушаалын дагуу гарган хүргүүлж байна.	-
Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газар, Байгаль орчны албанд	БОМТөлөвлөгөөний биелэлт	БОМТөлөвлөгөөний биелэлтийн тайлан батлагдсаны дараа	Шинэжинст сум	БОМТөлөвлөгөөний биелэлтийг дүгнүүлсний дараа батлагдсан биелэлтийн тайланг сумын Засаг даргын тамгын газрын мэргэжилтэн Байгаль орчны хяналтын улсын байцаагчид хүлээлгэн өгөх болно.	-
Сумын болон багийн Иргэдийн хуралд	БОМТөлөвлөгөөний биелэлт	БОМТөлөвлөгөөний биелэлтийн тайлан батлагдсаны дараа	Шинэжинст сум, Уртын гол баг	БОМТөлөвлөгөөний биелэлтийг дүгнүүлсний дараа 2022 онд багтаан сумын ИТХ болон багийн ИНХ-д танилцуулахаар төлөвлөж байна.	1,000.0
Уртын гол багийн иргэд	Үйл ажиллагааны танилцуулга	2022 он	Уртын гол баг	БОМТөлөвлөгөөний биелэлтийг дүгнүүлсний дараа 2022 онд хэрэгжүүлсэн ажлын талаар нутгийн малчин өрхүүдэд зочлох үедээ танилцуулна. Мөн хээрийн ангид ирэх үед нээлттэй танилцуулна.	1,000.0



## БҮЛЭГ 5. ДҮГНЭЛТ

“Эрдэнэ Монгол” ХХК нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Уртын гол 2-р багийн нутагт “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийг хөгжүүлэх ажлыг хэрэгжүүлж эхлээд байна. Тус компани нь байгаль орчин, нийгмийн хариуцлагын хүрээнд сайн туршлага, менежментийг нэвтрүүлж олон нийтэд нээлттэй, хариуцлагатай уул уурхайн жишиг төсөл болох зорилго тавин ажиллаж байна.

“Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны хууль тогтоожмийн дагуу боловсруулж БОАЖЯ-нд тогтоосон хугацаанд хүргүүлсэн боловч БОАЖЯ нь Баянхонгор аймгийн орон нутгийн иргэдийн хүсэлтийн дагуу БОАЖЯ, УУХҮЯ, АМГТГ, Усны газар, Баянхонгор аймгийн МХГ болон иргэдийн төлөөлөл бүхий ажлын хэсэг 2022 оны 04 дүгээр сарын 07-13-ний өдрүүдэд, Усны газрын шинжээчдийн баг 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр Баянхөндий төслийн талбайд ажиллаж, холбогдох дүгнэлт гарсаны дараагаар БОАЖЯ-аас төслийн БОМТ-г 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр батласан.

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1 дэх хэсэгт заасны дагуу Усны газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 01/532 дугаартай ус ашиглуулах дүгнэлтийн дагуу 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Алтайн Өвөр Говийн сав газрын захиргаатай Баянхөндий төслийн Ус ашиглах гэрээг байгуулсан.

Баянхөндий төслийн үйл ажиллагаанд коронавирусын цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, хил гаалийн хүндрэл бэрхшээл, нөгөө талаас зарим төрийн бус байгууллага, иргэдийн эсэргүүцэлтэй тулгарч, тэдгээрийг мэдээллээр хангах зэрэг олон хүчин зүйлүүд ихээхэн нөлөөлж, 2022 онд төлөвлөсөн туслах барилгын ажлууд хойшлогдсон бөгөөд БОМТ-ний хэрэгжилтийг 08 дугаар сараас хойш хэрэгжилтийг хангаж ажиллах боломж бүрдэж, хэрэгжилтийг эрчимжүүлж ажилласан. Зарим төрийн бус байгууллага, иргэдийн эсэргүүцэл нь 2022 оны 04 дүгээр сарын 09 болон 22, 05 дугаар сарын 7-10, 05 дугаар сарын 26-30, 06 дугаар сарын 10-аас 07 дугаар сарын 07-ны өдөр, 07 дугаар сарын 20-оос 08 дугаар сарын 15-ны өдрүүдэд болсон. Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 29-өөс үзнэ үү. Баянхөндий төслийн 2022 онд төлөвлөсөн туслах барилгын ажил дээрх шалтгаануудын улмаас хойшлогдсон тул байгалийн ургамал үржүүлгийн газар байгуулах, кемпийн өргөтгөлийн бэлтгэл, нэмэлт хайгуулын өрөмдлөг, газрын доорх усны ордын гидрогеологийн нэмэлт судалгааны ажил явагдаж байна.

Баянхөндий төслийн хүрээнд 2022 онд барилгын ажил хойшлогдож газар хөндөөгүй боловч БОМТ-ний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дээрх Түймэртийн 1.6 га, Их Богдын Байгалийн цогцолборт газрын 14 га нийт 15.6 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийж БОМТ-нд тусгасан 6.3 га талбайн хэмжээнээс 2.5 дахин их талбайд нөхөн сэргээлтийн ажлыг хэрэгжүүлсэн.

Төслийн 2022 оны БОМТ-ний хэрэгжилтэд 160 сая төгрөг, Тэрбум мод хөтөлбөрт 40 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд БОМТ-ний хэрэгжилтэд 174 сая төгрөг, Тэрбум мод хөтөлбөрийн хэрэгжилтэд 42.2 сая төгрөгийг зарцуулсан байна.





Хүснэгт 22. БОМТ-ний хэрэгжилтэд зарцуулсан зардал, 2022 он

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зардал, төг.	
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөө	15 сая	
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	13.5 сая	
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт	58 сая
		Тандан судалгаа	9 сая
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-	
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-	
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	Үйл ажиллагааны зардал	
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	17 сая	
8	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	59.7 сая	
9	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах	2 сая	
Нийт дүн		174.2 сая	
“Тэрбум мод тарих” үндэсний хөдөлгөөн		42.2 сая	

---oOo---



## БҮЛЭГ 6. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. CITES-ийн хавсралтад бүртгэгдсэн амьтан, ургамлын зүйлийг таних бичиг. 2004. Улаанбаатар хот, Монгол улс.
2. E. L. Clark., Ж. Мөнхбат., E.M. Monks., С. Дуламцэрэн., J.E.M. Baillie., Н. Батсайхан., Л.Я. Боркин., Р. Самъяа., М. Stubbe (Эмхэтгэгчид, редакторууд) 2006. *Монгол орны хөхтөн амьтны улаан данс*. Бүс нутгийн Улаан Дансны Цуврал. Боть 5. Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Лондон хот.
3. Gombobaatar S. And Monks E. M. (compilers), Seidler R., Sumiya D., Tseveenmyadag N., Bayarkhuu S., Baillie J. E. M., Boldbaatar Sh., Uuganbayar Ch., (editors) 2011. *Regional Red List Series Vol.7. Birds*. Zoological Society of London, National University of Mongolia and Ornithological Society.
4. Gombobaatar, S. 2009. *A Dictionary of Vertebrate Animals of Mongolia*. Admon print. Ulaanbaatar.
5. Terbish., Н. Munkhbayar., Н. Munkhbaatar., М. 2013. *A Guide to the Amphibians and Reptiles of Mongolia (Second Edition)*. Admon print. Ulaanbaatar city, Mongolia.
6. Бадамханд, Ж. 2011. Монгол орны агнуурын амьтдын лавлагаа. Хүст хэвлэл. Улаанбаатар хот, Монгол улс.
7. Батсайхан, Н., Самъяа, Р., Шар, С., Кинг, С.Р.Б. 2010. Монгол орны хөхтөн амьтад таних гарын авлага. Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэг, Лондон хот.
8. Болдбаатар, Ш. 2008. Монгол орны шувууны фото лавлах (125 зүйл). Улаанбаатар хот, Монгол улс.
9. Болормаа нар., 2011. Монгол орны гуурст дээд ургамлын хураангуйлсан нэрийн жагсаалт. Сэлэнгэпресс ХХК-ийн хэвлэх үйлдвэр. Монголын Бэлчээрийн Менежментийн Холбоо. Улаанбаатар хот.
10. Лхагвасүрэн, Б., нар. 2012. Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (СМС)-ын үндэсний тайлан. Улаанбаатар хот, Монгол улс.
11. Мөнхбаяр, Х., Тэрбиш, Х., Мөнхбаатар, М. 2009. Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчид. Улаанбаатар хот, Монгол улс.
12. Нямбаяр, Д., Оюунцэцэг, Б., Тунгалаг, Р. (эмхэтгэгчид), Ц. Жамсран, Ч. Санчир, С. Бахман, Н. Сонинхишиг, С. Гомбобаатар, Ж.Е.М. Баиллие, Ц. Цэндээхүү (редакторууд) (2012). Монголын ургамлын Улаан данс ба хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл. Бүс нутгийн улаан дансны цуврал. Боть 10. Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Монгол Улсын Их Сургууль.
13. БОАЖ Сайдын 2020 оны А/59 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт “Усны нөөцөд учирсан хохирлыг үнэлэх, нөхөн төлбөр тооцох аргачлал”
14. Х. Тэрбиш., Х. Мөнхбаяр., E. L. Clark., Ж. Мөнхбат., E.M. Monks., М. Мөнхбаатар., J.E.M. Baillie., Н. Батсайхан., Л.Я. Боркин., Р. Самъяа., Д.В. Семенов. (Эмхэтгэгчид, редакторууд) 2006. Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн улаан данс. Бүс нутгийн Улаан Дансны Цуврал. Боть 5. Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Лондон хот.
15. Шийрэвдамба, Ц. (ерөнхий ред). 2013. Монгол улсын улаан ном. Улаанбаатар хот, Монгол улс
16. “Эко трейд” ХХК. 2021. Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ. Улаанбаатар хот, Монгол улс



## БҮЛЭГ 7. ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

№	Хавсралтын нэр
<b>Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу хавсаргах материалууд</b>	
1	Улсын бүртгэлийн гэрчилгээ
2	Тусгай зөвшөөрлийн хуулбар
3	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дүгнэсэн аймгийн дүгнэлт
4	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн 2022 оны жилийн мэдээ
5	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хяналтын хуудас /аж ахуйн нэгж бөглөх/
<b>Баянхөндий төслийн БОМТ-ний хэрэгжилтгүй холбоотой хавсралтууд</b>	
1	Хавсралт 6. Газар хөндөх зөвшөөрөл авсан ГМС-ийн бүртгэл
2	Хавсралт 7. Газар хөндөх журам.
3	Хавсралт 8. Биологийн төрөл зүйлийн сургалтын материал
4	Хавсралт 9. Асгаралтаас урьдчилан сэргийлэх, асгаралтад авах арга хэмжээний журам
5	Хавсралт 10. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын горим
6	Хавсралт 11. Тээврийн хэрэгслийн үзлэгийн маягт, Гарах болон орох зөвшөөрлийн маягт
8	Хавсралт 12. Ус хэмнэх сургалтын материал болон сургалтад хамрагдсан нэрсийн жагсаалт.
9	Хавсралт 13. 2022 оны амьтаны бүртгэл
10	Хавсралт 14. Нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэлийг хүлээн авсан тухай акт
11	Хавсралт 15. Биологийн төрөл зүйлийн тандан судалгааны тайлан
12	Хавсралт 16. Тарвага нутагшуулсан ажлын тайлан
13	Хавсралт 17. Археологи, палентлогийн олдвор олдсон үед хэрэгжүүлэх журам
14	Хавсралт 18. Анхны тусламж үзүүлэх сургалтын хуваарь
15	Хавсралт 19. Баянхөндий төсөлд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бохирын ерөнхий схем
16	Хавсралт 20. Аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, шилжүүлэх, тээвэрлэх журам
17	Хавсралт 21. Аюултай хог хаягдал нийлүүлэх гэрээ
18	Хавсралт 22. Хог хаягдлын журмын сургалтын материалыг хавсаргав.
19	Хавсралт 23: Хөрсний шинжилгээний хариу
20	Хавсралт 24. Гүн загийн худгийн усны шинжилгээний хариу
21	Хавсралт 25. Майхан хүрэнгийн худгийн усны шинжилгээний хариу
22	Хавсралт 26. Малчдын худгуудийн түвшний хэмжилт
23	Хавсралт 27. Ургамалын хээрийн бичглэлийн судалгааны дүн
24	Хавсралт 28. Байгаль орчны чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам
25	Хавсралт 29. Баянхөндий төслийн үйл ажиллагаанд нөлөөлсөн байгууллага иргэдийн үл ойлголцлын бүртгэл-2022 он

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын  
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.



# МОНГОЛ УЛС УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

0000108106

2005.12.08

*/ Бүртгэсэн он, сар, өдөр /*

9019005124

*/ Улсын бүртгэлийн дугаар /*

2718243

*/ Регистрийн дугаар /*

Эрдэнэмонгол

Гадаадын хоронго оруулалттай хязгаарлагдмал  
хариуцлагатай компани

*/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /*

Дүрэм

*/ Үүсгэн байгуулах баримт бичиг /*

Тушаал

*/ шийдвэрийн нэр /*

A-720

*/ дугаар /*

2002.08.19

*/ он, сар, өдөр /*

4610

*/ код /*

Гадаад худалдаа

*/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /*

*/ код /*

*/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /*

16.02.27~18.02.27

*/ хугацаа /*

1

*/ гишүүдийн тоо /*

149,263.00

*/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган тэгрэгээр /*

Улаанбаатар, Чингэлтэй, 4-р хороо, 2.3-р давхарт, Утас1: 318532, Утас2: 318534, Факс: 976-11-315988

*/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /*

Улсын бүртгэлийн ерөнхий  
газрын Бүртгэлийн газар

*/ бүртгэсэн байгууллагын нэр /*



Гэрчилгээ дахин олзосон 2015 он 9 сар 11 өдөр

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Akerley овогтой Peter Covert-г Захирал-р томилсныг бүртгэв.	2005.12.08	Г.Алтантуяа
2	Дахин гэрчилгээ олгов.	2015.09.11	А.Мөнхсайхан
1	Хувь нийлүүлэгчээс 1 хасагдаж, 1 нэмэгдэж үүсгэн байгуулагчийн тоо нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2017.01.30	А.Мөнхсайхан
2	Ажиллах хугацааг 2018.01.29 -ний өдрөөс 2020.02.27 -ний өдөр хүртэл сунгасныг бүртгэв.	2018.01.29	Х.Түвшинтөр
3	Өөрийн хөрөнгийн хэмжээ 13304901 мян.төг-р нэмэгдэж нийт 13454164 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2019.07.18	Г.Санжаа
4	Ажиллах хугацааг 2020.02.27-ний өдрөөс 2022.02.27-ний өдөр хүртэл сунгасныг бүртгэв.	2020.01.10	Г.Алтай
5	Эцсийн өмчлөгч 0 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. 08990 Ашигт малтмалын ашиглалт /2020.03.05-2050.03.05/ үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2020.12.04	Э.Эрдэнэбилэг
6	08910 Ашигт малтмалын хайгуур /2020.04.14-2021.04.14/ үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2020.12.04	Э.Эрдэнэбилэг
7.	Эцсийн өмчлөгч 1 иргэн бүртгэв.	2020.12.04	Э.Эрдэнэбилэг
8	Үйл ажиллагаа эрхлэх хугацааг хугацаагүй болгов.	2021.12.15	С.Цолмон

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.





АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ  
**ЗӨВШӨӨРӨЛ**

Дугаар *MV-021444*

Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн

Баянхонгор аймаг /хот/-ийн  
Шинэжинст сум /дүүрэг/-ын  
Хөндий нэртэй газарт орших

2308.62 гектар талбай бүхий уурхайн талбайд хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг зөвшөөрч улсын бүртгэлийн 9019005124 тоот гэрчилгээтэй “Эрдэнэмонгол” гадаадын 100% хөрөнгө оруулалттай ХХК -д энэхүү тусгай зөвшөөрлийг 2049.08.05 дуустал хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.

КАДАСТРЫН ХЭЛТЭСИЙН  
ДАРГА  Д.ДАШЗЭВЭГ  
2019 оны 08 сарын 3 өдөр  
Улаанбаатар хот

0000354



# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

MV-021444

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Огноо, гарын үсэг, тэмдэг
001-NM	<ul style="list-style-type: none"><li>Бүртгэв: Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон 2019.08.05, дуусах хугацаа 2049.08.05</li><li>Тусгай зөвшөөрлийн 1 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв</li><li>Кадастрын хэлтсийн даргын 2019.08.01-ний 379 тоот шийдвэр</li></ul>	2 2019-08-05 КАДАСТРЫН ХЭЛТЭС УХА0595
002-FE	<ul style="list-style-type: none"><li>Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 2 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2020.08.05 – 2021.08.05 хүртэл</li></ul>	
003-FE	<ul style="list-style-type: none"><li>Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 3 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2021.08.05 – 2022.08.05 хүртэл</li></ul>	2020.07.31 1 АМТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС УХА0595
Мөргөлдөх	Өндөр	Замын хөдөлгөөний дүрмийг баримталж дүрэм зөрчихгүй байх	Дунд
Онхолдох	Өндөр	Хурд тохируулах	Дунд
Шарвах	Өндөр	Эрсдэлийг үнэлэж, шаардлагатай бол зогсох	Дунд
Явган хүн мөргөх	Өндөр	Явганаар уул болон барилгын замын хөдөлгөөний бүсэд зорчихгүй байх	Дунд
Мал амьтан мөргөх	Өндөр	Мал амьтнаас болгоомжлох, хурд хэтрүүлэхгүй байх	Дунд
Хүнд даацын машинтай хөнгөн тэрэг мөргөлдөх	Өндөр	Зөвхөн зөвшөөрөдсөн жолоочид жолоодох эрх олгох	Дунд
Шаварт суух	Өндөр	Ахлах ажилтны зааврыг дагах	Дунд



ЭРДЭНЭ МОНГОЛ ХХК

## SAFE WORK PROCEDURE

Date/Огноо: 2022-07-10

Revision /шинэчлэлт: 00

Page/хуудас 3/12

PROCEDURE	ГОРИМ
<b>GENERAL:</b>	
<b>Purpose and scope:</b> The main purpose of this procedure is to identify hazardous traffic situations, take preventive actions and prevent the occurrence of accidents.  All personnel including basic employees, long and short-term contractors who are going to drive or operate on machines, equipments /including light vehicle, heavy equipments, auxiliary equipments, bus/ in "Baruun Noyon Uul" operations shall follow the requirements in this procedure.	<b>Зорилго, цар хүрээ:</b> Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад гол зорилго оршино.  Энэхүү дүрмийг "Баянхөндий" алтны уурхайн төсөл дээр машин, техникийн /хөнгөн тэрэг, дунд болон том оврын машин, механикжсан тээврийнн хэрэгслийг ойлгоно/ жолоо барих гэж буй ажилтан болон гэрээт ажилтан дагаж мөрдөх үүрэгтэй.
<b>Procedure:</b> <u>Requirements for machines and equipments:</u> All machines and equipments are must complete the next requirements: <ul style="list-style-type: none"><li>- machine, equipments must be fully operational</li><li>- operational base radio station</li><li>- functional seat belts</li><li>- fire extinguisher</li><li>- wheel chocks</li><li>- emergency warning sign, beacon, flag /light vehicles only/</li></ul>	<b>Горим:</b> <u>Техникт тавигдах шаардлага:</u> Уурхай дээр замын хөдөлгөөнд оролцож буй бүх тоног төхөөрөмжүүд дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй: <ul style="list-style-type: none"><li>- машин, техникийн эд анги бүрэн ажиллагаатай байх</li><li>- бүрэн ажиллагаатай суурин радио станцтай байх</li><li>- ажиллагаатай суудлын даруулгатай байх</li><li>- галын хортой</li><li>- дугуйны ивүүртэй</li><li>- ослын анхааруулах тэмдэг, маяк, тугтай байх /зөвхөн хөнгөн тэргэнд/</li></ul>
<u>Mine driving license:</u> Personnel who are to drive/operate any equipment must hold mine operations driving license Drivers or operators must only operate equipment according to approved driving classification. It is prohibited to operate any equipment without mine driving license. To get mine driving license employee must prepare next documents: <ul style="list-style-type: none"><li>- full safety induction</li><li>- valid Mongolian driving license, notarized</li><li>- valid professional license or certificates, notarized</li><li>- request form of driving license</li><li>- related machine or equipment instruction form</li><li>- training sheet for company employees</li><li>- evaluation form</li></ul> Employee always must keep mine driving license ready.	<u>Уурхайн жолооны үнэмлэх:</u> Уурхай дээр машин техник жолоодох гэж буй аливаа хүн уурхайн өөрийн жолооны үнэмлэхтэй байх үүрэгтэй. Зөвхөн уурхайн жолооны үнэмлэх дээр заасан ангилалын дагуу тохирсон машин, техник барих. Уурхайн жолооны үнэмлэхгүйгээр аль нэг тээврийн хэрэгсэл барихыг хориглоно. Уурхайн жолооны үнэмлэх авахын тулд доорхи бичиг баримтыг бүрдүүлнэ: <ul style="list-style-type: none"><li>- ХЭМАА-ны хэлтсийн сургалт, зааварчилгаа бүрэн бүтэн байх</li><li>- нотариатаар баталгаажуулсан хүчинтэй Монгол улсын жолооны үнэмлэхтэй байх</li><li>- нотариатаар баталгаажуулсан хүчинтэй мэргэжлийн үнэмлэх, сертификаттай байх</li><li>- жолооны үнэмлэх хүссэн маягт</li><li>- тухайн техникийн ангийн сургалт</li><li>- компаний операторуудад дадлагын хуудас</li><li>- үнэлгээний хуудас</li></ul> Уурхайн жолооны үнэмлэх авсан тохиолдолд байнга



ЭРДЭНЭ МОНГОЛ ХХК

## SAFE WORK PROCEDURE

Date/Огноо: 2022-07-10

Revision /шинэчлэлт: 00

Page/хуудас 4/12

PROCEDURE	ГОРИМ
	биедээ авч явах.
<p><b>Before to drive or operate:</b> Any machine or equipment must have functional base station. Without radio station a machine or equipment can be operated only after when a driver had contact with safety coordinator and got permission to be escorted.</p>	<p><b>Хөдөлгөөн эхлэхээс өмнө:</b> Бүрэн ажиллагаатай радио станцтай машин, техник замын хөдөлгөөнд оролцох эрхтэй. Радио станцгүй тохиолдод тухайн хүн аюулгүй ажиллагааны мэргэжилтэнтэй холбогдож зөвшөөрөл авсны дараа гүперлүүлэн замын хөдөлгөөнд оролцож болно.</p>
<p>Pre-start inspection must be performed in the beginning of each shift and prior to starting the equipment. The Daily Vehicle/ Equipment Checklist must be filled out and any damage or unsafe condition noted on the checklist constantly. Inform direct supervisor immediately in case of any unsafe condition and machine must not be operated until the damage is repaired.</p>	<p>Машин, техникийг ээлж хүлээлцэхэд болон асаахаас өмнө шалгаж эвдрэл, гэмтлийг өдөр тутмын техникийн үзлэгийн дэвтэрт тогтмол тэмдэглэнэ. Ажилтан хэрэв ямар нэгэн аюултай гэмтэл, согог илрүүлбэл нэн даруй удирдлагадаа мэдэгдэж, тухайн тоног төхөөрөмжийг засагдаж аюулгүй болох хүртэл уг тоног төхөөрөмжийг ажиллуулахгүй.</p>
<p>Due to snowfall, rainfall or after long parking period the windshields, mirrors and warning lights of mobile equipment become dirty and contaminated and can greatly reduce visibility and cause mining accidents and incidents. In order to avoid the hazard, it is compulsory to clean the windshields, mirrors and warning lights prior to work.</p>	<p>Цас, бороо орох, удаан хугацаагаар паркалж зогсох, шавар шавхай туулсанаас болоод машин шил, толь, дохио бохирдож жолоочийн хувьд үзэгдэх орчин нь ихээхэн хязгаарлагддаг ба улмаар уурхайд аюул гарах нөхцөл бүрддэг. Энэ аюулыг арилгахын тулд шил, толь бохирдсон үед ажилд гарахаас өмнө заавал цэвэрлэж байх шаардлагатай.</p>
<p>Every morning during the pre-start checks the windshields, side windows, rear windows, mirrors and warning lights should be checked, any dust or contaminates must be removed prior to moving away also make a note that you have cleaned the appropriate part on the daily inspection sheet. Every equipment operator shall have cleaning substances and cloths in the equipment.</p>	<p>Өглөө болгон операторууд машин, техникийнхээ салхины, хажууд талын, ар талын шил, толь, гэрэл дохионуудыг цэвэрхэн байгаа эсэхийг шалгаж, тоос шороог цэвэрлээд чухам ямар хэсгийг цэвэрлэсэнээ өдөр тутмын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэнэ. Жолооч болгон цэвэрлэгээний бодис болон алчуурыг машин, техник-тээ авч явна.</p>
<p>If visibility is reduced during the work, the operator must stop somewhere safe and clean the glass and mirror contamination away, it is compulsory to clean the dirt and eliminate hazard. It is prohibited to drive/operate vehicles/machines with dirty and contaminated windshields or mirrors. <i>It is prohibited to clean windshields and mirrors while the equipment is moving.</i></p>	<p>Хэрэв ажлын үеэр шил, толь нь бохирдсоноос үзэгдэх орчин хязгаарлагдвал аюулгүй газар зогсож заавал цэвэрлэж аюулыг арилгасны дараа ажилд гарах ёстой. Бохирдсон шил, тольтой машин/механизм жолоодон ажилд гарахыг хориглоно.  <i>Явж буй машины шил, толь, цонх цэвэрлэхыг хориглоно.</i></p>
<p>The following clauses are to be taken into consideration during windshield and mirror cleaning:</p> <ul style="list-style-type: none"><li>Follow 3 points of contact rule while getting up and down by ladder/stairs to and from the equipment and face to equipment side.</li><li>It is prohibited to step and walk on non designated platform to avoid slipping.</li></ul>	<p>Шил толио цэвэрлэх үедээ анхаарах зүйлс.</p> <ul style="list-style-type: none"><li>Тоног төхөөрөмжийн шатаар өгсөж уруудахдаа 3 цэгээр хүрэлцэж, машиныхаа өөдөөс харсан байрлалаар бууж, сууна.</li><li>Халтирч унахаас сэргийлэх үүднээс зориулалтын бус тавцан дээр гишгэх, явахыг хориглоно.</li></ul>



PROCEDURE	ГОРИМ
<ul style="list-style-type: none"><li>Sometimes it is necessary to clean windshields and mirrors during snow and rain fall, in such cases it is important to take your time and select sure footing with no rush.</li></ul> <p>It is prohibited to get out from cabin and clean windshield and mirror during loading.</p>	<ul style="list-style-type: none"><li>Заримдаа цас бороо салхитай үед оператор нь машиныхаа шилийг цэвэрлэх шаардлага гардаг учраас яаралгүй хөлийнхөө гишгэлтэндээ анхаарал тавих нь чухал.</li></ul> <p>Ачилт хийж байгаа үед кабинаас гарч шил, толио цэвэрлэхийг хориглоно.</p>
<p><u>Mine traffic regulation:</u> Mine traffic will be regulated according to the Mongolian Traffic Rule and "Right hand rule". Grader, water truck and dozer due to work requirement may operate on any side of road.</p> <p>All intersections where traffic meets shall be regulated by road signs. All heavy duty, mid-size equipment and light vehicles shall obey the road signs equally (emergency vehicles are excepted under certain circumstances). All road signs shall comply with Mongolian Traffic Rules.</p>	<p><u>Уурхайн замын зохицуулга:</u> Уурхайн замын хөдөлгөөн Монгол Улсын Замын Хөдөлгөөний Дүрэм болон "Баруун гар талын дүрэм"-ийг баримтлана. Харин ажлын шаардлагаар грейдэр, усны машин ба дозер замын аль ч талаар явж болно.</p> <p>Уулзвар нэвтрэх дараалал нь тэмдэгээр зохицуулагдах бөгөөд бүх төрлийн машин, техникт адил тэгш эрхтэйгээр үйлчилнэ. /Зөвхөн онцгой байдал үүссэн үед гал, эмнэлэг болон цагдаагийн машийнд хамаарахгүй бөгөөд эдгээр машинуудад зам тавьж өгөх үүрэгтэй/. Бүх тэмдэг Замын Хөдөлгөөний Дүрмийн шаардлагийн дагуу байна</p>
<p><u>Participation in traffic:</u> Prior to starting an engine horn the signal once and wait for 5 seconds. Before forward movement horn the signal twice and wait for 5 seconds. Before reverse movement horn the signal 3 times and wait for 5 seconds.</p> <p>After engine start light low-beam on and always keep it on while driving.</p> <p>Always remove flag and beacon while driving on local or public roads.</p> <p>Safety belts must be worn at all times. Drivers must transport passengers only according to the number of functional seat belts and ensure that all passengers fastened before moving. In case of emergency, mine trainers and operator trainers may operate the equipment without designated seats belts for training purpose.</p>	<p><u>Хөдөлгөөнд оролцох:</u> Машин, техникийг асаахаас өмнө дуут дохио нэг удаа өгнө. Машин, техникийг урагшлах хөдөлгөөн хийх бүрт хоёр дуут дохио өгч 5 секунд хүлээгээд аюулгүй тохиолдолд хөдөлнө. Машин, техникийг ухрах хөдөлгөөн хийх бүрт гурван удаа дуут дохио өгч 5 секунд хүлээгээд аюулгүй тохиолдолд хөдөлнө.</p> <p>Машин, техник хөдөлгүүр асаасны дараа ойрын гэрлээ асааж, үргэлж асаалттай хөдөөлгөөнд оролцоно.</p> <p>Уурхайн лицензийн талбайгаас гадна орон нутгийн болоод улсын чанартай замд туг маягийг авч хураана.</p> <p>Машин, техникийн жолооч, оператор эсвэл зорчигч заавал суудлын даруулгыг хэрэглэх үүрэгтэй. Жолооч эсвэл оператор суудлын даруулгын тоогоор хүн тээвэрлэх бөгөөд зорчигчид даруулгын бүс хэрэглэж буй тал дээр хяналт тавьж байх үүрэгтэй. Онцгой тохиолдолд тоног төхөөрөмжийн сургалт явуулах зорилгоор уулын сургагч, дадлагажуулагч эрх бүхий оператор зориулалтын суудал, бүсгүй тоног төхөөрөмжид орж ажиллаж болно.</p>



ЭРДЭНЭ МОНГОЛ ХХК

## SAFE WORK PROCEDURE

Date/Огноо: 2022-07-10

Revision /шинэчлэлт: 00

Page/хуудас 6/12

PROCEDURE	ГОРИМ
<p>It is forbidden to drive on opposite direction. A grader, water truck, dump truck, dozer and other equipments should drive on right side of road. But due to work requirement a grader and water truck may drive on any side of lane. During road construction work according to instruction of a spotter or additional road sign drivers may go on opposite flow of traffic if it is safe.</p>	<p>Бүх төрлийн машин, техник эсрэг урсгалаар зорчихыг хориглоно. Грейдэр, усны машин, өөрөө буулгагч, дозер, трактор болон өөрөө явдаг бүх механикжсан тээврийн хэрэгсэл ердийн үед замын хамгийн баруун талаар явах үүрэгтэй. Харин грейдэр болон усны машин ажлын шаардлагаар замын аль ч талын эгнээгээр явах эрхтэй. Мөн зам засварын ажил эсвэл осол болсон тохиолдолд замын тэмдэг эсвэл дохиочны заасны дагуу аюулгүй байдлыг хангаж эсрэг урсгал руу орж болно.</p>
<p>All drivers shall keep a minimum distance of 50 meters from the vehicle in front, this is to give the driver ample time to react and brake in case of an emergency. Never counter the opposite flow of traffic when crossing intersections and exits. Moreover, it is required to cross the carriageway as close as possible to the right side to turn right.</p>	<p>Жолооч, оператор урдаа яваа машин, техникээс 50 метрээс багагүй зай барьж явна. Уулзвар нэвтрэхдээ эсрэг урсгалд орж нэвтрэхийг хориглоно мөн баруун гар тийш эргэхдээ замын хамгийн баруун талыг барьж эргэнэ.</p>
<p>In license area for all machine and equipments it is forbidden to make reverse movement. Drivers and operators while participating in traffic, parking, refueling should drive so that it is possible to move in forward direction only. Except next situations:</p> <ul style="list-style-type: none"><li>- dump trucks in loading area or at the waste rock to unload</li><li>- graders and dozers due to work requirements</li><li>- light vehicle is parking in parking area</li></ul>	<p>Уурхайн лицензийн талбайд бүх машин, техник ухрах үйлдэл хийхийг хориглоно. Машин, техникүүд ямар ч төрлийн хөдөлгөөнд оролцох, зогсоолд тавих, түлш цэнэглэх үед урагшлах хөдөлгөөний баримталж ажиллана. Зөвхөн дараах нөхцөлд зөвшөөрнө:</p> <ul style="list-style-type: none"><li>- өөрөө буулгагч машин ачилтанд орох эсвэл отвал дээр ачаагаа буулгах үед</li><li>- ажлын шаардлагын дагуу грейдэр болон дозер ажилаа хийх үед</li><li>- жижиг тэргүүд зогсоолын талбай дээр парклах үед</li></ul>
<p><u>Speed limits:</u></p> <ul style="list-style-type: none"><li>- in license territory no more than 40km/h</li><li>- in pit area no more than 40km/h</li><li>- in loading area, construction area and camp area no more than 20km/h</li></ul> <p>Remember to keep speed according to the weather condition. Security staff will randomly check vehicles speed with speed gun.</p>	<p><u>Хурдны хязгаар:</u></p> <p>Хурдны хязгаарын тэмдгийг баримтлана мөн цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалж хурдаа тааруулж явна.</p> <ul style="list-style-type: none"><li>- уурхайн лицензийн нийт талбайд 40км/цагаас хэтрэхгүй</li><li>- ашиглалтын бүсэд 40км/цагаас хэтрэхгүй</li><li>- ачилтын бүс, засвар, Барилгын ажлын бүс болон кемп орчим 20км/цагаас хэтрэхгүй</li></ul> <p>Харуул хамгаалалтын ажилтан хурд хэмжигчээр машин, техникийн хурдыг шалгаж байх болно.</p>
<p>Drivers and operators must choose appropriate speed while turning left, right and reversing to avoid any damages, accidents to themselves and others. Consider about machine or equipment dimension, carriage and weather condition.</p>	<p>Уурхайн талбайд зорчиж байгаа бүх төрлийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжүүдийн жолооч операторууд баруун, зүүн болон буцаж эргэх үйлдэл хийх үедээ өөрийн овор хэмжээ, тээвэрлэж буй ачаа болон өөртөө ба бусдад ямар нэгэн гэмтэл, эвдрэл, аюул учруулахгүй байх хурдыг сонгоно.</p>



ЭРДЭНЭ МОНГОЛ ХХК

## SAFE WORK PROCEDURE

Date/Огноо: 2022-07-10

Revision /шинэчлэлт: 00

Page/хуудас 7/12

PROCEDURE	ГОРИМ
<p><u>Entering the pit area:</u> Driver or operator must inform their intent to enter an active mine area to mine foreman. Mine Foreman must confirm that he received the message, and should inform the driver or operator of any unsafe situations or restricted areas that the driver may not know. The Mine Foreman may also ask their intent to enter the pit and target area and may refuse entry if visibility is poor; blasting is being carried out or for any other hazardous conditions.</p> <p>Personnel entering the active mining area must be familiar with safe working procedure on blast notification and be aware of blasting time before entering.</p> <p>When exiting from the active mining area a driver or operator must inform a mine foreman and got permission too.</p>	<p><u>Уурхайн бүсэд нэвтрэх:</u> Уурхайн бүс рүү нэвтэрч буй бүх машин, техник тухайн ээлжийн уулын мастертай радио станцын сувгаар холбогдож зөвхөн зөвшөөрөл авсны дараа нэвтрэнэ. Уулын мастер нь энэ мэдээг хүлээн авч жолоочид эрсдэл ихтэй байж болох нөхцөл байдал, хориотой бүс зэргийн талаар мэдээлэл өгнө. Уулын мастер нь ямар хэсэгт ажиллах шаардлагатай байгааг лавлаж болох бөгөөд үзэгдэх орчин муу, аюултай болон тэсэлгээтэй үед орохыг хориглож болно.</p> <p>Уурхайн бүсэд нэвтэрч байгаа бүх ажиллагсад "Тэсэлгээний мэдэгдлийн аюулгүй ажиллагааны горим"-г судалсан, тэсэлгээ явагдах цагийг мэдсэн байх шаардлагатай.</p> <p>Уурхайн бүсээс гарч байгаа тохиолдолд мөн ялгаагүй ээлжийн уулын мастерт мэдэгдэж зөвшөөрөл авч гарна.</p>
<p><u>Overtaking:</u> To overtake a machine or equipment in front a driver or operator must contact and got permission. Only after confirmation of your request you can overtake on flat, straight road with sufficient visibility.</p> <p>Once the front vehicle driver or operator allows overtaking on radio, driver should allow overtaking of behind vehicle and give enough space. If required, the front vehicle may stop to be overtaken.</p> <p>It is prohibited to overtake and approach any mobile equipment from "blind side" under any circumstances /road maintenance equipment may be excluded from it if they acquired permission in advance/.</p> <p>It is prohibited to overtake on ramp. Do not overtake any dump truck which is moving or starting to move. But if dump truck is stopped and turned on emergency lights then you have to contact with operator and after permission you may overtake.</p> <p>When following any equipment, remain in operator's view (visible in cab side mirror).</p>	<p><u>Гүйцэж түрүүлэх:</u> Аливаа тээврийн хэрэгсэл болон тоног төхөөрөмжүүд урд яваа тээврийн хэрэгслийг гүйцэж түрүүлэхдээ радио станцаар жолооч эсвэл оператортой нь холбогдож зөвшөөрөл авсны дараа болно. Гүйцэж түрүүлэхдээ зөвхөн замын шулуун хэсэг, үзэгдэх орчин сайтай газар зөвшөөрнө.</p> <p>Урд талд нь зорчиж буй тээврийн хэрэгслийн жолооч, оператор станцаар зөвшөөрөл өгсний дараа хангалттай зай тавьж өгөх ба шаардлагатай бол зогсон өнгөрүүлнэ. Ямарч нөхцөлд "сохор талаар" гүйцэж түрүүлэх, ойртон очихыг хориглоно /зам засварын ажил хийж буй машин механизмын оператороос урьдчилан зөвшөөрөл авсан бол уг заалтанд хамруулахгүй/.</p> <p>Уулзвар, өгсүүр, уруу газар гүйцэж түрүүлэхийг хориглоно. Ачаатай, ачаагүй өөрөө буулгагч машин хөдөлгөөнөө эхлүүлж байгаа эсвэл явж байгаа тохиолдолд хориглоно. Харин ослын гэрлээ асаагаад зогсож байгаа үед оператортой нь холбогдсоны дараа гүйцэж түрүүлж болно.</p> <p>Машин, техникийн араас явах үед урд яваа жолооч, операторын харагдах хэсэгт явна.</p> <p>Машин, техникээс буус суухдаа заавал гурван цэгээр</p>



ЭРДЭНЭ МОНГОЛ ХХК

SAFE WORK PROCEDURE

Date/Огноо: 2022-07-10

Revision /шинэчлэлт: 00

Page/хуудас 8/12

PROCEDURE	ГОРИМ
<p>Mount and dismount from machine or equipment with 3 point contact: 1 hand – 2 feet or 2 hands – 1 foot on the vehicle steps and handrails at all times. Use handrails and steps when mounting or dismounting equipment. Clean mud off boots prior to entering cab. Always face the machine when mounting or dismounting equipment. Sometimes, an operator will be required to climb up or down from other parts of the machine and it is important to watch your footing and handholds. Never jump down from mobile equipment.</p> <p>Give way to oncoming vehicle when turning aside from equipment stopping on the road.</p>	<p>хүрэлцэнэ: 1 гар 2 хөлөөрөө эсвэл 2 гар 1 хөлөөрөө байнга гишгүүр болон бариулд хүрэлцэх. Машинд суух, машинаас буухдаа зориулалтын тоноглогдсон бариул, шатыг ашиглана. Бүхээгт орохоосоо өмнө гутлынхаа шаврыг цэвэрлэнэ. Машинаас бууж суухдаа үргэлж машиныхаа өөдөөс харсан байрлалтай байна. Ачилт хийлгэж байгаа өөрөө буулгагчын кабинаас бууж суухыг хориглоно.Заримдаа операторыг машины бусад хэсгүүдэд авирах эсвэл буух шаардлага тавигддаг. Гишгэлт барилтандаа анхаарал тавих нь тун чухал. Машинаасаа хэзээ ч үсэрч бууж болохгүй.</p> <p>Зам дээр зогсох машин, техникийг тойрон гарахдаа өөдөөс яваа тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө.</p>
<p><u>Parking:</u> Equipment shall be parked only in designated parking area with flat surface except emergency parking.</p> <p>Always park so that it is possible to move in forward direction only.</p> <p>All drivers and operators should turn on emergency light, put wheel chocks and inform supervisor if parked in non designated area.</p> <p>In the case if parking ditch is unavailable, it is required to place two or more wheel chocks for each equipment. Place wheel chocks under rear tire. If wheel chock is under front tire, steering rule may get steered when vehicles rolls and wheel chock will come off from the tire. It is prohibited to use rocks, wood and other materials that are not intended for using as wheel chocks.</p> <p>In the mine parking is not permitted within 20 meters from the high wall.</p>	<p><u>Зогсоолд тавих:</u> Машин, техникийг зайлшгүй зогсолтоос бусад тохиолдолд тусгайлан зассан тэгш талбайд тавих хэрэгтэй. Зайлшгүй зогсолтын үед зөвхөн урагшлах хөдөлгөөнөөр гарч явах боломжтой газрыг сонгоно. Бүх машин, техник зогсоолын талбайгаас бусад газар түр болон удаан зогсолт хийсэн тохиолдолд ослын дохионы гэрлийг асааж ивүүр хэрэглэнэ.</p> <p>Ховилгүй талбайд дугуйны ивээсийг ашиглана. Автомашинуудад заавал 2 буюу түүнээс дээш тооны дугуйны ивээс авч явах шаардлагатай. Дугуйны ивүүрийг аль болох арын дугуйнд хийх хэрэгтэй. Учир нь урд дугуйнд хийснээр машин өнхөрөх үед жолооны хүрд залагдаж улмаар дугуй ивүүрээсээ мултрах аюултай. Чулуу болон мод гэх мэт зориулалтын бус зүйлүүдийг дугуйнд ивүүр болгож ашиглахыг хориглоно. Уурхай дээр өндөр хананаас 20 метрээс бага зайд зогсохыг хориглоно.</p>
<p><u>Heavy duty equipment:</u> The operator shall park the equipment at least 3 meters from other equipment when parking side by side and at least 2 vehicles lengths from the equipment when parking in a procession.</p> <p>When parking equipment for long time, the operator shall place the transmission in neutral, apply the parking brake, turn off all head lights, 2 way radio, clearance lights and</p>	<p><u>Хүнд даацын машин механизм:</u> Хүнд машин механизмыг зэрэгцүүлэн зогсоохдоо хоорондын зай нь 3 метрээс багагүй байна. Цуваагаар зогсоохдоо хоорондын зай нь 2 ижил төрлийн машины урттай тэнцэхээр байрлуулна.</p> <p>Тоног төхөөрөмжийг удаан хугацаагаар зогсоолд тавихдаа оператор нь: - араагаа нейтраль байрлалд шилжүүлэх,</p>





PROCEDURE	ГОРИМ
<p>shut down the engine (wait for 5 minutes to cool down) then place wheel chocks.</p> <p>If it is required to park heavy equipment in non designated area, it is mandatory to put wheel chock and cones. In parking areas, heavy and auxiliary equipment put front wheel, light vehicles put rear wheel into parking ditch.</p> <p>If it is required to remain engine running due to weather conditions, the operator should turn on four way flashers and clearance lights and leave the master switch in ON position.</p> <p>If loaded broken equipment is required to park on the ramp or downhill, it should be unloaded completely or partially on downhill side of the truck to prevent from rolling over and wheel chocks shall be placed.</p> <p>Haul trucks are allowed to turn blind side only during the following cases:</p> <ul style="list-style-type: none"><li>- Before and after loading, haul truck shall shift from right hand traffic to the left and from left to right hand traffic to occupy to line.</li><li>- Unloading area may not have established road. Trucks approaching unloading area must turn clockwise and shift to left side of traffic from right hand side.</li><li>- Farthest right hand haul truck among 2 or more haul trucks that unloaded in parallel manner shall participate in traffic first. If required, haul truck that unloaded first can participate in traffic after informing on the radio.</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>- зогсоолын тормосыг ажиллуулах,</li><li>- ойрын гэрэл, радио станцыг унтраах,</li><li>- дугуйнд ивээс хийх,</li><li>- хөдөлгүүрийг 5 минут нормальдсан байвал зохино.</li></ul> <p>Зориулалтын бус талбайд хүнд даацын машин механизмыг зогсоохдоо конусан тэмдгүүдийг байрлуулж, дугуйндаа ивээс хийн аюулгүй байдлыг хангана. Зогсоолын талбайд хүнд болон туслах тоног төхөөрөмжүүд урд дугуйг, суудлын автомашин хойд дугуйг шуудуйнд оруулна.</p> <p>Цаг агаарын нөхцлөөс шалтгаалан хөдөлгүүрийг асаалттай орхин зогсолт хийх үед оператор нь ослын дохионы гэрэл, оврын гэрлүүдээ асааж, мастер унтраалгыг (ерөнхий унтраалга) ON байрлалд шилжүүлэн орхино.</p> <p>Хэрэв ачаатай тоног төхөөрөмж эвдрэл гэмтлээс шалтгаалан газрын өгсүүр хэсэгт зогсох шаардлага гарвал, ачаагаар газрын уруу талд бүгдийг эсвэл хэсэгчлэн буулгаж өнхрөхөөс сэргийлэх ба ивээсийг давхар байрлуулна.</p> <p>Өөрөө буулгагч машинууд /дамп/ дор дурдаснаас бусад тохиолдолд баруун гар тийш эргэхийг хориглоно:</p> <ul style="list-style-type: none"><li>- ачилтанд орох, гарах үед өөрөө буулгагч нь замын баруун гар талаас зүүн гар тал руу, мөн зүүнээс баруун тийш шилжиж эгнээ байраа эзэлнэ.</li><li>- буулгалтын талбайд тогтсон зам байхгүй байж болно. Гэхдээ буулгалт хийх хэсэгт ойртон очихдоо өөрөө буулгагч нь цагийн зүүний дагуу эргэх үйлдлийг хийх ба энэ нь мөн адил замын баруун гар талаас зүүн гар тал руу шилжих үйлдлийг хийнэ.</li><li>- зэрэгцээ буулгалт хоёр болон түүнээс дээш тооны өөрөө буулгагчаас хамгийн баруун талынх нь хөдөлгөөнд түрүүлж орно. Шаардлагатай үед үйлдэл нь түрүүлж хийгдсэн өөрөө буулгагчийн оператор нь радио станцаар хөдөлгөөнөө эхлүүлж байгааг бусад мэдэгдэх хэрэгтэй.</li></ul>
<p><u>Light vehicle</u></p> <p>Light vehicles shall be parked at least one open doors distance away when parking side by side and at least 2 vehicles lengths from the front or back vehicle when parking in a procession.</p>	<p><u>Суудлын автомашин</u></p> <p>Суудлын автомашинуудыг зэрэгцүүлэн зогсоохдоо хажуугийн зай нь хаалга онгойход тулахааргүй чөлөөтэй зайд байна. Цуваагаар зогсоохдоо хоорондын зай нь 2 ижил машины урттай тэнцэхээр байна.</p>



PROCEDURE	ГОРИМ
<p>When parking light vehicles for an extended period of time in non designated area (not in parking area), the driver must use wheel chock. Cones and/or reflectors or hazard lights may be used.</p> <p>If it is required to keep the engine running due to weather conditions, the operator should turn on four way flashers and clearance lights and apply parking brake and place wheel chocks.</p> <p><u>Mine support and medium duty equipment:</u></p> <p>When parking the equipment such as dozer, grader, excavator, shovel, loader etc. always ensure that all raised tools (Ground Engaging Tools) are grounded.</p> <p>Always maintain minimum of 50 m of safe distance when approaching to mine support equipment and positioning the transportation means. Safe distance can be increased due to weather conditions.</p> <p>When approaching any heavy duty equipment keep at least 50 meters of distance away from the machine until radio communication with the operator is confirmed.</p> <p>Approach from the front or cab side of machine at all times, if possible.</p> <p>Note: it is prohibited to start movement towards the machine unless you know for sure that an operator sees you. Wait until ground engaging tools are grounded and maintain proper distance between you and equipment to execute maneuver if required.</p>	<p>Автомашинныг тусгайлан засаагүй талбайд (паркийн талбайгаас өөр газарт) удаан хугацаагаар тавихдаа заавал дугуйны ивээс хэрэглэнэ. Конусан тэмдгүүдийг тавьж бусад тээврийн хэрэгслүүдээс ялгаж өгнө.</p> <p>Цаг агаарын нөхцлөөс шалтгаалан хөдөлгүүрийг асаалттай орхин зогсолт хийх үед жолооч нь ослын дохионы гэрлээ асааж, гар тормосыг татсан байх ба дугуйнд ивээс хийсэн байх шаардлагатай.</p> <p><u>Тусгай зориулалтын машин механизм:</u></p> <p>Тусгай зориулалтын машин механизмыг (дозер, грейдер, ачигч гм) зогсоохдоо уг механизмын газарт буух хэсгүүдийг (хутга, соёо, шанага) заавал буулгана.</p> <p>Тусгай зориулалтын машин механизмд ойртох, тээврийн хэрэгслийг байрлуулах үед 50 метрээс багагүй аюулгүйн зай барих шаардлагатай. Цаг агаарын нөхцөлөөс шалтгаалж уг зайг ихэсгэж болно.</p> <p>Зогсож байгаа хүнд даацын машин механизмд ойртож ажиллахдаа радио станцаар оператортой холбоо барих хүртэл 50 метрээс дотогш ойртохыг хориглоно.</p> <p>Боломжтой бол тухайн машин техникийн зөвхөн урд талаас, эсвэл жолоочид гүйцэд харагдах талаас ойртоно.</p> <p>Санамж: оператор өөрийг чинь харж байгааг бүрэн мэдээгүй тохиолдолд хөдөлгөөн эхлэхийг хориглоно. Бүх гидрийг буулгахыг хүлээ шаардлагатай бол холдон гарах боломжтой хажуу болон хоорондын зайг барь.</p>
<p><u>Bus participation in traffic:</u></p> <p>The Bus Driver should not exceed the speed limit of 50 km at all times and drive according to road and weather conditions and provide traffic safety.</p> <p>The bus driver must start movement after ensuring that all passengers are wearing their seat belts.</p> <p>Maintain at least 50 meters of distance from equipment in front. Overtaking is allowed only if you have good visibility ahead, the road is straight, and you have contacted</p>	<p><u>Автобус:</u></p> <p>Автобусны жолооч хурдны хязгаарыг 50 км/ц –аас хэтрүүлэлгүй явах бөгөөд, зам болон цаг агаарын нөхцөлд хурдыг тохируулан, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангаж явбал зохино.</p> <p>Ээлжийн автобусны жолооч нь бүх хүмүүс бүрэн сууж, суудлын бүсээ бүсэлснийг шалгасны дараа хөдөлгөөнийг эхэлнэ.</p> <p>Замын хөдөлгөөнд оролцохдоо урд яваа машинаас 50 метрээс багагүй зайг барьж явах ба зөвхөн үзэгдэх орчин сайтай шулуун зам дээр, тоног төхөөрөмжийн</p>



ЭРДЭНЭ МОНГОЛ ХХК

## SAFE WORK PROCEDURE

Date/Огноо: 2022-07-10

Revision /шинэчлэлт: 00

Page/хуудас 11/12

PROCEDURE	ГОРИМ
<p>with the front equipment operator and received confirmation to pass.</p> <p>When parking to drop off people in active mining area, park at least 50 meters away from any equipment. Park on flat area and always try to park in designated parking area.</p> <p>If required to park on slope, the bus Driver must stay in the cab with the parking brake applied, or if required to leave the bus unattended, must turn the wheels toward to the high wall or safety berm and place wheel chocks to prevent roll over. Never park under or close to the high wall, when dropping off the personnel from bus.</p> <p>Shift change bus is prohibited to enter drill or blast pattern.</p> <p>Note: Shift Change Bus should avoid parking nearby high wall, if it is required to park there, maintain at least 50 m of safe distance.</p>	<p>оператороос зөвшөөрөл авсны дараа гүйцэж түрүүлнэ. Уурхайн идэвхтэй бүсэд зорчигчдыг буулгахдаа тоног төхөөрөмжөөс 50 метрээс багагүй зайтай зогс. Аль болох тэгш газарт зогсоно. Зориулалтын талбайг сонгохыг хичээ.</p> <p>Хэрвээ налуу газар зогсох шаардлагатай бол жолооч жолооныхоо ард байж, гар тормосоо татна. Бүхээгнээс гарах шаардлага тулгарвал, урд дугуйгаа карьерын хана, хөмсөгийг чиглүүлэн эргүүлж тээврийн хэрэгслийг өнхрөхөөс сэргийлнэ. Зорчигчдыг автобусаас буулгахдаа хэзээ ч өндөр хананы эгц дор зогсож болохгүй</p> <p>Ээлж солилцох автобус нь өрмийн болон тэсэлтээний талбайд орохыг хориглоно.</p> <p>Санамж: Ээлж солилцох автобус уурхайн өндөр хананы дор зогсохоос зайлхийх, хэрэв зайлшгүй зогсох шаардлага гарвал 50 метрээс багагүй зайд зогсолтыг хийнэ.</p>
<p><u>Freight transportation:</u></p> <p>Freight weight and the load per axle should not exceed the limit defined by the technical specifications of machine and equipment. The freight and materials should be fixed and tied meeting the following requirements:</p> <ul style="list-style-type: none"><li>- It shall not drop, fall and interrupt the traffic and cause hazards.</li><li>- Shall not limit driver's visibility.</li><li>- It shall not affect the vehicle stability, balance and cause inconvenience to driving.</li></ul> <p>In case of hauling freight with dimension exceeding 1 m of length and 0.4 m width an "oversized freight" sign should be placed on.</p> <p>Note: Oversized loads should only be transported during day light hours. For light vehicles it is prohibited to transport freight which length or width is exceeding 0.5 m of the vehicle dimensions.</p> <p><u>Emergency guidance:</u></p>	<p><u>Ачаа тээвэрлэх:</u></p> <p>Ачааны жин болон тэнхлэгт оногдох ачааллын хэмжээ нь тухайн тээврийн хэрэгслийн техникийн тодорхойлолтоор тогтоосон хэмжээнээс хэтрэхгүй байвал зохино. Ачааг дор дурьдсан шаардлагыг хангахаар байрлуулж бэхэлсэн байна.</p> <ul style="list-style-type: none"><li>- Унаж чирэгдэхгүй, хөдөлгөөнд оролцогчидод саад, аюул учруулахгүй байхаар,</li><li>- Жолоочийн харах боломжийг хязгаарлахгүй байхаар,</li><li>- Тээврийн хэрэгслийн тогтворжилтыг алдагдуулахгүй, жолоодлогыг хүндрүүлэхгүй байхаар бэхэлбэл зохино.</li></ul> <p>Тээврийн хэрэгслийн овроос уртаашаа нэг 1 метр, өргөшөө 0.4 метрээс илүү ачаа тээвэрлэхдээ түүний илүү гарсан хэсэгт /овор ихтэй ачаа/ таних тэмдэгийг байрлуулна.</p> <p>Санамж: Овор ихтэй ачааг зөвхөн өдрийн цагаар тээвэрлэнэ. Суудлын автомашинд түүний овроос урт буюу өргөнөөрөө 0.5 метрээс илүү гарсан ачаа тээвэрлэхийг хориглоно.</p> <p><u>Ослын үеийн мөрдлөг:</u></p> <p>Аливаа ослын үед бүх тоног төхөөрөмжүүд хийж байгаа</p>



ЭРДЭНЭ МОНГОЛ ХХК

## SAFE WORK PROCEDURE

Date/Огноо: 2022-07-10

Revision /шинэчлэлт: 00

Page/хуудас 12/12

PROCEDURE	ГОРИМ
<p>In case if emergency is declared all equipment must stop immediately (Equipment shall pull safely over to the side of road and stop). Drivers and operators must wait for further instructions from the supervisor.</p> <p>In case of recognizing the approaching ambulance vehicle and fire truck, drivers and operators must free the line and allow the emergency response vehicles.</p> <p><u>Note:</u> If road signs and traffic rules are changed or amended to Bayankhundii gold mine operations lease area all the changes made to Traffic Rules of mine and relevant information must be announced through information board and introduced at toolbox meetings. It's prohibited to change the road sign without confirmation of Health, Safety and Environmental Department. The only exception to above rule refers to signs in the active mining area. Signage is continually changing in the active mining area. Therefore, Mine Operations Department is in charge of changes of any signs and it must be approved by the Manager of Mine Operations Department.</p>	<p>ажлаа нэн даруй зогсоож /төхөөрөмжийг замын хажуу хэсэг лүү шахаж байрлуулна/, удирдлагаасаа дараагийн зааврыг хүлээнэ.</p> <p>Түргэн тусламж болон галын машин ойртож ирэхийг мэдсэн тохиолдолд жолооч/операторууд замын зорчих хэсгийг чөлөөлж, зам тавьж онцгой байдлын машинуудыг саадгүй өнгөрүүлнэ.</p> <p>Санамж: Баянхөндий алтны уурхайн Уурхайн лицензийн талбай дахь замын хөдөлгөөний дүрмэнд өөрчлөлт орсон мөн замын тэмдэг тэмдэглэгээнд аливаа өөрчлөлт орсон тохиолдолд энэ тухай мэдээллийг мэдээллийн самбарт тавьж ээлжийн өдөр тутмын зааварчилгаан дээр танилцуулна. Аюулгүй ажиллагааны хэлтсийн зөвшөөрөлгүйгээр замын аливаа тэмдэг тэмдэглэгээг өөрчлөхийг хориглох бөгөөд зөвхөн уурхайн идэвхтэй бүсэд л дээрхи нөхцөлгүйгээр өөрчлөлт хийгдэх боломжтой. Энэ бүсэд хийх өөрчлөлтийг уулын ашиглалтын хэлтэс хариуцах бөгөөд уулын ашиглалтын менежер батлана.</p>

## Хөнгөн тэрэгний өдөр тутмын үзлэгийн хуудас



Жолоочийн нэр \_\_\_\_\_

Түлш цэнэглэгдсэн эсэх \_\_\_\_\_

Километр \_\_\_\_\_

Машины дугаар \_\_\_\_\_

Огноо \_\_\_\_\_

Шалгах хуудас			Тэмдэглэл
Тээврийн хэрэгслийн гэрчилгээ		Хаалга их бие	
Даатгалын бичиг баримт		Шил толь	
Анхны тусламжийн хайрцаг		Моторын маслын түвшин	
Гал унтраагуур		Сэнс ба ремень	
Ослын гурвалжин		Антифризийн түвшин	
Станц/ Гар болон суурин		Аккумулятор / бэхэлгээнүүд	
Маяк		Үрүүлийн систем түүнийг шалга	
Туг болон антен		Бүх төрлийн шингэний түвшин	
Дугуйн эвүүр		Суудал / суудлын бүс	
Дамхрад / суурин эвүүр		Тормосны систем	
Шил арчигчын ажиллагаа		Гэрлүүд	
Дугуй болон Запасууд		Дугуй / Обуд	
Дугуйн торцоп / түлхүүр багаж		Их биеийн гэмтэл	
Хянах самбрын заалтууд		Хэвийн бус дуу гарах	
Удирдлагын товчлуурууд		Эвдрэл илэрсэн	

Би өгөгдсөн бүх зааварчилгааг ойлгосон ба учирч болзошгүй бүх аюулыг ухамсарлаж,  
Шаардлагатай хэрэгслүүдийг хэрэглэх болно. Гарын үсэг \_\_\_\_\_



## Хөнгөн тэрэгний өдөр тутмын үзлэгийн хуудас

Жолоочийн нэр \_\_\_\_\_

Түлш цэнэглэгдсэн эсэх \_\_\_\_\_

Километр \_\_\_\_\_

Машины дугаар \_\_\_\_\_

Огноо \_\_\_\_\_

Шалгах хуудас			Тэмдэглэл
Тээврийн хэрэгслийн гэрчилгээ		Хаалга их бие	
Даатгалын бичиг баримт		Шил толь	
Анхны тусламжийн хайрцаг		Моторын маслын түвшин	
Гал унтраагуур		Сэнс ба ремень	
Ослын гурвалжин		Антифризийн түвшин	
Станц/ Гар болон суурин		Аккумулятор / бэхэлгээнүүд	
Маяк		Үрүүлийн систем түүнийг шалга	
Туг болон антен		Бүх төрлийн шингэний түвшин	
Дугуйн эвүүр		Суудал / суудлын бүс	
Дамхрад / суурин эвүүр		Тормосны систем	
Шил арчигчын ажиллагаа		Гэрлүүд	
Дугуй болон Запасууд		Дугуй / Обуд	
Дугуйн торцоп / түлхүүр багаж		Их биеийн гэмтэл	
Хянах самбрын заалтууд		Хэвийн бус дуу гарах	
Удирдлагын товчлуурууд		Эвдрэл илэрсэн	

Би өгөгдсөн бүх зааварчилгааг ойлгосон ба учирч болзошгүй бүх аюулыг ухамсарлаж,  
Шаардлагатай хэрэгслүүдийг хэрэглэх болно. Гарын үсэг \_\_\_\_\_

**Төслийн талбайд нэвтрэх зөвшөөрлийг 48 цагийн өмнө бүрдүүлж хамаарал бүхий хэлтсийн менежер болон холбогдох хүмүүст илгээнэ.** Access Requests must be made 48 hours in advance of any visit or routine requirement.



Тохирох нүдийг бөглөх хэрэв <b>Тийм бол</b> <input checked="" type="checkbox"/> <b>Эсвэл</b> <b>X</b> тэмдэглэгээг хийнэ үү- Please use if yes tick yes or cross X to indicate your selection.			
<b>Хүсэлтийн төрөл / Type of permit</b>		<b>Кемп-д байрлах гэр байгаа эсэх/Accommodation availability</b> <input type="checkbox"/>	
Шинээр нэвтрэх хүсэлт New Booking <input type="checkbox"/>	Өмнөх хүсэлтэд өөрчлөлт хийсэн; Changes to an existing booking <input type="checkbox"/>	Байр шаардлагатай эсэх? Accommodation Required <input type="checkbox"/>	Төлбөрийн асуудал тавигдах? Payment consideration? T/y <input type="checkbox"/> Y/n <input type="checkbox"/>
<b>Ажилтан / Зочны мэдээлэл</b>		<b>Машины дугаар / Vehicle number ( )</b>	
Үндсэн ажилтан Direct Employee <input type="checkbox"/>	Гэрээт ажилтан ( ) Contractor employee <input type="checkbox"/>	Ирэх огноо / Arrival date 2022 / / Time	Буцах огноо / Leave date 2022 / / Time
<b>Нэрс / Names</b>		<b>Сургалт зааварчилгааны шаардлага/ Induction &amp; training</b>	
1.	Хариуцах хүн/contact person	Зочны зааварчилгаа Visitor induction <input type="checkbox"/>	Кемпийн зааварчилгаа Camp induction <input type="checkbox"/>
2.		Бүрэн зааварчилгаа Full induction <input checked="" type="checkbox"/>	Төслийн талбайд урьд нь ажиллаж байсан эсэх / The employee did work at previously at BK site? Тийм/yes <input type="checkbox"/> Үгүй/no <input type="checkbox"/>
3.	ХҮЙС / gender	Нэмэлт сургалт What training required? <input type="checkbox"/>	
4.			
5.	Эм / Female <input type="checkbox"/> №		
6.			
<b>Сайтад нэвтрэх ажлын зорилго/ Purpose of access to Bayan-Khundii site.</b>			
<b>Шууд удирдлага / Line manager</b>		<b>Төслийн менежер / Authorized by SITE MANAGER</b>	
<b>Нэр / Name:</b>		<b>Нэр / Name</b>	
<b>Гарын үсэг болон Огноо</b> Signature & Date:		<b>Гарын үсэг болон Огноо</b> Signature & Date:	

**Route from Bayankhongor province to Sinejinst to BK project site. Газар зүйн байршил замын маршрутын талаарх мэдээлэл.**

[1\\_Employee\\_Transport\\_Route\\_trans\\_exported.kmz](#) Энэхүү KMZ өргөлтгөл бүхий FILE-г хуулбарлан авч жолоочид дамжуулан өгөх шаардлагатай. Жолооч уг FILE-г өөрийн гар утсан дахь MAPS ME аппликейшнд хөрвүүлэн суулгаснаар Баянхонгор аймгаас Шинэжинст сум мөн төслийн талбайд хүрэх нарийвчилсан чиглэлийг авах боломжтой болно.

1-р алхам FILE-г аливаа төрлийн мессенжер аппликейшнаар хүлээн авагчид илгээнэ.

2-р алхам FILE-г хүлээн авагч дээр нь товшин нээнэ. FILE-г нээхэд доорх дүрслэл гарч ирнэ. Улаанаар тойруулсныг дарна. /Зураг1/ Мөн улаанаар тойруулсан MAPS ME аппликейшны сонголт гарч ирнэ /Зураг2/. Түүний дараа зураг 3 дахь илэрц MAPS ME дээр илэрнэ. Уг маршрутыг дагаад л явхад болно.



Жолоочийн нэр \_\_\_\_\_ Шатахуун цэнэглэгдсэн эсэх \_\_\_\_\_

Километр \_\_\_\_\_ Машины дугаар \_\_\_\_\_ Огноо \_\_\_\_\_

Шалгах хуудас			Тэмдэглэл
Тээврийн хэрэгслийн гэрчилгээ		Хаалга их бие	
Даатгалын бичиг баримт		Шил толь	
Анхны тусламжийн хайрцаг		Моторын маслын түвшин	
Гал унтраагуур		Сэнс ба ремень	
Ослын гурвалжин		Антифризийн түвшин	
Станц/ Гар болон суурин		Аккумулятор / бэхэлгээнүүд	
Маяк		Үрүүлийн систем түүнийг шалга	
Туг болон антен		Бүх төрлийн шингэний түвшин	
Дугуйн эвүүр		Суудал / суудлын бүс	
Дамхрад / суурин эвүүр		Тормосны систем	
Шил арчигчын ажиллагаа		Гэрлүүд	
Дугуй, багадаа 2 запас		Дугуй / Обудны нөхцөл	
Дугуйн торцоп / түлхүүр багаж		Их биеийн гэмтэл	
Хянах самбран заалтууд		Хэвийн бус дуу гарах	
Удирдлагын товчлуурууд		Дугуй хийлэгч	

Би өгөгдсөн бүх зааварчилгааг ойлгосон ба учирч болзошгүй бүх аюулыг ухамсарлаж, Шаардлагатай хэрэгслүүдийг хэрэглэх болно. Гарын үсэг \_\_\_\_\_

**АЯЛАЛ ТЭЭВРИЙН ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАХ ХЭСЭГ / TRAVEL AUTHORITY CHECKLIST**

Сонгогдсон Аяллын ахлагчын нэр / Name of Nominated Journey leader	Төлөвлөгдсөн жолооч / Designated Driver		
Компанийн Нэр / Name of Company	Машины Загвар / Vehicle Type		
Сансрын Холбоо: Mobile or Satellite No: Утасны Дугаар: Contact No:	Аяллын ойролцоогоор тооцоологдсон цаг / Estimated Time of Departure:		
<b>ТХ-Д БАЙХ ЁСТОЙ ЗҮЙЛС / ITEMS WHICH HAS TO BE IN THE VHL</b>	<b>Гүйцэтгэл T/Y Yes or No</b>		
Хүн бүрт хүрэлцэхүйц ус (Хүн бүрт доод тал нь 5л) Water for each person in journey (min 5 L per person)	T	Y	X
MAPS ME аппликейшнийг гар утсандаа суулгаж маршрутыг тогтоосон эсэх, MAPS ME application & KMZ is intalled ?	T	Y	X
Сансрын холбооны утас (Дугаарыг аяллын менежерт өгсөн байх) Satellite Phone (number to be given to Journey Manager)	T	Y	X
Онцгой байдлын үед ашиглах хайрцаг / Emergency kit	T	Y	X
Хүрз / Shovel	T	Y	X

**Жолооч,** Би аяллын Зохицуулалтын Журмыг дагаж мөрдөхөө баталж байна. Мөн дээрх тоног төхөөрөмжийг хүлээж авлаа. Driver, I Certify that I have complied with the requirements of the ERD Journey Management Procedure and have received the equipment listed above. Name / Нэр: \_\_\_\_\_ Signature / Гарын үсэг \_\_\_\_\_

**Аяллын ахлагчтай байна /Travel leader/. Жишээ нь: тээврийн хэрэгсэлд зорчиж буй зорчигчдоос тодорхой удирдах түвшний ажилтныг сонгосон байна.**

Аяллын талаарх мэдээлэл дамжуулах урсгалыг зөв сонгох ёстой. Жишээ нь: амралтын өдрүүдээр зорчих тохиолдолд УБ хотын оффист ажиллаж байгаа ажилтаны амралтын өдөр байх тохиолдол бий харин төслийн талбайн ажилчид аль ч цагт аяллын ахлагчтай харилцахад хэзээд бэлэн байх болно.

Аяллын ахлагч нь аялалд гарахын өмнө замын турш дайран өнгөрөх болон хүрэх гэж зориж буй орон нутгын цаг агаарын нөхцөл байдлыг ус цаг уур орчны шинжилгээний мэдээллийн сангаас шалгасан байх шаардлагатай.

Аяллын ахлагч нь тухайн хамаарал бүхий хэлтэс салбарын ажилтантай аяллын турш харилцах ёстой. Тэрхүү харилцах ажилтан нь төслийн талбайд байрлаж буй хүн байх ёстойг анхаарна уу.

Аяллын ахлагч нь аяллын мэдээг 2 цаг тутамд өгч байх ёстой ба хэрэв утасны сүлжээгүй орчинд зорчиж байгаа тохиолдолд сансрын утсаар мэдээллээ заавал өгөх ёстой.

Мэдээллийг хүлээн авсан төслийн талбай дахь ажилтан нь төслийн менежерт цаг тухай бүрт нь илтгэж байх шаардлагатай.

Хэрэв цаг агаарын таагүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд аяллыг зогсоох аятай тухай орчинд хонож өнжих саналыг төслийн менежерт яаралтай хүргүүлэх шаардлагатай.

Хурдны хязгаарыг Монгол улсын замын хөдөлгөөний журмын дагуу захин мөрдөх бөгөөд замын болон цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалж хурдыг тохируулан зорчих шаардлагатайг анхаарна уу.

Жолооч хангалттай унтаж амарсан байх бөгөөд биеийн болон сэтгэл зүйн хувьд ажлаа хийж гүйцэтгэхэд бэлэн байх шаардлагатай.

**ЗУНЫ ХУВААРЬ болон цагын зохицуулалт, хязгаарлалт**

1	Улаанбаатраас Баянхонгор-руу хөдлөх	630км	10 цаг	08:00 цагаас хойш Улаанбаатраас хөдлөхийг хориглоно.
2	Баянхонгороос Шинэжинст-рүү мөн Төслийн талбайруу хөдлөх	350км	8 цаг	11:00 хойш Баянхонгороос хөдлөхийг хориглоно.

Хэрэв цагын хязгаарлалтаас хэтэрсэн тохиолдолд төслийн менежерээс /түүний орлогч/ зөвшөөрөл авсны үндсэн дээр зочих боломжтой

Сансрын утсыг ашиглахдаа:

Асаах товчыг удаан дарна.

1. Пин код хийлгүйгээр асхаар тохируулсан байгаа учир шууд асна
2. Дээвэргүй ил задгай газар гарна.
3. Дэлгэцийн зүүн дээд буланд сүлжээ орж ирж буйг илэрхийлнэ.
4. Сүлжээ илэрмэгц 0 товчлуурыг удаан дарж + тэмдэг гаргана зарим тохиолдолд тоон товчлуурыг дархад + тэмдэг шууд гарна.
Илэрхийлэгч амьтны зүйл	Хавтгай тохиолдож болно. Зарим алагдаагны зүйл тохиолдоно. Зарим зүйл амьтан хамгийн нам дор байх хотгор газарт тохиолдоно.
Газрын зурагт буулгах арга	NDVI нь 0.045 ба 0.065-ийн хооронд байна.

Зураг 17. Хэт гандуу цөлийн тодорхойлолт.

Экосистемийн хэв шинж	Жинхэнэ цөл
Зонхилох ургамалшил	Цөл газар түгээмэл тохиолдох заг ( <i>Haloxylon ammodendron</i> ) улаан бударгана ( <i>Reaumaria</i> ).
Амьдрах орчны үндсэн хэв шинж	Бутлаг ургамал ургана, гэхдээ нягтшлын хувьд бага оочин цоочин байх ба ургамлын нөмрөгийн хувьд ч мөн л дорой.
Хөрсний хэв шинж	Чулуун дэвсгэр эсвэл элсэрхэг хөрс.
Түгээмэл шинж	Намхан бут (<0.5 метр), зарим нэгэн багахан хэмжээтэй газарт усан хангамж бага зэрэг их байснаас шалтгаалж арай өндөр ургаж болно.
Илэрхийлэгч ургамлын зүйл	Заг ( <i>Haloxylon ammodendron</i> ) улаан бударгана ( <i>Reaumaria</i> ).
Илэрхийлэгч амьтны зүйл	Ийм орчинд хавтгай, хулан хааяа үзэгдэж болох бөгөөд олон зүйл шувуудын тухайд өндөр ургасан ургамал их ач холбогдолтой.
Газрын зурагт буулгах арга	NDVI нь 0.065 ба 0.08-ийн хооронд байна.

Зураг 18. Жинхэнэ цөлийн тодорхойлолт.

Экосистемийн хэв шинж	Хээржүү цөл
Зонхилох ургамалшил	Цөлийн бутлаг ургамал (баглуур <i>Anabasis</i> , заг <i>Haloxylon</i> , зээргэнэ <i>Ephedra</i> , бударгана <i>Reaumaria</i> )–тай холилдон ургах өвслөг ургамал тохиолдоно.
Амьдрах орчны үндсэн хэв шинж	Цөлд түгээмэл ургах бутлаг ургамал заримдаа өвслөг ургамал (e.g. <i>Stipa glareosa</i> ) -тай мөн таана (e.g. <i>Allium mongolicum</i> )-тай холилдон ургах нь бий.
Хөрсний хэв шинж	Баглуур ( <i>Anabasis</i> )–ийн дорх хөрс нь ерөнхийдөө чулуулаг дэвсгэр хөрс бөгөөд түүний өнгөн хөрс салхины нөлөөгөөр алга болсон байх нь бий. Хэдийгээр заг иймэрхүү орчинд ургаж болох хэдий ч ихэвчлэн тэгш бус гадаргатай элсэрхэг хөрсөнд ургана. Давсны агууламж янз бүр байх ба заримдаа хааяа нэг газар маш өндөр ч байх нь бий.
Түгээмэл шинж	Цөлийн бутлаг ургамал хааяадаа өвслөг ургамал мөн эмийн шинж чанартай ургамалтай холилдон ургана.
Илэрхийлэгч ургамлын зүйл	Заг ( <i>Haloxylon ammodendron</i> ) ба баглуур ( <i>Anabasis</i> )
Илэрхийлэгч амьтны зүйл	Хөхтнөөс хавтгай, хулан, хааяа тахь, цагаан зээр, шувуудаас чогчоохой, шонхор, хулан жороо, дунхай.
Газрын зурагт буулгах арга	NDVI нь 0.08 ба 0.1125-ийн хооронд байна.

Зураг 19. Хээржүү цөлийн тодорхойлолт.

Экосистемийн хэв шинж	Цөлжүү хээр
Зонхилох ургамалшил	Хялгана ( <i>Stipa</i> ) давамгайлж, цөлийн бутлаг ургамал алга болно.
Амьдрах орчны үндсэн хэв шинж	Өвслөг ургамал ба эмийн ургамал давамгайлна. Өнөөгийн уур амьсгалтай уялдуулах бол зарим тохиолдолд газрын гадаргууг бүрхэх үнэ цэнийн хувьд ач холбогдолтой болж ирнэ.
Хөрсний хэв шинж	Ерөнхийдөө шаварлаг хөрс зонхилно. Салхины элэгдлээс болж үүссэн чулуурхаг дэвсгэр хааяа тохиолдоно.
Түгээмэл шинж	Ургамлын зүйлийн олон янз байдал нэмэгдэнэ. Хялгана ( <i>Stipa</i> ), таана ( <i>Allium</i> ) илүүтэй давамгайлна.
Илэрхийлэгч ургамлын зүйл	<i>Stipa glareosa</i> , <i>Stipa gobica</i> , <i>Allium mongolicum</i> , <i>Allium polyrrhizum</i> , <i>Caranaleucophloea</i> , <i>Ephedra</i> , <i>Eurotiaceratoides</i>
Илэрхийлэгч амьтны зүйл	Хулан, тахь, цагаан зээр тааралдахаас гадна гэрийн мал (хонь, ямаа)-ын тоо толгой нэмэгдэнэ.
Газрын зурагт буулгах арга	NDVI нь 0.1125 ба 0.15-ийн хооронд байна.

Зураг 20. Цөлжүү хээрийн тодорхойлолт.

Экосистемийн хэв шинж	Хужир мараалаг цайдам хотгор
Зонхилох ургамалшил	
Амьдрах орчны үндсэн хэв шинж	Голын хуурай сайр эсвэл гадагш урсацгүй хэв шинжтэй газрын доорх ус ойр, хужир мараалаг хотгор. Ийм орчин өвөрмөц ургамлын бүрдлийг тэтгэж байдаг болно (нийт бүс нутгийн хүрээнд заган төгөл, Дорнод говьд хайлаас, Алтайн-өвөр говьд тоорой). Физик газарзүйн хувьд гадаргууд ойр байрлалтай газрын доорх ус, усны сүлжээний онцлогоос шалтгаалаад хөрсний олон хэв шинж агуулдаг.
Хөрсний хэв шинж	Шаварлаг эсвэл элсэрхэг хөрс зонхилох бөгөөд голын голдрилын буюу сайр дагуу бол чулуурхаг болж ирнэ.
Түгээмэл шинж	Бүтээмж ихтэй экосистем бөгөөд баянбүрдийн төгөл зэрэг сэтгэл татам үзэмжит байдал ихтэй.
Илэрхийлэгч ургамлын зүйл	Тоорой, Хайлаас, Заг, Сухай зэрэг модлог ургамал
Илэрхийлэгч амьтны зүйл	Ургамал ба хөрсний харьцангуй бүтээмж, хэв шинжийн олон янз байдлаас шалтгаалаад эдгээр орчин олон зүйлийн жижиг хөхтөн, мөлхөгчдийг тэтгэх орчин болдог (Н. Батсайхан зөвлөмж).

Зураг 21. Хужир мараат цайдам хотгорын тодорхойлолт.

Экосистемийн хэв шинж	Баянбүрд орчмын өтгөн шигүү ургамалшил бүхий орчин - булаг, шанд даац
Зонхилох ургамалшил	Ихэвчлэн баянбүрдийн ойролцоо ажиглагдах цэгэн хэлбэрээр бие биендээ ойрхон зайтай байрлах өндөр ургасан мод, сөөг - сухай, тоорой, хайлаас, заг.
Амьдрах орчны үндсэн хэв шинж	Үржил шим ихтэй хужир мараалаг нуга.
Хөрсний хэв шинж	Шаварлаг эсвэл элсэрхэг хөрс ихэвчлэн давсны агууламж ихтэй
Түгээмэл шинж	Зөвхөн Говьд л байж болох зүйлийн болоод байгалийн өвөрмөц бүрдэл, эрс тэс ялгаатай ургамлын бүрдэл.
Илэрхийлэгч ургамлын зүйл	<i>Blysmus</i> , <i>Triglochin</i> төрөл.
Илэрхийлэгч амьтны зүйл	Мазаалай, эргийн шувууд, мөн мод шүтэж амьдардаг олон зүйлийн шувууд.

Зураг 22. Булаг, шанд, даацын тодорхойлолт.

Экосистемийн хэв шинж	Баянбүрд орчмын шигүү өтгөн ургамалшилтай орчин-сайр, цайдам
Зонхилох ургамалшил	Ихэвчлэн баянбүрдийн ойролцоо ажиглагдах цэгэн хэлбэрээр бие биендээ ойр ургасан өндөр мод, сөөг, болон мод-сухай, тоорой, хайлаас, заг.
Амьдрах орчны үндсэн хэв шинж	Өндөр ургасан сөөг нь 2 м ба түүнээс ч өндөр ургана.
Хөрсний хэв шинж	Шаварлаг эсвэл элсэрхэг хөрс ихэвчлэн давсны өндөр агууламжтай.
Түгээмэл шинж	Зөвхөн Говьд л байж болох зүйлийн болоод байгалийн өвөрмөц бүрдэл, эрс тэрс ялгаатай ургамлын бүрдэл.
Илэрхийлэгч ургамлын зүйл	<i>Tamarix</i> , <i>Populus</i> , <i>Ulmus</i> зэрэг модлог ургамал.
Илэрхийлэгч амьтны зүйл	Мазаалай, эргийн шувууд, мөн мод шүтэж амьдардаг олон зүйлийн шувууд.

Зураг 23. Сайр цайдамын тодорхойлолт.

Экосистемийн хэв шинж	Тарамцаг элс
Зонхилох ургамалшил	Жижиг элсэн манханд алаг цоог ургах хармагийн сондуул, элсэрхэг хөрсөнд ургах <i>Psamochloa</i> төрөл.
Амьдрах орчны үндсэн хэв шинж	Манхан элс бүхий уудам газар.
Хөрсний хэв шинж	Элс.
Түгээмэл шинж	Манхан элс.
Илэрхийлэгч ургамлын зүйл	Манхан элсний усны сүлжээний онцлог шинж чанар нь багахан хэмжээний чийглэг газрыг бий болгодог бөгөөд тэнд нь амьтан ба ургамлын зүйлийн бүрдэл өндөр байх нь бий. Эдгээр чийглэг орчныг хужир мараалаг нуга гэж ангилах бөгөөд бид энэ тухай дээр дурьдсан: булаг шандаар тэжээгдэж байгаа баянбүрдийн эргэн тойрны өтгөн шигүү ургамалшил.
Илэрхийлэгч амьтны зүйл	

Зураг 24. Тарамцаг элсний тодорхойлолт.

БАЯНХОНГОР АЙМГИЙН ШИНЭЖИНСТ СУМАНД  
МОНГОЛ ТАРВАГА НУТАГШУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН.

2022 оны 07 дугаар сарын 26

Залаа

Баянхонгор аймгийн БОАЖГ, Шинэжинст сумын ЗДТГ, Отгон-Бор Хавцал ТББ-ын хамтарсан гэрээний дагуу зэргэлдээ Баянөндөр сумын нутгаас 20 толгой тарвага мэргэжлийн байгууллага барьж 2022 оны 05 сарын 28-нд тус сумын Уртын гол 2-р багийн нутаг Хатан хайрхан гэдэг газар нутагшууллаа.

Тарвага сэргээн нутагшуулах ажлын зардал 8,3 сая төгрөгийг “Хонгор Тогтвортой Хөгжил” ТББ санхүүжүүлсэн.



Тарвага нутагшуулах ажилд Сумын ЗДТГ-ын албан хаагчид, 4-н багийн засаг дарга нар, сумын БОХУБ Ш.Бямбацогоо, Байгаль хамгаалагч нар хамтран оролцож хяналт тавин хүлээн авсан.

Мөн нутгийн малчин Б.Отгонбаатар хамт явж газар сонгох болон зам заах, нутагшуулсан тарваганд ажиглалт мониторинг хийх ажилд хамтран ажиллаж байна.

Тарвага нутагшуулсан цагаас эхлэн байгаль хамгаалагч Н.Мөнхдалай миний бие 7 хоног тутам очиж автомат камер сольж байршуулах, ажиглалт мониторинг хийн ажиллаж нутгийн иргэдэд хайрлан хамгаалах талаар сурталчилан ажиллаж байна.






Нутагшуулсан тарваганд гадны хулгайн ан, чоно нохой, бүргэд шувуу зэрэг аюул одоогоор ажиглагдаагүй байна.

Тарвага нутагшуулсан газрынхаа хуучин нүхнүүдийг сэргээн 4-н нүх ухсан нь ажиглагдаж байна.

ТАЙЛАН ГАРГАСАН  
БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧ  
Н.МӨНХДАЛАЙ

ХЯНАСАН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Г.ӨЛЗИЙБАТ

	<b>АРХЕОЛОГИ, ПАЛЕОНТОЛОГИЙН ОЛДВОР ОЛДСОН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ</b>			
	Approved Date Батлагдсан огноо:	Revision Шинэчлэлт:	Policy developed by Журмыг боловсруулсан:	Approved by Баталсан:
Policy # ___	01/4/2022	002	П.Өлзий-Ундрах БОНС-ийн мэргэжилтэн	 Peter Akerley, CEO



ЭРДЭНЭ МОНГОЛ ХХК

## АРХЕОЛОГИ, ПАЛЕОНТОЛОГИЙН ОЛДВОР ОЛДСОН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон Байгаль орчны холбогдох хууль, журмыг үндэслэсэн. Энэхүү журам нь өрөмдлөг хайгуул, барилга угсралт, уурхайн ашиглалт, хаалтын үе шатуудад “Эрдэнэ Монгол” ХХК-ны бүхий л төслийн талбайнуудад хамаарч үйлчилнэ.

- 1.1. “Эрдэнэ Монгол” ХХК болон тус компанийн бүх тусгай зөвшөөрөл бүхий талбайнуудад ажиллаж буй гэрээт компаниудын үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор олдохтой холбогдон үүссэн харилцааг зохицуулна.
- 1.2. Энэхүү журамд хэрэглэгдэх дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.
  - 1.2.1. соёлын өв: түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий өвийг;
  - 1.2.2. соёлын биет өв: түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх биетээр оршин байгаа дурсгалыг;
  - 1.2.3. түүх, соёлын үл хөдлөх дурсгал: унаган газартаа хүрээлэн байгаа орчны хамт үнэ цэнэ, ач холбогдол нь илэрхийлэгдэх дангаар болон цогцолбор байдлаар орших дурсгалыг;
  - 1.2.4. түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл: тодорхой орон зайд шилжүүлэн байрлуулах боломжтой дурсгалыг.

- 1.3. Энэхүү журмыг “Эрдэнэ Монгол” ХХК болон төслийн талбайд ажиллаж буй туслан гүйцэтгэгч компаниуд нэгэн адил дагаж мөрдөнө.

#### **Хоёр. Ерөнхий шаардлага**

“Эрдэнэ Монгол” ХХК болон гэрээт компаниуд дараах зарчмыг барилтлана.

- 2.1. Холбогдох хууль, журам болон стандарт шаардлагуудыг сахин мөрдөх;
- 2.2. Үйл ажиллагааны улмаас учирч болзошгүй эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгах;
- 2.3. “Эрдэнэ Монгол” ХХК-ийн ЭМААБО-ны бодлогын бичиг баримтыг дагаж мөрдөх;
- 2.4. БОННУ/Байгаль орчины нийгмийн нөлөөллийн үнэлгээ/-нд тусгасан шаардлагыг дагаж мөрдөх;
- 2.5. Үндсэн болон гэрээт компаний ажилчдад соёлын өвийн талаар мэдээлэл, зааварчилгаа өгөх;

#### **Гурав. Үйл ажиллагааны зарчим**

- 3.1. Эрдэнэ Монгол ХХК төсөл хэрэгжүүлэхээс өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар хайгуул, судалгаа хийлгэнэ.
- 3.2. Төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад соёлын биет өв илэрвэл ажлаа зогсоож энэ тухай сумын засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.
- 3.3. Соёлын өвийн олдвор олдсон тохиолдолд илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор тухайн сумын бүртгэл мэдээллийн санд бүртгүүлнэ.
- 3.4. Соёлын олдвор олдсон тохиолдолд авран хамгаалах арга хэмжээ авна.
- 3.5. Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 59-р зүйлийг үндэслэн гэрээт харуул хамгаалалтыг байгуулна.
- 3.6. Соёлын өв илэрсэн газруудад ажиглалт мониторинг хийнэ.

#### **Дөрөв. Хариуцлага**

- 4.1. Энэхүү журмыг зөрчсөн ажилтан, албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол “Хөдөлмөрийн дотоод журам”, тухайн ажилтантай байгуулсан “Хөдөлмөрийн гэрээ”-нд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 4.2. Туслан гүйцэтгэгч компани, албан тушаалтан нь энэхүү журмыг зөрчсөн болох нь тогтоогдвол тус компанитай байгуулсан гэрээнд заасны дагуу хариуцлага ногдуулах ба буруутай ажилтанд хариуцлага хүлээлгэх талаар албан шаардлага хүргүүлнэ.
- 4.3. Журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

**FIRST AID TRAINING SCHEDULE FROM JUNE TO AUGUST, 2022**

DATE ОГНОО	SUBJECT АНХНЫ ТУСЛАМЖИЙН СУРГАЛТЫН СЭДЭВ	RESPOSIBLE FOR
JUN 18	Артерын даралт ихсэх үед үзүүлэх тусламж, арга хэмжээ/First aid for high blood pressure	First Aid Clinic
JUN 25	Гэмтлийн үед үзүүлэх анхны тусламж/ First aid in case of injury	First Aid Clinic
JUL 2	Цус алдсан үед үзүүлэх анхны тусламж/First aid for bleeding	First Aid Clinic
JUL 9	Нүд, чихэнд гадны биет орох үеийн анхны тусламж/First aid for foreign bodies in eyes and ears	First Aid Clinic
JUL 16	Могой, хорхой шавьжинд хатгуулсан, хазуулсан үеийн анхны тусламж/First aid for snake and insect bites	First Aid Clinic
JUL 23	Амьсгалын замын үйл ажиллагаа алдагдсан үед үзүүлэх анхны тусламж/ First aid for respiratory failure	First Aid Clinic
JUL 30	Түлэгдэлтийн үеийн анхны тусламж/First aid for burns	First Aid Clinic
AUG 6	Өндөр хүчдэлд цохиулах үеийн анхны тусламж/ First aid in case of high voltage shock	First Aid Clinic
AUG 13	Нүдний гэмтлийн үед үзүүлэх тусламж	First Aid Clinic
AUG 20	Химийн бодист хордох үеийн анхны тусламж	First Aid Clinic
AUG 27	Цацрагийн осол хордлогын үеийн анхны тусламж	First Aid Clinic
SEP 3	Зүрх зогсох үед үзүүлэх анхны тусламж	First Aid Clinic
SEP 10	Наранд цохиулах буюу наршсан үед үзүүлэх анхны тусламж	First Aid Clinic
SEP 17	Стресс-н удирдлага	First Aid Clinic
SEP 24	Усанд живэх үед үзүүлэх анхны тусламж	First Aid Clinic
OCT 1	ABCD Амьлуулах суурь тусламж	First Aid Clinic
OCT 8	Зөөлөн эдийн гэмтлийн тусламж	First Aid Clinic
OCT 15	Биед зоогдсон гэмтлийн үед үзүүлэх тусламж	First Aid Clinic
OCT 22	Хамраас цус алдах үеийн анхны тусламж	First Aid Clinic
OCT 29	Эрхтэн тасрах үеийн анхны тусламж	First Aid Clinic
NOV 5	Угаартсан үед үзүүлэх анхны тусламж	First Aid Clinic
NOV 12	Шок Цочрол	First Aid Clinic
NOV 19	Няцралт ба дарагдсан гэмтэл	First Aid Clinic
NOV 26	Хэвлийн хөндийн гэмтэл	First Aid Clinic
DEC 3	Толгойн гэмтэл	First Aid Clinic
DEC 10	Нуруу нугасны гэмтэл ба тээвэрлэлт	First Aid Clinic
DEC 17	Астма -н үеийн тусламж / гуурсан хоолойн багтраа	First Aid Clinic
DEC 24	Ухаан алдалт, даталтын үед үзүүлэх анхны тусламж	First Aid Clinic
DEC 31	Тархины цус харвалтын үед үзүүлэх анхны тусламж	First Aid Clinic
JAN 07	Хүйтний нөлөөний үеийн анхны тусламж	First Aid Clinic
JAN 14	Диабит / Чихрийн шижин	First Aid Clinic
JAN 21	Харшил / Ходлого	First Aid Clinic
JAN 28	Мансуурсан үеийн анхны тусламж	First Aid Clinic

*Note: The First Aid training will be conducted on every Saturday at 20:00 pm in the REC ROOM.*



СУРГАЛТЫН БҮРТГЭЛИЙН МАЯГТ  
TRAINING RECORD FORM

Revision /шинэчлэлт: 01

Date/Огноо: 2020.02.01

Page/хуудас 1/1

TRAINING TOPIC:  
СУРГАЛТЫН  
СЭДЭВ:

АНАМЫ ТУСЛАМНА  
Андаа Шатны үзүүлэх сургалт.

Instructor Name:  
Сургагчийн нэр:

ИМЧ  
Хүснэгт тусламна

Date of Training: Сургалт  
явагдсан огноо:

15.07.2020д.

Continue hours & minutes  
Үргэлжилсэн цаг, минут:

08:00-08:00  
минут.

№	NAME (print) НЭР(дармалаар)	Position Албан тушаал	Гарын үсэг/Signature
1	Ормол	Организац.	Ормол
2	Дансажав.	баримтгүй адлах.	Дансажав
3	Минхзаяо	- x -	Минхзаяо
4	Б. Монтхболд	- x -	Монтхболд
5	ЭРЭНЭБАТ	НОХООГ	ЭРЭНЭБАТ
6	Д. Тунис дорь	Туслах	Д. Тунис дорь.
7	Х. Уртнасан	- x -	Уртнасан.
8	Х. Бамбаатар	- x -	Бамбаатар
9	М. Пуров-ошир	Молоот	Пуров
10	Т. Чойжинжав	- x -	Т. Чойжинжав
11	Б. Болоршия	оператор	Болоршия
12	Т. Шуман тугал	Тиймнэг	Шуман тугал
13	М. Монголзуу	Тиймнэг	Монголзуу
14	Н. Урчимпилсэв	Молоот	Урчимпилсэв
15	Э. Энхсайхан	А/амьттан	Энхсайхан
16	НОВСОЛБОО	Кемп менежер	НОВСОЛБОО
17	Ёндонсамбуу	ГМС ХАМГААЛАГЧ	Ёндонсамбуу
18	Отгонбаяр	ГМС АХЛАХ	Отгонбаяр
19	<del>Отгонбаяр</del> Сосило тугал	ГМС - АХЛАХ	Сосило тугал
20	М. Чулуулбаг	ERD - ИО Мэргэжилтэн	Чулуулбаг
21	Д. Валантмав	HR	Валантмав
22	С. МОНГОНТУЛГА	ОНХА.	С. Монголзуу.

Instructor's signature / Зааварлагчийн гарын үсэг

ИМЧ



ЭРДЭНЭ МОНГОЛ ХХК

БАЯН ХӨНДИЙ ТӨСӨЛ/BAYAN KHUNDII PROJECT

### Training/Induction Attendance Sheet

### Сургалт/Зааварчилгааны бүртгэлийн хуудас

Date/Огноо

2022.06.04

Department/Хэлтэс

Бухалын шуг

Training Topic/Сургалтын нэр

ХАНГАД ТОМХУЯНААС СЭРГИЙЛЭХ, ДАХЛАА САЙЖСРХУЛАХ ЦЭГЭН МАССАЖ

No	Name of trainee/ Суралцагчийн нэр	Position/ Албан тушаал	Company/ Компани	Signature/ Гарын үсэг
1	И. Доржиев	ХАББЭН	ERD	И. Доржиев
2	Р. Суртешев	үйс нэгж	МОНКИД	Р. Суртешев
3	Ц. Тхтмуу	үйс нэгж	<del>МОНКИД</del>	Ц. Тхтмуу
4	М. Урхивлал	үйс нэгж	МОНКИД	М. Урхивлал
5	Р. Мундуу	ОН	МОНКИД	Р. Мундуу
6	Р. Хамбаев	Калин. менежер	МОНКИД	Р. Хамбаев
7	Г. Батбаяр	Б.О. туслах	ERD	Г. Батбаяр
8	Эрдэнэ Баяр			
9	Шалзуул	сүлжээний оператор	Улаанбаатар	Шалзуул
10	Бат-Эрдэнэ	ТУСЛАХ	ERD	Бат-Эрдэнэ
11	Р. Тэнгэр	ТУСЛАХ	ERD	Р. Тэнгэр
12	Б. Доржиев	Б.О. туслах	ERD	Б. Доржиев
13	Б. Нямдорж	ТУСЛАХ	ERD	Б. Нямдорж
14	У. Сүхбаатар	АХЛАХ	Улаанбаатар	У. Сүхбаатар
15	Ц. Чорнобаев	ТУСЛАХ	ERD	Ц. Чорнобаев
16	Б. Доржиев	Туслах	Улаанбаатар	Б. Доржиев
17	О. Тхтмуу	ТУСЛАХ	ERD	О. Тхтмуу
18	Болорбаяр	оператор	Улаанбаатар	Болорбаяр
19	Доржпал	БОМ	ERD	Доржпал
20	Д. Сүхбаатар	ТУСЛАХ	ERD	Д. Сүхбаатар
21	Бат-Чин	PM	ERD	Бат-Чин
22	Н. Мөнхтөг	ТУСЛАХ	ERD	Н. Мөнхтөг
23	Мундуу	MT	ERD	Мундуу
24	Н. Доржиев	ТУСЛАХ	ERD	Н. Доржиев
25	Г. Доржиев	Г/Т	ERD	Г. Доржиев


Presenter Name/Сургалт явуулсан хүний нэр:  
 ...**Г. Бат-Эрдэнэ**...

Sign/Гарын үсэг: : ...**Г. Бат-Эрдэнэ**...

Date/Огноо: ...**2022.06.04**...

Signature/Гарын үсэг:  
 ...**Т.О.Г.**...

# Баянхөндий кемпийн бохирын ерөнхий схем



## Тайлбар:

50 м3 хүчин чадалтай тунгаагуурын ариутгах татуургын савыг 5м гүнд суурилуулж БХХ хоорондыг 150мм диаметртэй хоолойгоор дамжуулж гадуур нь дулаалга хийнэ. Хэрэглэгчээс гарч буй шугамыг 100мм диаметртэй хувицар хоолойгоор дамжуулж гадуур нь дулаалга хийнэ.

Шингэх талбайг уулын дайргаар дүүргэнэ.

<b>MONRUD LLC</b>		Баянхөндий кемпийн бохирын ерөнхий схем	
Урьдчилсан	Гэрийн өмчлөлтийн үйлчилгээ	Өмчлөгч	2018
Урьдчилсан	Монгол Улсын Засгийн газар	Хэрэглэгч	2018
Урьдчилсан	Баянхөндий кемпийн захирал	Хэрэглэгч	2018
Урьдчилсан	Баянхөндий кемпийн захирал	Хэрэглэгч	2018
Урьдчилсан	Баянхөндий кемпийн захирал	Хэрэглэгч	2018

	<b>АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ АНГИЛАХ, ЦУГЛУУЛАХ, ШИЛЖҮҮЛЭХ, ТЭЭВЭРЛЭХ ЖУРАМ</b>			
	Approved Батлагдсан огноо:	Date :	Revision Шинэчлэлт:	Policy developed by Журмыг боловсруулсан:
Policy # ___	10/05/2022	001	Р.Оюунбат Уул уурхайн хэлтэс	 Peter Akerley, CEO



ЭРДЭНЭ МОНГОЛ ХХК

## АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ АНГИЛАХ, ЦУГЛУУЛАХ, ШИЛЖҮҮЛЭХ, ТЭЭВЭРЛЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам”, БОАЖЯ-ын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг үндэслэсэн.

- 1.1. Энэхүү “Аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, шилжүүлэх, тээвэрлэх журам”-аар “Эрдэнэ Монгол” ХХК-ийн Баян хөндий төслийн үйл ажиллагаанаас үүсэх аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр багасгах, цуглуулах, ангилан ялгах, ангиллын дагуу аюултай хог хаягдлыг түр хадгалж, шилжүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2. Энэхүү журамд хэрэглэгдэх дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
  - 1.2.1. “Аюултай хог хаягдал” гэж тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдлыг;
  - 1.2.2. “аюултай хог хаягдал үүсгэгч” гэж үйл ажиллагаа болон үйлдвэрлэлээс нь аюултай хог хаягдал үүсдэг аж ахуйн нэгж, байгууллагыг;
  - 1.2.3. “аюултай хог хаягдал хүлээн авагч” гэж аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгчийг;



- 1.2.4. "аюултай хог хаягдал тээвэрлэгч" гэж аюултай хог хаягдлыг үүсгэгч болон өмчлөгчөөс тээврийн хэрэгслээр хүлээн авагчид хүргэх үйл ажиллагаа эрхлэгчийг;
- 1.2.5. "аюултай хог хаягдал хариуцсан ажилтан" гэж хэвийн болон аюул, осол гарсан үед аюултай хог хаягдалтай холбоотой үйл ажиллагааг зохицуулах ажилтныг;
- 1.2.6. "Хог хаягдлыг эх үүсвэр дээр бууруулах" гэж хог хаягдал бага үүсгэдэг, үр ашигтай, удаан хугацаанд ашиглах боломжтой бүтээгдэхүүн хэрэглэхийг;
- 1.3. Энэхүү журмыг "Эрдэнэ Монгол" ХХК болон төслийн талбайд ажиллаж буй туслан гүйцэтгэгч компани болон тэдгээрийн ажилтнууд нэгэн адил дагаж мөрдөнө.

#### **Хоёр. Хог хаягдлын үйл ажиллагаанд баримтлах зарчим**

- 2.1. Төслийн талбайд аюултай хог хаягдлын үйл ажиллагаатай холбогдуулан дараах зарчмыг баримтална. Үүнд:
  - 2.1.1. Аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь багасгах боломжийг бүрдүүлэх, эрэлхийлэх;
  - 2.1.2. Аюултай хог хаягдлыг ангилж, боломжтой тохиолдолд дахин ашиглахыг эрхэмлэх;
  - 2.1.3. Аюултай хог хаягдал үүсгэгч байгаль орчинд сөрөг нөлөөлөл учруулахгүй байх;
  - 2.1.4. Аюултай хог хаягдлын төрөл, кодыг жагсаалтын дагуу тогтоосон байх;
  - 2.1.5. Аюултай хог хаягдлыг дараах байдлаар ангилан ялгасан байх;
    - 1) Химийн бодисын сав баглаа боодол, химийн бодисоор бохирдсон материал
    - 2) Ашигласан тос, масло, техникийн тосны шүүр болон арчсан материал
    - 3) Хаягдал дугуй
    - 4) Аккумулятор
    - 5) Оффисоос гарах аюултай хог хаягдал /принтерын хор, батерей/
    - 6) Барилгын аюултай хог хаягдал
    - 7) Бусад аюултай хог хаягдал

#### **Гурав. Аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах**

- 3.1. Ил уурхайн засварын хэсэг, Боловсруулах үйлдвэр, Кэмп болон Лабораторийн хэсэг тус бүр дээр аюултай хог хаягдлыг ангилан, цуглуулах цэгүүдтэй байна.
- 3.2. Аюултай хог хаягдлын савыг суллаж онц хортой, тэсрэмтгий, шатамхай бодис тухайн бодисны шинж чанарт тохирсон уусмалаар саармагжуулан цэвэрлэсэн байна. Хоосон сав нь ЗГ-н 2018 оны 116-р тогтоолын 1-р хавсралтын 5.7-5.9-д заасан шаардлагыг хангасан байвал зохино.

- 3.3. Цуглуулах цэгүүд дэх аюултай хог хаягдлыг агуулах сав нь агуулж буй хог хаягдалтайгаа урвалд ордоггүй материалаар хийгдсэн, эсвэл ийм материалаар доторлосон байна.
- 3.4. Аюултай хог хаягдлыг хадгалах сав нэг бүр нь "Аюултай хог хаягдал" гэсэн нэр, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх бөгөөд ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, цуглуулж эхэлсэн хугацааг тэмдэглэсэн байна.
- 3.5. Цуглуулах цэгүүд дэх аюултай хог хаягдлын хэмжээний талаар бүртгэлтэй байна.
- 3.6. Цуглуулах цэгүүд дэх аюултай хог хаягдлыг 7 хоногт 1 удаа Аюултай хог хаягдал хадгалах байгууламж руу шилжүүлнэ.
- 3.7. Аюултай хог хаягдлыг нэр, төрөл, төлөв байдал, хэмжээг тэмдэглэсэн бичгийн хамт шилжүүлнэ.

#### **Дөрөв. Аюултай хог хаягдлыг түр хадгалах**

- 4.1. Түр хадгалах байгууламжид Ил уурхайн засварын хэсэг, Боловсруулах үйлдвэр, Кэмп болон Лабораторийн цуглуулах цэгүүдээс ирсэн аюултай хог хаягдлын тоо хэмжээ, төрөл, сав баглаа боодлын нийцсэн байдал болон бүрэн бүтэн байдлыг шалгаж хүлээн авна.
- 4.2. Цуглуулах цэгүүдээс аюултай хог хаягдлыг нэр, төрөл, төлөв байдал, хэмжээг тэмдэглэсэн бичгийн хамт түр хадгалах байгууламжид шилжүүлнэ.
- 4.3. Түр хадгалах байгууламж дах аюултай хог хаягдлыг агуулах сав нь агуулж буй хог хаягдалтайгаа урвалд ордоггүй материалаар хийгдсэн, эсвэл ийм материалаар доторлосон байна.
- 4.4. Аюултай хог хаягдлыг хадгалах сав нэг бүр нь "Аюултай хог хаягдал" гэсэн нэр, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх бөгөөд ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, цуглуулж эхэлсэн хугацааг тэмдэглэсэн байна.
- 4.5. Аюултай хог хаягдлыг түр хадгалах байгууламж нь аюултай хог хаягдлын шинж чанар, төрлөөс хамааран ангилж байршуулах зохион байгуулалттай байна.
- 4.6. Аюултай хог хаягдлыг түр хадгалах байгууламжид хадгалахдаа төрөлжүүлэн хадгална.
- 4.7. Аюултай хог хаягдлыг түр хадгалах байгууламжид дах аюултай хог хаягдлын хэмжээ болон шилжилт хөдөлгөөнийг бүтргэсэн бүртгэлтэй байна.
- 4.8. Аюултай хог хаягдлыг энгийн хог хаягдалтай хольсон тохиолдолд энэ хольцыг аюултай хог хаягдлын нэгэн адил зохицуулж, ангилна.
- 4.9. Түр хадгалах байгууламж дах аюултай хог хаягдлыг 180 хоног хадгална.
- 4.10. Аюултай шингэн хаягдлын савыг газраас тусгаарласан байдлаар байршуулж хадгална.

**Тав. Аюултай хог хаягдлыг шилжүүлэх, тээвэрлэх**

- 5.1. Аюултай хог хаягдлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас олгосон тээвэрлэх зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулж тээвэрлүүлнэ.
- 5.2. Аюултай хог хаягдал тээвэрлэгчдэд зориулалтын саванд савласан, "Аюултай хог хаягдал" гэсэн тэмдэг, тэмдэглэгээтэй, хог хаягдлыг дагалдах бичиг баримтын хамт хүлээлгэн өгнө.
- 5.3. Аюултай хог хаягдлыг шилжүүлэхдээ БОАЖЯСайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаалын 1-р хавсралтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг бүрдүүлж өгнө.
- 5.4. Аюултай хог хаягдлын тоо хэмжээ, төрөл аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ дагалдах бичгийг хавсаргана.
- 5.5. Аюултай хог хаягдлыг огноо, гарын үсэг бүхий хог хаягдлын үнэн зөв бөглөгдсөн бичгийг 3 хувь үйлдэн тээвэрлэгчдэд хүлээлгэн авна.
- 5.6. Тээвэрлэгч нь үүсгэгчээс хүлээн авсан аюултай хог хаягдлын бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг ханган тээвэрлэж, дагалдах бичигт заасан аж ахуйн нэгжид хүлээлгэж өгнө.
- 5.7. Тээвэрлэлт дууссаны дараа хүлээн авагчийн гарын үсэг зурж баталгаажуулсан хог хаягдлын дагалдах бичгийн 1 хувийг үүсгэгчид буцаан өгч, 1 хувийг өөртөө авна.
- 5.8. Тээвэрлэгч нь аюултай хог хаягдлын дагалдах бичгийн өөрт үлдсэн хувийг 10 жил хадгална.
- 5.9. Аюултай хог хаягдлыг тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавигдах ерөнхий шаардлагын стандартыг хангасан, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.
- 5.10. Аюултай хог хаягдал тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолооч нь тухайн ангилалд тохирох жолоодох эрхийн үнэмлэхтэй, аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан байна.
- 5.11. Тээвэрлэгч нь тээврийн хэрэгслийг аюултай хог хаягдал асгарах, алдагдах үед ашиглах багаж хэрэгсэл, материалаар хангах бөгөөд тээврийн хэрэгслийн жолооч нь тэдгээрийг ашиглах сургалтад хамрагдаж, зохих дадал эзэмшсэн байна.
- 5.12. Аюултай хог хаягдлыг тээврийн хэрэгсэлд ачиж, буулгахад дараах шаардлагыг мөрдөнө.
  - 5.12.1. Тээвэрлэлтийн явцад аюултай хог хаягдал унаж, асгарч, алдагдахгүй байхаар хөдөлгөөнгүй, жигд тархалттайгаар байршуулж тээвэрлэх;

- 5.12.2. том овортой сав, баглаа боодолтой аюултай хог хаягдлыг тээврийн хэрэгсэлтэй бат бөх бэхлэх, шингэн бодисын хувьд савалгааны дүүргэлтийг хазайх, тойрох үед тэнцвэр нь хадгалагдаж байхаар тохируулах;
- 5.12.3. аюултай хог хаягдалтай савны амыг дээш харуулж байрлуулах;
- 5.12.4. авто тээврийн хэрэгслээр зөвхөн өдрийн цагаар тээвэрлэх;
- 5.12.5. авто тээврийн хэрэгслийн хурдыг 50 км/цаг-аас хэтрүүлэхгүй байх;
- 5.12.6. цуваагаар явах тохиолдолд тээврийн хэрэгсэл хоорондын зайг хөдөлгөөний эрчим, тээврийн хэрэгслийн онцлог байдал, тээж яваа ачаа, замын болон цаг агаарын нөхцөл, хөдөлгөөний дагуу үзэгдэлтийг харгалзан уулын замд 300 метрээс багагүй, бусад замд 50 метрээс багагүй байхаар хурдыг сонгож явах.
- 5.12.7. Тээвэрлэгч нь асгарсан, алдагдсан хог хаягдлыг байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй түвшинд хүртэл цэвэрлэх арга хэмжээг авах бөгөөд уг арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг буруутай этгээд хариуцна.
- 5.12.8. Аюултай хог хаягдлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас олгосон боловсруулах, устгах зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулж шилжүүлнэ.

#### **Зургаа. Аюултай хог хаягдлын бүртгэл**

- 6.1. Үйл ажиллагааны хүрээнд үүсч буй аюултай хог хаягдлын хэмжээ, байршил, төрөл, тээвэрлэлтийн тухай мэдээллүүдийг Хог хаягдлын тухай хууль тогтоомж, холбогдох дүрэм журамд заасны дагуу бүртгэж, аюултай хог хаягдлын бүртгэлийн сан хөтлөх ба бүртгэлийг Аюултай хог хаягдал хариуцсан ажилтан хариуцна.

#### **Долоо. Хориглох зүйл**

- 7.1. Аюултай хог хаягдалтай холбоотой дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
  - 7.1.1. Аюултай хог хаягдлыг энгийн хог хаягдлын сав, талбайд хаях;
  - 7.1.2. Аюултай хог хаягдлыг цуглуулах болон түр хадгалах цэгээс бусад газар хадгалах
  - 7.1.3. Аюултай хог хаягдлыг устгах, булшлах, шатаах;
  - 7.1.4. Аюултай хог хаягдлыг нийцгүй саванд цуглуулах, хадгалах.

#### **Найм. Хариуцлага**

- 8.1. Энэхүү журмыг зөрчсөн ажилтан, албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол "Хөдөлмөрийн дотоод журам", тухайн ажилтантай байгуулсан "Хөдөлмөрийн гэрээ"-нд заасан хариуцлага хүлээлгэнэ.

- 8.2. Туслан гүйцэтгэгч компани, албан тушаалтан нь энэхүү журмыг зөрчсөн болох нь тогтоогдвол тус компанитай байгуулсан гэрээнд заасны дагуу хариуцлага ногдуулах ба буруутай ажилтанд хариуцлага хүлээлгэх талаар албан шаардлага хүргүүлнэ.
- 8.3. Журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

## АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ БҮРТГЭЛИЙН МАЯГТ

1. Эрдэнэ Монгол ХХК бүртгэлийн дугаар:.....
2. Хэсэг, нэгжийн нэр:.....
3. Аюултай хог хаягдал үүссэн хугацаа: .....
4. Үүсгэсэн аюултай хог хаягдлын мэдээлэл:

№	Код	Аюултай хог хаягдлын нэр	Үүссэн хэмжээ	Хэмжих нэгж
1				
2				
3				
4				
5				
6				
7				
8				

5. Аюултай хог хаягдал агуулахад шилжүүлсэн мэдээлэл:

№	Код	Аюултай хог хаягдлын нэр	Шилжүүлсэн хэмжээ	Хэмжих нэгж
1				
2				
3				
4				
5				
6				
7				
8				

6. Тайлан гаргасан албан тушаалтны мэдээлэл:

Гарын үсэг /тамга/	Овог нэр, албан тушаал	Огноо

## АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ

Дагалдах бичгийн дугаар .....

*/ шаардлагатай тохиолдолд нэмэлт хуудас хэрэглэнэ. /*

<b>1. Үүсгэгчийн талаарх мэдээлэл:</b>								
Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар:								
Аюултай хог хаягдал үүсгэгч байгууллагын нэр: .....								
<b>2. Аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгсөн:</b>								
Овог нэр	Албан тушаалтан	Гарын үсэг:	Огноо:					
.....	.....	.....	..... он ..... сар.....өдөр					
<b>3. Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл:</b>								
1/ Тээврийн хэрэгслийн улсын дугаар: ..... Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар:.....								
Тээвэрлэгч аж ахуйн нэгжийн нэр: .....								
<b>4. Аюултай хог хаягдлын талаарх мэдээлэл:</b>								
	Аюултай хог хаягдлын нэр	Аюулын ангилал	Савлагааны бүлэг	Савны		Хэмжээ	Нэгж /кг, л, ш/	Аюултай хог хаягдлын код
				дугаар	Төрөл			
1								
2								
3								
4								
<b>5. Тээвэрлэх үед анхаарах нэмэлт зааварчилгаа, мэдээлэл:</b>								
<b>6. Аюултай хог хаягдлыг хүлээн авсан тээвэрлэгч :</b>								
1. Овог нэр:..... Гарын үсэг:..... Он ..... сар.....өдөр								
<b>7. Үл зохицол:</b>								
<b>8. Аюултай хог хаягдлыг хүлээн авагчийн талаарх мэдээлэл:</b>								
Аж ахуйн нэгжийн нэр:								
Бүртгэлийн дугаар:								
<b>Аюултай хог хаягдлыг хүлээн авсан:</b>								
Овог нэр :	Албан тушаал	Гарын үсэг/ тамга /				Огноо		
.....	.....	.....				20 он .... сар ... өдөр		

## АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ҮҮСГЭГЧИЙН ТАЙЛАНГИЙН МАЯГТ

7. Тайлангийн жил: .....
8. Бүртгэлийн дугаар: .....
9. Аж ахуйн нэгжийн нэр:.....
10. Аж ахуйн нэгжийн бүртгэлийн дугаар:.....
11. Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: .....
12. Аж ахуйн нэгжийн хаяг:

Аймаг/хот:

Сум/дүүрэг:

Баг/хороо:

Гудамж,

дугаар:.....

13. Үүсгэсэн аюултай хог хаягдлын мэдээлэл /шаардлагатай бол нэмэлт хуудас хэрэглэ/

№	Код	Аюултай хог хаягдлын нэр	Үүссэн хэмжээ	Хэмжих нэгж
1				
2				
3				
4				
5				

14. Аюултай хог хаягдлаа тээвэрлүүлсэн тээвэрлүүлэгчийн мэдээлэл:

№	Тээвэрлэгч аж ахуйн нэгжийн нэр	Бүртгэлийн дугаар			
		Т			
1		Т			
2		Т			
3		Т			
4		Т			

15. Аюултай хог хаягдлаа устгуулсан байгууллагын мэдээлэл:

№	Аж ахуйн нэгжийн нэр	Бүртгэлийн дугаар	Үүссэн хэмжээ	Хэмжих нэгж
1				
2				

16. Үүссэн аюултай хог хаягдлаа дотооддоо дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа явуулдаг бол:

№	Код	Хэмжээ	Хэмжих нэгж	Устгасан, боловсруулсан арга
1				
2				
3				

17. Тайлан гаргасан албан тушаалтны мэдээлэл:

Гарын үсэг /тамга/	Овог нэр, албан тушаал	Огноо







“ХАЙ БИ ОЙЛ” ХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

“ЭРДЭНЭ МОНГОЛ” ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



PETER AKERLEY

## АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

2022 оны 07-р сарын 01-ны өдөр

№ АХХ/ 22/17

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа 2615134 тоот регистрийн, 90100011063 тоот улсын бүртгэлийн дугаартай “Хай Би Ойл” ХК-г төлөөлж менежер ажилтай Л.Даваагэрэл, нөгөө талаас Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа 2718243 тоот регистр, 9019005124 тоот улсын бүртгэлийн дугаартай “Эрдэнэ Монгол” ХХК-ийн Байгаль Орчны мэргэжилтэн ажилтай Э.Өнөрзаяа нар дор дурдсан зүйлийг харилцан тохиролцсоны үндсэн дээр Монгол Улсын Иргэний /380-397/ хууль, Хог хаягдлын тухай хуулийн /Дөрөвдүгээр бүлэг, Хоёр дугар бүлэг 10 дугаар зүйл, Тавдугаар бүлэг/ холбогдох зүйл заалтыг баримтлан энэхүү Аюултай хог хаягдал буюу техникийн ажилласан тос хүлээн авч тээвэрлэх гэрээг байгуулав.

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ,

- 1.1 Энэхүү гэрээгээр “Хай Би Ойл” ХК болон “Эрдэнэ Монгол” ХХК-ийн уурхайн засвар үйлчилгээний төв /цаашид ЗҮТ гэх/ гэрээнд заасан хугацаанд машин механизмын, тоног төхөөрөмжийн, хөдөлгүүрийн, гидрийн болон моторын тосыг солих үед гарах техникийн хаягдал тос буюу аюултай хог хаягдал /цаашид ”АХХ” гэх/-г хүлээн авах, түүнийг тээвэрлэх болон бусад холбогдох харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү гэрээ нь талуудын хооронд хийгдсэн тохиролцоонуудыг агуулж байгаа бөгөөд энэхүү гэрээнд тодорхой байдлаар тусгаж оруулсан заалтуудыг оролцуулахгүйгээр Үйлчилгээтэй холбоотой хэлцэл, мэдэгдэл, аман болон бичгээр хийсэн тохиролцоог энэхүү гэрээ орлож байгаа болно.
- 1.3 Энэхүү гэрээнд өөрөөр заагаагүй бол түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, хоёр тал гарын үсэг зураагүй бол тэдгээрийг хүчин төгөлдөр бус гэж үзнэ.

### ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1 Энэхүү гэрээ нь “Хай Би Ойл” ХК болон “Эрдэнэ Монгол” ХХК-ийн ЗҮТөвийн төлөөлөлүүд гарын үсэг зурснаар 2023 оны 12 сарын 31 -ний өдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.



- 2.2 Гэрээнд оролцогч талууд Монгол Улсын Иргэний хуульд зааснаар гэрээний үүргээ бүрэн буюу хэсэгчлэн биелүүлээгүй гэж үзсэн тохиолдолд гэрээг дуусгавар болгохыг санал болгох эрхтэй.
- 2.3 Гэрээний хугацаа дуусгавар болоход талууд гэрээг үргэлжлүүлэх эсэх талаар харилцан мэдэгдэж зөвшилцөнө.
- 2.4 Энэхүү гэрээний нөхцөл, болзол, заалтаас татгалзан дуусгавар болгох тухай санал, шалтгааныг талууд зөвхөн албан бичгээр тайлбарлан гаргана.

### ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 Талууд бие биенээсээ энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, хэрэгжүүлэхийг шаардах бүрэн эрхтэй.
- 3.2 Талууд аюултай хог хаягдал /цаашид АХХ гэх/-г юүлэх, зөөх, тээвэрлэх, машинд ачиж буулгах зэрэг АХХ-г хөдөлгөх тухай бүрт хариуцлагатай байж, ажлын болон агуулахын талбай, газар шороо, байгаль орчинг бохирдуулахгүй байхад шаардлагатай арга хэмжээг авч хяналт тавьж ажиллах үүрэгтэй.
- 3.3 АХХ буюу техникийн хаягдал тосыг “Эрдэнэ Монгол” ХХК-ийн ЗҮТөв нь ямар нэг биет хог /эрэг, боолт, төмөр, чулуу, хуванцар, даавуу, гялгар уут гэх мэт/, механик хольц болон хөргөлтийн шингэн /тосол/, хурдны хайрцагны тос /АКТ/-ны хольцгүйгээр аль болох нэг төрлөөр цуглуулж хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 3.4 “Хай Би Ойл” ХК нь “Эрдэнэ Монгол” ХХК-ийн ЗҮТөвийн цуглуулан ангилж буй АХХ буюу техникийн хаягдал тосны чанарын асуудлаар АХХ үүсгэгч талд бичгээр шаардлага хүргүүлэх эрхтэй.
- 3.5 “Хай Би Ойл” ХК нь АХХ-н тээвэрлэлт, аюулгүй ажиллагаа, ачилтын асуудалд үүсэх эрсдлийг хариуцаж, АХХ үүсгэгчийн талбайгаас өөрийн техникээр тээвэрлэн АХХ-ын цуглуулгын цэг рүү тээвэрлэх үүрэгтэй.
- 3.6 “Хай Би Ойл” ХК нь ачих, тээвэрлэх үедээ хөдөлмөр аюулгүй ажиллагааг сайтар ханган ажиллах ба аюулгүй ажиллагааг хангаагүйгээс үүдэн “Эрдэнэ Монгол” ХХК болон бусад гуравдагч этгээдэд хохирол учруулбал бие даан хариуцан барагдуулна.
- 3.7 Энэхүү гэрээний дагуу өгөх шаардлагатай эсхүл өгөхийг зөвшөөрсөн аливаа мэдэгдлийг бичгээр үйлдэх бөгөөд түүнийг биесчлэн хүргүүлэх эсхүл доор заасан цахим шуудангийн хаягаар илгээсэн тохиолдолд аливаа мэдэгдлийг хүлээж авснаа талууд бичгээр хариу мэдэгдэх үүрэгтэй.
- 3.8 “Хай Би Ойл” ХК АХХ үүсгэгчээс тээвэрлэгдэн ирсэн энэхүү гэрээний 3.3 заалтын дагуу АХХ-ыг тохирох эсэхийг өөрийн лабораторт судалж, шинжилсний үндсэн дээр шалган авах эрхтэй.
- 3.9 Энэхүү гэрээ байгуулсантай холбогдон олж авсан талуудтай холбоотой мэдээлэл, баримтын нууцлалыг гэрээ байгуулснаас хойш хоёр тал хугацаагүйгээр чанд хадгалах бөгөөд аль нэг тал нөгөө талд зөвшөөрөл олгосон эсвэл хууль тогтоомжийн дагуу шаардсанаас бусад тохиолдолд аливаа гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй байх, гэрээнд заагдаагүй зорилгоор ашиглахгүй байх үүрэгтэй.
- 3.10 “Эрдэнэ Монгол” ХХК-ийн тээвэрлүүлсэн техникийн хаягдал тос буюу аюултай хог хаягдлыг хүлээн авснаар бүх эрсдэл, хариуцлага “Хай Би Ойл” ХК-д шилжинэ. Хүлээн авсан аюултай хог хаягдлыг “Хай Би Ойл” ХК нь хэрхэн ашиглах, ашигласан нь “Эрдэнэ Монгол” ХХК-нд үл хамаарна.
- 3.11 “Хай Би Ойл” ХК нь “Эрдэнэ Монгол” ХХК-иас хүлээн авсан хаягдал тосыг байгаль орчинд ээлтэйгээр дахин боловсруулна.

## **ДӨРӨВ. ТЭЭВЭРЛЭЛТИЙН ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ**

- 4.1 “Эрдэнэ Монгол” ХХК нь ЗҮТөвөөс бэлтгэн нийлүүлж буй шаардлагыг хангасан техникийн хаягдал тос (АХХ)-ыг ямар нэгэн төлбөрийн нөхцөлгүйгээр “Хай Би Ойл” ХК-д нийлүүлнэ. Бэлтгэн нийлүүлсэн АХХ-ын хэмжээг талуудын хүлээлгэн өгсөн болон хүлээн авсан ажилтны гарын үсгээр баталгаажсан санхүүгийн анхан шатны баримтын бичилтийг үндэслэн тогтооно.
- 4.3 “Эрдэнэ Монгол” ХХК-ийн бэлтгэн нийлүүлсэн АХХ-н хэмжээгээр улиралд тооцоо нийлүүлж “Хай Би Ойл” ХК нь Байгаль Орчны Яаманд мэдээлдэг мэдээ тайландаа тусгаж тайлагнана.

## **ТАВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ**

- 5.1 Ямар ч тохиолдолд аль нэг тал түүний хяналтаас гарсан аливаа шалтгаан, нөхцөл байдлын улмаас шууд эсхүл шууд бус байдлаар, бүхэлд нь эсхүл хэсэгчлэн энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй, үүргийн биелэлт нь хойшлогдсон тохиолдолд нөгөө талын өмнө хариуцлага хүлээхгүй.
- 5.2 Тийм шалтгаан, нөхцөл байдалд: гал түймэр, үер, ажил хаялт, үймээн, хорлон сүтгэх ажиллагаа, дэлбэрэлт, цаг уурын сөрөг нөхцөл, зайлсхийх боломжгүй золгүй явдал, ажиллах хүч, материал, тээвэр эсхүл үйлчилгээ олдхоггүй байх, давагдашгүй хүчин зүйлс эсхүл дайсагнагч улсын үйл ажиллагаа, нөгөө талын үйлдэл, шүүхийн шийдвэр, тушаал, тогтоол эсхүл Засгийн газрын эрх бүхий байгууллагын журам эсхүл зөвшөөрлийг алдах явдал бөгөөд энэ бүхэн аль ч талын үйлдэлд үндэслэгдээгүй байх ёстой.
- 5.3 Дээрхээс шалтгаалах ажил зогсоолт эсхүл энэ гэрээний дагуу үзүүлэх үйлчилгээний гүйцэтгэл тасалдсаны улмаас цаг хугацааны хувьд хойшлогдох асуудлыг аль болох яаралтай засаж залруулна.

## **ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ**

- 6.1 Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж, талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 6.2 Энэхүү гэрээнд заасан хэлцлүүд хэрэгжсэн эсэхийг үл харгалзан гэрээнд тусгагдсан болон гэрээг бэлтгэх, хэрэгжүүлэх үед гэрээнд оролцогч талуудын зүгээс гарсан аливаа зардлыг талууд өөр өөрсдөө хариуцна.

## **ДОЛОО. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ**

- 7.1 Талууд харилцагч талынхаа бизнесийн нэр хүндийг хүндэтгэж, тэгш эрхийн зарчимд тулгуурлан ажиллана.
- 7.2 Талууд гэрээний хугацаанд харилцан ашигтай, найрсаг байдлаар хамтран ажиллаж аливаа маргааныг зөвшилцлийн замаар шийдвэрлэх бөгөөд хэрэв тодорхой зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хуулийн дагуу харьяалагдах шүүхээр шийдвэрлүүлнэ.

**ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:**

**ХҮЛЭЭН АВАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:**

“Хай Би Ойл” ХК-ийн


Менежер Л.Даваагэрэл

  
/гарын үсэг/

**НИЙЛҮҮЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:**

“Эрдэнэ Монгол”ХХК-ийн

Байгаль орчны мэргэжилтэн Э.Өнөрзаяа

  
/гарын үсэг/

**ТАЛУУДЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ:**

Монгол улс, Улаанбаатар хот,  
Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо,  
Сонсголонгийн /18135/,Товчооны зам 59  
тоот  
Утас: 8811 9740, 8801 0277  
Цахим шуудан:  
ganchimeg@hboil.mn

Монгол улс, Улаанбаатар хот,  
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу гудамж,  
Монруд ХХК-ийн байр  
Утас: 88099905  
Цахим шуудан:

unurzaya@erdene.com

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын  
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав



# МОНГОЛ УЛС УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2007.12.27  
*/Бүртгэсэн он, сар, өдөр/*

9010001063  
*/Улсын бүртгэлийн дуагар/*

2615134  
*/Регистрийн дуагар/*

Хай Би Ойл

Хувьцаат компани

*/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр/*

**Дүрэм**

*/Үүсэн байгуулах баримт бичиг/*

Гэгтгөл  
*/Илдэврийн нэр/*

41  
*/дугаар/*

2007.06.29  
*он, сар, өдөр*

411000  
*лого*

Гядаад худалдаа  
*/Үүсэн зөвлөх үйл ажиллагааны чиглэл/*

4000

*/Үүсгэх зөвлөх үйл ажиллагааны чиглэл/*

Хугацаагүй  
*хугацаа*

34  
*/жишүүдийн тоо/*

500,000.0  
*/өрийн хөрөнгийн хэмжээ, мянган тогтоогоор/*

Сүхбаатар дүүрэг, 9-р хороо, 7-р хороолол, 31 - 31 утас:1.323552, утас:99098089, факс:

*/Хуулийн этгээдийн албан өсны хаяв/*



Улсын бүртгэлийн алба

*/Бүртгэсэн байдгуулагын нэр/*

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ,  
ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
**ЗӨВШӨӨРӨЛ**

Дугаар 0000009

Огноо: 2020.07.01

Хавсралт 1 -д заасан нөхцлийн дагуу аюултай хог хаягдал  
Авто тээврээс гарч буй ашигласан тосыг тээвэрлэх, цуглуулах  
хадгалах, дахин боловсруулах 9010001063 үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг  
2615134 улсын бүртгэлийн дугаартай

регистрийн дугаартай "Хай Би Ойл" ХК -д 2020 оны 06 дугаар сарын 29 -ны  
өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 29 -ны өдөр 5 жилийн хугацаагаар олгов.

**Үйл ажиллагаа эрхлэх талаарх мэдээлэл:**

Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа  
эрхлэгчийн бүртгэлийн дугаар 0000009

Аж ахуйн нэгж/иргэний хаяг: Улаанбаатар аймаг, хот Сонгинохайрхан  
20-р сум, дүүргийн Үйлдвэрлэл нүүрсний газрын урд  
баг, хорооны Улаанбаатар

Зөвшөөрөл олгосон үйл ажиллагаа явуулах газрын байршил: Улаанбаатар  
аймаг, хот Сонгинохайрхан сум, дүүргийн 20-р

баг, хорооны Үйлдвэрлэл нүүрсний газрын урд  
(газрын нэр/гудамжны нэр, дугаар)

**Хавсралт нь энэхүү зөвшөөрлийн салшгүй нэг хэсэг болно.**

**Зөвшөөрөл олгосон:**

**БОАЖ-ын сайд**

(байгууллагын нэр, албан тушаал)



(гарын үсэг, тамга)

**Н.Цэрэнбат**

(овог нэр)



# ХОГ ХАЯГДЛЫН ЖУРАМ

ERD | MSE:ERDN

Бүх ажилчдад зориулав.





# Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан хаяна.



ХҮНСНИЙ ОРГАНИК  
ХОГ ХАЯГДАЛ



## Хог хаягдал гэж юу вэ?



- 4.1.1.“хог хаягдал” гэж өмчлөгч этгээд хэрэглэхгүй болсон эд юмс, материалыг;
- 4.1.2.“аюултай хог хаягдал” гэж тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдлыг;
- 4.1.3.“энгийн хог хаягдал” гэж аюултай хог хаягдлаас бусад хог хаягдлыг;
- 4.1.4.“ахуйн хог хаягдал” гэж айл өрхөөс гарах энгийн хог хаягдлыг;
- 4.1.7.“хог хаягдал ангилах” гэж хог хаягдлыг дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах, шатаах, устгах, булшлах зорилгоор төрөлжүүлэн ялгахыг;
- 4.1.27.“дахивар нөөц” гэж дахин ашиглагдах, дахин боловсруулах, сэргээн ашиглагдах хог хаягдлыг;

## Ням гараг бүр



*Хээрийн ангийн ойр  
орчимд цэвэрлэгээг  
тогтмол хийнэ.*

# Хог хаягдлын менежмент



# Saving water in the bathroom



Turn off  
tap while  
brushing  
teeth

Take  
shorter  
baths



Turn off  
tap while  
applying  
soap

Turn off  
tap after  
each use



Don't flush tissue paper  
or waste into the toilet




---

 [www.erdene.com](http://www.erdene.com)

 [ErdeneRes](#)

 [ErdeneResource](#)

 [Erdene Resource Development](#)

 [Erdene Resource Development Corp.](#)

---

## ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

ЗАХИАЛГА №: 2022/1521

ЗАХИАЛГАЧИЙН НЭР: ЭРДЭНЭ МОНГОЛ ХХК

ДЭЭЖИЙН ТӨРӨЛ, ТОО:

Хөрс, 6

№	ЛАБОРАТОРИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ	ЭЛЕМЕНТ, %						ЭЛЕМЕНТ, мг/кг					
				Al*	Ca	Mg	K	Fe <sub>снiтr</sub>	As	Ba*	Be	Bi	Cd		
1	Л-16260	SHMP-01	Хөрс	7.53	4.13	1.07	2.35	3.27	28.33	634.1	<5.0	<10.0	<1.0		
2	Л-16261	SHMP-02	Хөрс	5.99	2.44	0.76	2.26	3.93	28.37	620.7	<5.0	<10.0	<1.0		
3	Л-16262	SHMP-03	Хөрс	5.54	2.06	0.55	2.08	3.75	31.17	642.5	<5.0	<10.0	<1.0		
4	Л-16263	SHMP-04	Хөрс	9.10	2.83	0.87	2.22	3.39	23.42	699.5	<5.0	<10.0	<1.0		
